

ЭМНЕСТИ

ИНТЕРНЭШНЛИЙН

ТАЙЛАН 2021/22

**ДЭЛХИЙ ДАХИНЫ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**



**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



Эмнести Интернэшнл нь хүн бүрт эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө бид ажилладаг.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал, эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс ангид бие даасан, хараат бүс бөгөөд гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг. хүмүүс эв санааны нэгдэлтэй, хүмүүнлэг энэрэнгүй байснаар илүү сайхан нийгмийг бий болгож, өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.

© Эмнести Интернэшнл 2022

Энэ баримт бичгийн агуулга нь Creative Commons лицензийн дагуу лицензтэй болно. (attribution, non-commercial, no derivatives, international 4.0)

<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб сайтын зөвшөөрлийн хуудас руу

орж авна уу:

www.amnesty.org

Хэрэв материалыг Эмнести Интернэшнлээс бусад зохиогчийн эрхийн эзэмшигчид хамааруулсан бол энэхүү материал нь Creative Commons лицензэд хамаарахгүй болно.

Эмнести Интернэшнлээс 2022 онд анх хэвлүүлсэн

Peter Benenson House, 1 Easton Street, London WC1X 0DW, UK

Индекс: POL 10/4870/2022

ISBN: 0-86210-505-6

Эх хэл: Англи

amnesty.org

amnesty.mn

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ: ГУРВАН ГОЛ ЧИГ ХАНДЛАГА

Эрүүл мэнд ба тэгш бус байдал	6
Иргэний орон зай	11
Умардын орнууд дүрвэгсэд болон цагаачдыг хүчээр буцааж байна	13
Зөвлөмж	15

АФРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Хууль бус халдлага ба аллага	17
Ял завших явдал	19
Эдийн засаг, нийгэм, соёлын эрх	19
Эрүүл байх эрх	19
Боловсрол эзэмших эрх	20
Орон байртай байх эрх	21
Өөрөөр сэтгэгчдийг нухчин дарсаар	21
Жагсаал цуглаан ба хүч хэтрүүлэн хэрэглэх	21
Хүний эрх хамгаалагчид ба эвлэлдэн нэгдэх эрх чөлөө	21
Хэвлэл мэдээллийн эрх чөлөө	22
Дүрвэгсэд, цагаачид, дотооддоо шилжин суурьшигчдын хүний эрх	22
Ялгаварлан гадуурхалт ба шоовдорлолт	23
Эмэгтэйчүүд, охидын эрх	23
Альбинизмтай хүмүүс	23
ЛГБТИ хүмүүсийн эрх	24
Уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн буй орчны доройтол	24
Зөвлөмж	25

АМЕРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Эдийн засаг, нийгэм, соёлын эрх	28
Эрүүл мэндийн эрх	27
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх	28
Уугуул иргэдийн эрх	28
Үзэл бодлоо илэрхийлэх болон хуран чуулах эрх чөлөө	29
Хүч хэтрүүлэн хэрэглэх	30
Хүний эрхийн хамгаалагчид	31
Ял завших явдал болон шударга ёсыг тогтоох	31
Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл	32
ЛГБТИ хүмүүсийн эрх	32
Дүрвэгсэд болон цагаачдын эрх	33
Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлж чадсангүй	33
Зөвлөмж	34

АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Өөрөөр сэтгэгчдийг нухчин дарсаар	35
Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	36

Хуран чуулах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө	37
Хүний эрх хамгаалагчид	38
Эрүүл мэндийн эрх	38
Ажилчдын эрх	39
Дүрвэгсэд болон цагаачдын эрх	40
Эмэгтэйчүүд, охидын эрх	40
ЛГБТИ хүмүүсийн эрх	41
Уугуул иргэдийн эрх	41
Олон улсын эрх зүйн гэмт хэрэг	42
Эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрээр зүй бус харьцах	42
Ял завших	42
Зөвлөмж	43
ЕВРОП БА ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	44
Төр эрх мэдлээ өргөжүүлсээр	44
Шүүхийн хараат бус байдал алдагдсаар	45
Үзэл бодлоо илэрхийлэх, хуран чуулах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө	45
Хүний эрх хамгаалагчид	47
Дүрвэгсэд болон цагаачдын эрх	48
Ялгаварлан гадуурхалт	48
Цыган хүмүүс	49
ЛГБТИ хүмүүсийн эрх	49
Эмэгтэйчүүдийн эрх	49
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх	49
Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл	49
Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын эрх	50
Хямрал мөргөлдөөний бүс дэх хүний эрх	50
Уур амьсгалын хямралын эсрэг арга хэмжээ хангалтгүй байна	51
Улс орны дотоодын болон дэлхий даяарх хүний эрх	52
Зөвлөмж	52
ОЙРХ ДОРНОД, ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ	54
Эрүүл байх эрх	54
Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө	55
Хувийн нууцтай байх эрх	56
Хүний эрх хамгаалагчид ба эвлэлдэн нэгдэх эрх чөлөө	56
Жагсаал цуглаан ба хууль бус хүч хэрэглэх	57
Хоригдлуудын эрх	58
Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах	58
Цаазаар авах ял	58
Ял завших явдал	59
Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл	59
Зэвсэгт мөргөлдөөн	60
Дүрвэгсэд, дотоодын шилжин суурьшигчдын эрх	60
Ажилчдын эрх	61
Эмэгтэйчүүд, охидын эрх	61
ЛГБТИ хүмүүсийн эрх	62
Шашны болон үндэстний цөөнхүүд	62
Зөвлөмж	63

ASEAN –ACEAH

Association of Southeast Asian Nations
- Зүүн өмнөд Азийн орнуудын хамтын
нийгэмлэг

AU –AX

African Union -Африкийн холбоо

CEDAW –ЭАБХУК

UN Convention on the Elimination of All
Forms of Discrimination against Women
- НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх
хэлбэрийг устгах тухай конвенц

CEDAW Committee –ЭЭЯГУ Хороо

UN Committee on the Elimination of
Discrimination against Women - НҮБ-
ын Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан
гадуурхалтыг устгах хороо

CERD –АӨАБХУОУК

International Convention on the
Elimination of All Forms of Racial
Discrimination - Арьс өнгөөр алагчлах
бүх хэлбэрийг устгах тухай олон улсын
конвенц

CERD Committee –АӨАҮУ хороо

UN Committee on the Elimination of
Racial Discrimination- НҮБ-ын Арьс
өнгөөр алагчлах үзлийг устгах хороо

CIA –ТТГ

US Central Intelligence Agency - АНУ-ын
Тагнуулын төв газар

COVAX–КОВАКС

Covid-19 Vaccines Global Access, directed
by the GAVI vaccine alliance, CEPI
and the WHO – Тархварзүйн бэлэн
байдлын шинэчлэлийн холбоо (CEPI),
Вакцин дархлаажуулалтын глобал
альянс (GAVI), Дэлхийн эрүүл мэндийн
байгууллага (ДЭМБ)-ын удирддаг
Ковид-19 вакцины дэлхийн хүртээмж
хөтөлбөр

Covid-19 –Ковид–19

Coronavirus disease-19 -Коронавирусын
халдварт өвчин -19

ECOWAS –БАУЭЗХН

Economic Community of West African
States- Баруун Африкийн улсуудын
эдийн засгийн хамтын нийгэмлэг

EU –EX

European Union -Европын холбоо

**European Committee for the
Prevention of Torture – Эрүүдэн
шүүхээс урьдчилан сэргийлэх
Европын хороо**

European Committee for the Prevention
of Torture and Inhuman or Degrading
Treatment or Punishment - Эрүүдэн
шүүх, хүнлэг бусаар буюу нэр төрийг
доромжлон харьцах, шийтгэхээс
урьдчилан сэргийлэх Европын хороо

**European Convention on Human
Rights– Европын Хүний эрхийн
конвенц**

(European) Convention for the Protection
of Human Rights and Fundamental
Freedom - Хүний эрх, үндсэн эрх чөлөөг
хамгаалах Европын конвенц

GDP –ДНБ

Gross domestic product - Дотоодын
нийт бүтээгдэхүүн

ICC –ОУЭШ

International Criminal Court - Олон
улсын Эрүүгийн Шүүх

ICCPR –ИУТЭОУП

International Covenant on Civil and
Political Rights - Иргэний Болон Улс
Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пакт

ICESCR–ЭЗНСЭОУП

International Covenant on Economic,
Social and Cultural Rights - Эдийн Засаг,
Нийгэм, Соёлын Эрхийн Тухай Олон
Улсын Пакт

ICRC –ОУУЗХ

International Committee of the Red Cross
- Олон улсын Улаан Загалмайн Хороо

ILO –ОУХБ

International Labour Organization- Олон
улсын Хөдөлмөрийн Байгууллага

**International Convention against
Enforced Disappearance – Хүчээр
Алга Болгохын эсрэг Олон Улсын
Конвенц**

International Convention for the
Protection of All Persons from Enforced
Disappearance - Хүчээр Алга Болгохоос
Бүх Хүнийг Хамгаалах тухай Олон
Улсын Конвенц

LGBTI –ЛГБТИ

Lesbian, gay, bisexual, transgender and
intersex - Лесбиян, гей, бисексуал,
трансгендер, интерсекс

MP –УИХ-ын гишүүн

Member of Parliament - Улсын Их
Хурлын Гишүүн

NATO –НАТО

North Atlantic Treaty Organization -
Умард Атлантын Гэрээний Байгууллага

NGO –ТББ

Non-governmental organization- Төрийн
бус байгууллага

OAS –АУБ

Organization of American States-
Америкийн улсуудын байгууллага

ОСНА –ХЭЭГ

United Nations Office for the
Coordination of Humanitarian Affairs
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Хүмүүнлэгийн Хэрэг Эрхлэх Газар

ОНСНР –ХЭДКГ

Office of the United Nations High
Commissioner for Human Rights - НҮБ-
ын Хүний Эрхийн Дээд Комиссарын
Газар

OSCE –ЕАБХАБ

Organization for Security and Co-
operation in Europe - Европын Аюулгүй
Байдал, Хамтын Ажиллагааны
Байгууллага

PPE –XXX

Personal protective equipment - Хувийн
хамгаалах хэрэгсэл

TRIPS –ОӨЭХАХ

Trade-Related Aspects of Intellectual
Property - Оюуны Өмчийн Эрхийн
Худалдааны асуудлаарх Хэлэлцээр

UK –ИБ

United Kingdom - Их Британи /Их
Британи Умард Ирландын Нэгдсэн Вант
Улс/

UN –НҮБ

United Nations - Нэгдсэн Үндэстний
Байгууллага

**UN Convention against Torture – НҮБ-
ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц**

Convention against Torture and Other
Cruel, Inhuman or Degrading Treatment
or Punishment - Эрүүдэн Шүүх болон
бусад Хэлбэрээр Хэрцгий, Хүнлэг
бусаар буюу Хүний Нэр Төрийг
Доромжлон Харьцаж, Шийтгэхийн
Эсрэг Конвенц

**UN Refugee Convention – НҮБ-ын
Дүрвэгсдийн тухай конвенц**

Convention relating to the Status of
Refugees - Дүрвэгсдийн Эрх зүйн
байдлын тухай Конвенц

**UN Special Rapporteur on extrajudicial
executions – НҮБ-ын хууль бусаар
цаазаар авах ялын асуудал
хариуцсан Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on extrajudicial,
summary or arbitrary executions - НҮБ-
ын хууль бусаар, дур мэдэн, олноор
цаазаар авах асуудал хариуцсан Тусгай
илтгэгч

**UN Special Rapporteur on extreme
poverty – НҮБ-ын нэн ядуурлын
асуудал хариуцсан Тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on extreme
poverty and human rights - НҮБ-ын
нэн ядуурал ба хүний эрхийн асуудал
хариуцсан Тусгай илтгэгч

**UN Special Rapporteur on freedom
of expression – НҮБ-ын Үзэл
бодлоо илэрхийлэх эрх чөлөөний
асуудлаарх тусгай илтгэгч**

UN Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression - НҮБ-ын үзэл санаа, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, хамгаалах асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on racism- НҮБ-ын Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on contemporary forms of racism, racial discrimination, xenophobia and related intolerance- НҮБ-ын Ялгаварлан гадуурхах, арьс өнгөөр алагчлах, жигших, үл тэвчих орчин үеийн хэлбэрийн асуудлаарх Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on torture - НҮБ-ын эрүүдэн шүүхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment - НҮБ-ын эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудал Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on toxics and human rights - НҮБ-ын Хорт бодис ба хүний эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on the implications for human rights of the environmentally sound management and disposal of hazardous substances and wastes - НҮБ-ын Аюултай бодис, хог хаягдлыг байгаль орчинд ээлтэйгээр устгах менежмент, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special Rapporteur on violence against women - НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UN Special rapporteur on violence against women, its causes and consequences

- НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний шалтгаан, үр дагаврын асуудал хариуцсан Тусгай илтгэгч

UNHCR, the UN refugee agency – ДАЭДКГ, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссар
Office of the United Nations High Commissioner for Refugees - НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал Эрхэлсэн Дээд Комиссарын Газар

UNICEF- ЮНИСЕФ

United Nations Children's Fund - НҮБ-ын Хүүхдийн сан

UPR -ЭДХ

UN Universal Periodic Review -НҮБ-ын Ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг

USA -АНУ

United States of America - Америкийн нэгдсэн улс

WHO -ДЭМБ

World Health Organization - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ӨМНӨХ ҮГ

2021 онд улс төрийн эрх мэдэл дор хүмүүсийн амьдрал ямаршуухан байв?

Ашиг хонжоо, эрх ямба, албан тушаалын төлөөх утгагүй өрсөлдөөн дунд дэлхий даяар хүний эрх илүү сайн хангагдаж чадсан уу? Ковид-19 цар тахал үргэлжилж, хямрал мөргөлдөөн улам бүр гүнзгийрсэн энэ цаг үед эрх эдлэгчдийг илүүтэй хүлээн зөвшөөрч, хүндэтгэн хамгаалж чадсан уу?

“Бид өмнөхөөсөө илүүг бүтээх болно” хэмээх лоозон 2021 онд хоосон уншлага болсон байв. “Дэлхийн эдийн засгийг дахин сэргээх”; корпорациудын хүчирхийллийг зогсоох, тогтвортой бөгөөд ногоон сэргэлтийг бий болгох, өөрчлөлтийн төлөөх эв нэгдлийг хангах дэлхийн “нийтлэг мөрийн хөтөлбөр” зэрэг амлалтууд ч бас гацсан. Уриа лоозон нь утга учир багатай, амлалтууд нь биелээгүй төдийгүй олон газар оронд хүмүүсийн эрх зөрчигдөж, нөхцөл байдал улам дордсон. Өөр олон боломжит сонголт байсан хэдий ч засгийн газрууд иргэдийнхээ нэр төртэй байх, хүн шиг амьдрах, эрхээ эдлэх боломжийг хаан боогдуулсан бодлогыг сонгож, хэрэгжүүлээ. Цар тахлыг өдөөсөн тогтолцооны тэгш бус байдал системтэйгээр буурах биш харин ч улам гүнзгийрлээ. Эмнэлгийн тусламжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ, материал хангамжийн хил дамнасан урсгал ихэнхдээ хангалттай байсангүй. Улмаар гамшиг, хүний эрхийн хямралыг бууруулах засгийн газар хоорондын хамтын ажиллагаа тэр бүр хэрэгжээгүй байна. Яг жилийн өмнө Эмнести Интернэшнлийн жилийн тайлангийн оршил үгийг бичиж байхдаа би 2021 онд улс орнууд, иргэд Ковид-19 цар тахлыг даван туулах тал дээр ахиц гаргана гэж чин сэтгэлээсээ найдаж байсан. Шинжлэх ухааны ололт амжилт, урьд өмнө хэзээ ч байгаагүй хурдацтай ялалт байгуулж, цар тахлын төгсгөлийг бидэнд ойртуулах боломжтой гэж бодож байсан. Гэвч тэгсэнгүй. Тэгэхээр, юунаас болж бүх юм буруу тийшээ эргэсэн бэ?

Дэлхийн удирдагчид бидэнд тогтвортой сайн засаглал авчрахын оронд үндэсний явцуу ашиг сонирхолдоо хөтлөгдөн ухралт хийлээ. Удирдагчид илүү олон хүний аюулгүй байдлыг хангахын оронд аюул заналын ангал руу, тэр ч бүү хэл дайн байлдаан руу түлхэв. Удирдагчид ард түмнүүдийг хагаралдуулж буй үйл ажиллагаа, стратегийг таслан зогсоохын оронд улс үндэстнээ эд баялаг, байгалийн нөөцийн төлөө сөрөг үр дагавартай өрсөлдөөн, мөргөлдөөн, хямрал руу түлхлээ. Тэгш эрхийн талаарх хүний эрхийн түгээмэл хэм хэмжээг сахин хамгаалахын оронд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг олон улсын тогтолцоонд нэвтрүүлэн, тэр ч байтугай хэн амьд үлдэж, хэн амьд үлдэхгүй байхыг хүртэл тодорхойлж байгаа нь хэний амьдрал чухал, хэнийх нь чухал биш байх тухай харгис түүхийг баяжуулсаар байна. 2021 он бол эдгээх, нөхөн сэргээх жил байх ёстой байсан боловч түүний оронд зөвхөн 2021 онд төдийгүй 2022 онд, цаашлаад ирэх арван жилийн хугацаанд **тэгш бус байдал гаарсан, тогтворгүй байдал бодитоор нүүрлэх эрсдэлт нөхцлийг бий болгочихлоо.**

2021 оны Ковид-19 цар тахлын халдвар, өвчлөлт, нас баралтын асар өндөр давалгааг таамаглах, зайлсхийх боломж байсан. Баян чинээлэг засгийн газрууд вакцинжуулсан хэмээн өөрсөддөө баяр хүргэж байх зуур оны эцсээр вакцины талаарх тэдний үндсэрхэг үзэл газар авснаас болж дэлхийн хүн амын талаас илүү хувь нь вакцинд огт хамрагдаагүй буюу хагас хугас хамрагдаад байв. Дархлаажуулалтын түвшин доогуур байгаа нь вирусын шинэ хувилбаруудад тархах боломж олгож, бид бүгдийг вакцинд тэсвэртэй мутацид өртөх эрсдэлд оруулж, цар тахлын үргэлжлэх хугацааг уртасгасан юм. Дэлхийн өмнөд хэсэгт сая сая хүмүүс, түүний дотор өвчин нь хүндрэх, нас барах эрсдэл өндөртэй хүмүүс анхны тунгаа хүлээсээр байхад баян чинээлэг улс орнуудын иргэд вакцины сэргээх тунгаа хийлгэж байв. Өнгөрсөн 9 дүгээр сард Эмнести Интернэшнл хөгжингүй орнууд хагас

тэрбум илүүдэл тун хадгалж байгааг тогтоосон бөгөөд энэ нь дэлхийн хамгийн бага вакцинжуулалтад хамрагдсан хэд хэдэн улсыг бүрэн вакцинжуулахад хангалттай хүрэлцэхээр байв. Тэд хугацаа дууссан илүүдэл тунгуудыг хог дээр хаяж байсан нь ёс суртахуунгүй, замаа алдсаны цочирдом шинж тэмдэг байв. Компаний гүйцэтгэх захирал, хөрөнгө оруулагчид их хэмжээний ашиг олж байхад вакцин хамгийн их хэрэгтэй байгаа хүмүүс хүлээсээр, амь насаа алдсаар байв.

Ковид-19 цар тахлын хажуугаар шинэ хямрал мөргөлдөөн үүсч, шийдэгдээгүй хямрал мөргөлдөөн улам гүнзгийрэв. Афганистан, Буркина Фасо, Этиоп, Израйль / Палестин, Ливи, Мьянмар, Йемен зэрэг улсад үүссэн хямрал мөргөлдөөн олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн хуулийг өргөн цар хүрээтэйгээр зөрчигдөхөд хүргэлээ. Маш цөөн тохиолдолд нь олон улсаас шаардлагатай хариу арга хэмжээ авч, шударга ёсыг сэргээж, хариуцлага тооцсон. Дийлэнх тохиолдолд хямрал мөргөлдөөн улам өргөжиж, цаг хугацаа өнгөрөх тусам сөрөг үр нөлөө нь ихэссэн. Оролцогч талуудын тоо, олон талт байдал нэмэгдсэн. Хямрал мөргөлдөөний шинэ талбарууд нээгдэв. Шинэ зэвсэг туршиж, илүү олон хүн амь насаа алдаж, илүү олон хүн бэртэл гэмтэл авч, хүний амь үнэгүйдэв.

Олон улсын цэргийн бүх хүч Афганистаныг орхиж, засгийн газар нь нуран унаж, талибанчууд улс орныг нь эзлэн авсны дараа хүний эрх, ардчиллын үнэт зүйлсийн төлөөх тэмцлийн тэргүүн эгнээнд байсан Афганистаны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг үнсэнд хаясан шалз шиг орхисон нь дэлхийн ялзран доройтож буй дэг журмын хаа ч байхгүй нэгэн тод илрэл боллоо.

Түүний зэрэгцээ дэлхий даяар цар тахлын эсрэг нэгдсэн хариу арга хэмжээ авч чадаагүй нь илүү их зөрчилдөөн, шударга бус байдлын үрийг тарьсан. Ядуурал нэмэгдсэн, хүнсний аюулгүй байдал алдагдсан, цар тахлыг өөрөөр сэтгэгчид, эсэргүүцэгчдийг дарах арга болгосон зэрэг нь бүгд 2021 онд эх үндсээ тавьсан. Энэ нь вакцины үндсэрхэг үзлээр услагдаж, баян орнуудын шуналаар бордогдсон.

2021 оны энэхүү хандлага КОП26 уур амьсгалын бага хурал дээр ч тодорхой харагдсан. Богино хугацааны үр дүнд хэт автсан, хувиа хичээсэн сэтгэлгээнд хөтлөгдөн 14 хоног үргэлжилсэн хэлэлцээ урвалтаар өндөрлөсөн билээ. Гамшгийн хэмжээнд хүрээд байгаа уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлаас урьдчилан сэргийлэх тохиролцоонд хүрч чадаагүй нь засгийн газрууд ард түмнээсээ урвасан хэрэг болсон юм. Ингэснээр хүн төрөлхтөн усны хомсдол, ган гачиг, үер, өлсгөлөнд нэрвэгдсэн ирээдүйг угтахаас аргагүйд хүрлээ. Цагаачдыг хил дээрээсээ буцааж буй засгийн газрууд сая сая хүнийг аюулгүй байдал, илүү сайн амьдрах нөхцлийг хайж гэр орноо орхин дүрвэх шалтгаан болсон. Өндийж чадахгүй болтлоо өрөнд унасан улс орнууд амь насанд халтай хүрээлэн буй орчны өөрчлөлттэй тэмцэх хангалттай санхүүжилтгүй хоцорчээ.

2021 он олон сая хүнийг үхэл амьдралын заагт амьдрахад хүргэсэн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бодлого, үзэл суртлыг хүлээн зөвшөөрөх явдлыг илүү өргөжүүллээ. Тухайлбал: Вакцин үйлдвэрлэгч орнууд бага орлоготой орнуудтай мэдлэг, технологио хуваалцахаас татгалзаж, вакцины хомсдлыг арилгах вакцины үйлдвэрлэл нэмэгдэх боломжийг хаалаа. Тэд вакцины патенттай холбоотой хэлэлцээрийн хүрээнд оюуны өмчийн эрхийг түр хугацаагаар цуцлахыг уриалсан дэлхий нийтийн санаачилгыг дэмжсэнгүй. Засгийн газрууд дүрвэгсэд, цагаачид, дотооддоо шилжин суурьшигчид, орогнол хүсэгчдийн их урсгалыг тогтоон барихаар “үхлийн эрсдэл”-д тулгуурласан бодлого барьж, хүний амийг аврахыг оролдсон хүмүүсийг тэр бүү хэл гэмт хэрэг үйлдсэнд тооцов. Цөөнхийг ад зэтгэр болгон буруутгаж, дур зоргоороо (“үзэн ядах эрх чөлөө” гэх мэт) үзэл санаа дэвшүүлж, арьс өнгө, хүйсээр ялгаварлан гадуурхах үзлийг хориглосон түгээмэл эрх, хэм хэмжээ, стандартыг үгүйсгэсэн улс төрийн хорт ярианы агуулгыг өөгшүүлж байлаа. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагатай үйлчилгээг татан буулгаж эмэгтэйчүүд, охидод асар их хор хөнөөл учруулснаас бид үүнийг харж болно.

2021 онд эрх баригчдад хүн төрөлхтний хамгийн ноцтой асуудлуудтай тэмцэх хүсэл зориг дутсан бол харин ард иргэдийн тухайд тэдэнтэй адил байгаагүй. 2021 онд дэлхийн өнцөг булан бүрт хүмүүс зөвхөн өөрсдийнхөө эрхийн төлөө бус бүх нийтийн эрхийн төлөө эв санааны нэгдлээ илэрхийлэн тэмцсэн. Тэд илүү сайн тогтолцоо, шударга хууль, шударга нийгмийг шаардаж байв. Улс орныхоо авлигад идэгдсэн удирдлага, хэвлэл мэдээллийн эсрэг тогтоосон хязгаарлалтыг зүрх зоригтойгоор сөрөн зогссоных нь төлөө Нобелийн хороо 2021 оны Нобелийн Энх тайвны шагналыг Филиппиний Мария Ресса, Оросын Дмитрий Муратов гэсэн хоёр сэтгүүлчид олгосноороо энэхүү эрэлхэг үлгэр дуурайллыг үнэлсэн билээ. Эрх баригчид харгис хэрцгийгээр нухчин дарж, зарим тохиолдолд цар тахлыг жагсаал цуглаан хийх эрхийг үгүйсгэх шалтаг болгон ашиглаж байсан ч дэлхийн өнцөг булан бүрт хүмүүс эрслэн боссон. 2021 онд дор хаяж 67 улс оронд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарласан шинэ хуулиудыг батлан гаргажээ.

Гэсэн хэдий ч энэ нь хүмүүс дуу хоолойгоо хүргэхэд саад болж чадаагүй. Дэлхийн 80 гаруй оронд олныг хамарсан жагсаал цуглаан зохион байгуулагдсан. ОХУ-д сөрөг хүчний удирдагч Алексей Навальныйг дэмжих жагсаал урьд өмнө хэзээ ч байгаагүй хоморголсон хууль бус баривчилгаа, байцаалтын бай болсон. Энэтхэгийн тариаланчид 12 дугаар сар хүртэл газар тариалангийн талаар маргаантай гурван хуулийг эсэргүүцэн жагссан. Энэтхэгийн холбооны засгийн газар ард түмний мэргэн ухаанд ялагдаж, тэдгээр хуулийг хүчингүй болгуулав. 2021 оны турш Колумби, Ливан, Мьянмар, Судан, Тайланд, Венесуэл болон бусад олон оронд хүмүүс эрслэн боссоор байна.

2021 онд дэлхий даяар хуульч, эрдэмтэн судлаачид, ТББ-ууд, хохирогчид, тэдний гэр бүлийнхэн хүний эрхийн зөрчлийн эсрэг, дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн эсрэг, шударга ёсны төлөө эцэж цуцахыг үл тоон тэмцлээ. Шүүхээс зарим түүхэн чухал шийдвэрүүд гарлаа. 2 дугаар сард хоёр эрэлхэг Вьетнам хүүхэд Лондонд төвтэй хуулийн профессорын дэмжлэгтэйгээр хүний наймааны хохирогчдод ял оноодог асуудлаар Европын Хүний эрхийн шүүх дээр ялалт байгуулж чадсан. Өнгөрсөн 6-р сард Швейцарьт Либери дэх босогчдын командлагч асан Алиеу Косиаг дайны болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 20 жил хорих ял оноожээ. Төрийн бус байгууллагууд Хятадын Шинжааны бүс нутагт албадан хөдөлмөр эрхлэхэд хамтран оролцсон Nike, Patagonia, C&A зэрэг үндэстэн дамнасан томоохон компаниудын эсрэг шинэлэг стратегийн зарга, эрүүгийн хэрэг үүсгэсэн. 2021 онд иргэний нийгэм, сэтгүүлчид ч технологийн том компаниудын эсрэг тэмцэлд нэгдлээ. Хүний эрхийн шинжээчид, эрэн сурвалжлах сэтгүүлзүйн хамтын ажиллагааны томоохон хүчин чармайлт болох “Pegasus” төсөл нь засгийн газрын шүүмжлэгчид болон хүний эрх хамгаалагчдыг төрийн зүгээс мөшгин хянаж байгааг илрүүлсэн нь өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах далд арга тактикийг илчилсэн хэрэг боллоо. Арваннэгдүгээр сард АНУ-ын шүүх WhatsApp-д “Pegasus” тагнуулын программыг бүтээгч NSO группын эсрэг мэдүүлсэн заргаа үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн. Мөн түүнчлэн Amazon (746 сая еврогийн торгууль), WhatsApp (225 сая евро), Grindr (6.34 сая евро) зэрэг тэргүүлэгч технологийн компаниудад өгөгдлийн хамгаалалт, хувийн нууцын тухай хууль тогтоомжийг зөрчсөн хэмээн хамгийн өндөр торгууль ногдуулж чадсан.

Жирийн иргэдийн дэмжлэгээр төрийн бус байгууллагууд ч олон улсын хэм хэмжээ, механизмд эерэг өөрчлөлтийг авчирсан. Эмнести Интернэшнл зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын лобби амжилтанд хүрч НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөр цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхийг хүлээн зөвшөөрүүлж, Афганистан дахь хүний эрхийн асуудлаарх болон Уур амьсгалын өөрчлөлт, хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчдийг бий болгуулж чадлаа.

Хэрэв засгийн газрууд өмнөхөөс илүү дээрийг бүтээх биш харин ч өмнөхөөс дордуулбал бидэнд маш бага сонголт үлдэнэ. Бид дуу хоолойг маань нухчин дарах аливаа шийдвэр, аливаа оролдлого бүрийг нухацтай авч үзэж, эрхээ хамгаалж

зогсох болно. Бид бас нэг нэгнийгээ дэмжин урагшлах ёстой. Бид дэлхий дахины эв нэгдлийн төлөөх хүнээс хүн рүү чиглэсэн илүү бодитой, шаардлага өндөртэй, тууштай хөдөлгөөнийг хамтдаа байгуулах ёстой. Хэрэв манай удирдагчид биднийг хүний эрх рүү хөтлөхгүй бол хүний эрх биднийг бие бие рүү маань хөтлөх ёстой.

Үүний тулд бид шударга ёсны төлөөх дэлхийн нийтийн хөдөлгөөнийг зохион байгуулж, дэмжиж, идэвхжүүлэх ёстой. Эцсийн дүндээ манай гараг болоод хүмүүс бидний ирээдүй, хувь заяа маань харилцан уялдаатай, харилцан хамааралтай гэдгийг бид мэднэ. Бид үүнийг хүлээн зөвшөөрч амьдрах ёстой. Бид хүний эрхийн төлөө хариуцлага хүлээх ёстой. Хэн нэгний эрхийг орхигдуулдаггүй дэлхийн засаглалыг бид хамтдаа шаардах хэрэгтэй. Үүнийг одоо бүгдээрээ хамтдаа хийцгээе.

Агнес Калламард

Эмнести Интернэшнлийн Ерөнхий нарийн бичгийн дарга

ЭМНЕСТИ

ИНТЕРНЭШНЛИЙН

ТАЙЛАН 2021/22

**ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ,
БҮС НУТГИЙН ТОЙМ**



ДЭЛХИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ: ГУРВАН ГОЛ ЧИГ ХАНДЛАГА

2021 он бол итгэл найдвар, амлалтын жил байлаа: Ковид-19 цар тахлаас үүдсэн сүйрлийг вакцин зогсооно гэсэн хүн бүрийн итгэл найдвар, Их-7, Их-20-ын засгийн газрууд болон бүлгүүдийн «бид өмнөхөөсөө илүүг бүтээн байгуулах» амлалтуудыг дурдаж болно. Гэсэн хэдий ч энэ нь ихэнхдээ хоосон яриа төдий байсан бөгөөд зарим засгийн газар байр сууриа бэхжүүлэхэд цар тахлыг ашиглах явдлаа хоёр дахин нэмэгдүүлсэн.

Энэхүү дүн шинжилгээ нь 2021 онд Эмнести Интернэшнлийн 154 улсад хийсэн хүний эрхийн судалгаанаас урган гарсан гурван гол чиг хандлага болох «Эрүүл мэнд ба тэгш бус байдал», «Иргэний орон зай», «Умард»-ийн» улсуудын дүрвэгсэд ба цагаачдыг буцаан түлхэж байгаа байдлыг авч үзсэн болно.

ЭРҮҮЛ МЭНД БА ТЭГШ БУС БАЙДАЛ

Вакцинжуулалт нь ДЭМБ-ын тооцоогоор 2021 оны эцэс гэхэд наад зах нь 5,5 сая хүний амь насыг авч одсон (зарим тооцоогоор нас баралтын бодит тоо 2-3 дахин их байх магадлалтай) цар тахлыг эцэслэх найдвар төрүүлсэн. Олон орны засгийн газрууд дэлхий нийтийн вакцинжуулалтыг дэмжихээ амласан бөгөөд Их-7 болон Их-20-ын улс орнууд томоохон амлалт өгсөн. Гэсэн хэдий ч, ялангуяа “Өмнөд”-ийн зарим засгийн газрын хүчин чармайлтыг эс тооцвол олон улсын хамтын ажиллагаа үндсэндээ бүтэлгүйтэв. Өндөр орлоготой орнууд хэрэгцээнээсээ хэдэн саяар илүү тунг нөөцөлж, зарим нь нийт хүн амаа 3-5 дахин вакцинжуулах боломжтой болсон. 9 дүгээр сарын байдлаар энэ хэдэн улсад 500 сая гаруй тунг илүүдэл вакцин байсан тооцоо байна. Европын Холбооны орнуудын вакцинжуулалтын түвшин 70 гаруй хувьтай байсан бол “Өмнөд”-ийн олон улс орны иргэд вакцины анхны тунгаа хийх боломжийг хүлээсээр байв. Оны эцэс гэхэд Африк тивийн 1,2 тэрбум хүн амын 8 хүрэхгүй хувь нь вакцинд бүрэн хамрагдаад байсан нь дэлхийн аль ч тивийн вакцинжуулалтын хамгийн бага түвшин бөгөөд ДЭМБ-ын 2021 оны эцэс гэхэд нийт хүн амын 40% вакцинжуулалтад хамруулна гэсэн зорилтоос хол зөрүүтэй байна. Вакцины ийм тэгш бус байдал нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах шударга бус байдлыг улам бүр гүнзгийрүүлсэн. Европын Холбооны гишүүн Норвеги, Швейцарь, Их Британи зэрэг баян улс орнууд оюуны өмчийн эрхийг түр түдгэлзүүлэхийг татгалзсанаар дэлхийн вакцины үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бага дунд орлоготой орнуудын вакцины хүртээмжийг сайжруулах оролдлогыг хаан боогдуулж байсан. Үүний зэрэгцээ, хүчирхэг засгийн газруудын дэмжлэгтэй эмийн компаниуд өндөр орлоготой орнуудад вакцин хүргэх ажлыг нэн тэргүүнд тавьж байв. Ковид-19 вакцины үйлдвэрлэлийг тэргүүлж буй гол компаниуд оюуны өмчийг монопольчилж, технологи дамжуулалтыг хааж, вакцины дэлхийн үйлдвэрлэлийг өргөжүүлэх арга хэмжээний эсрэг түрэмгий лобби хийж байлаа. Ихэнх компаниуд олон тэрбум долларын төсвийн санхүүжилт авч, цар тахлаас санаанд оромгүй их ашиг олж байсан хэдий ч ийм зүйл болсон. Тэдний гурав болох **BioNTech, Pfizer болон Moderna** 2022 оны эцэс гэхэд 130 тэрбум ам.долларын орлого олохоор төлөвлөжээ.

Вакцинжуулалтын үндэсний хөтөлбөрүүд харилцан адилгүй явагдлаа. Зарим улсын эрүүл мэндийн байгууллагууд шинжлэх ухааны арга барил, мэдээллийн кампанит ажил, эрүүл мэндийн ажилтнуудын ачаар вакцинжуулалтын үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Гэтэл зарим орны засгийн газрын вакцинжуулалтын хөтөлбөр нь нээлттэй бус, хангалттай зөвшилцөл байхгүй, авлигад өртсөн байв. Зарим нь цагаачид, дүрвэгсэд, дотооддоо шилжин суурьшигчид, хөдөө орон нутгийн болон уугуул иргэд, хоригдол, орон гэргүй бичиг баримтгүй хүмүүс,

ялгаварлан гадуурхалтад өртсөөр ирсэн бусад бүлгийн хүмүүс зэрэг онцгой эмзэг нөхцөлд байгаа хүмүүсийг вакцинжуулах ажлыг чухалчлан авч үзээгүй, зориудаар хасч байв. ОХУ-д гэр оронгүй, бичиг баримтгүй цагаачдаас иргэний үнэмлэх, эмнэлгийн даатгал (тэдний ихэнхэд байдаггүй) зэргийг шаардсан нь вакцинжуулах ажлыг хүндрүүлсэн.

Никарагуа улсад зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр Ковид-19 цар тахалд өртөх эрсдлээс үл хамааран засгийн газрыг дэмжигчдийг тэргүүн ээлжинд вакцинжуулж байгаа талаар мэдээлсэн. Латин Америкийн бүс нутгийн гэх мэт олон улс орон уугуул иргэдийг вакцинжуулах соёлын хувьд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх тусгай журмыг бий болгож чадаагүй.

Цаашилбал, улстөрчид, тэр ч байтугай удирдагчид өөрсдийн ашиг сонирхлын төлөө худал, ташаа мэдээлэл түгээж, хариуцлагагүй нийгмийн сүлжээний компаниудтай хавсран вакцинд эргэлзэх хандлагыг улам хурцатгав. Мөргөлдөөн хямрал нь вакцинжуулалтын хөтөлбөр, эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд сөргөөр нөлөөлсөн бөгөөд тухайлбал Йемен, Этиоп зэрэг улсад иргэний дэд бүтцэд халдаж, хүмүүнлэгийн хүртээмжийг хязгаарласан. Афганистан, Мьянмар зэрэг оронд гарсан улс төрийн үймээн самуун угаасаа хэврэг байсан эрүүл мэндийн тогтолцоог сүйрлийн ирмэгт хүргэв.

Хүний эрүүл байх, эрүүл мэндээ хамгаалуулахаар дамжин хэрэгжих эрхүүд нь урьд өмнө хэзээ ч ийм чухлаар тавигдаж байгаагүй буюу ийм их эрсдэлтэй байгаагүй. Дэлхий даяар асар их хөрөнгө оруулалт, анагаах ухааны ололт амжилтыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад ашиглах боломж байсан. Гэвч засгийн газрууд манлайлж чадаагүй. Тэд олон арван жилийн турш эдгээр үйлчилгээг үл тоомсорлож, дутуу санхүүжүүлж байсан практикаа өөрчлөх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хязгаарлагдмал, тэгш бус хүртээмжээ шийдэж чадаагүй. Энэ нь Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахын хажуугаар эрүүл мэндийн ердийн үйлчилгээг үзүүлэх давхар сорилт бүхий эрүүл мэндийн тогтолцоонд тулгарч буй хямралын том сорилт байв. Ялангуяа, арьс өнгөөр ялгаварлан гадуурхагдсан цөөнх, цагаач ажилчид, өндөр настан, түүнчлэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүсэлтэй эмэгтэйчүүд ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгарсан. Зарим эрх баригчид улс төрийн шалтгаанаар Ковид-19 халдварын тохиолдол байгааг үгүйсгэх, эрсдэлийг үл тооцоолох, зарим улсаас вакцин авахыг хориглох зэргээр байдлыг улам дордуулж байв. Конго, Нигери, Того зэрэг Африкийн зарим оронд эрүүл мэндийн ажилтнууд эрүүл мэндийн салбарынхаа доголдолтой асуудлаар тодорхой арга хэмжээ авахыг засгийн газраасаа шаардах, хэдэн сарын турш аваагүй цалин хөлсөө олгохыг шаардан жагсаж, ажил хаяхад хүрсэн байна. Бусад улс орнууд, тэр дундаа Европын орнуудын зарим засгийн газар эрүүл мэндийн үйлчилгээнд тулгарч буй доголдлын талаар олон нийтэд мэдээлсэн эрүүл мэндийн ажилтнуудад арга хэмжээ авчээ.

Мөн түүнчлэн цар тахал болон цар тахлын эсрэг хариу арга хэмжээ олон улс оронд эдийн засаг, нийгмийн бусад эрхүүдэд асар ихээр нөлөөлж олон зуун сая хүнийг туйлын ядуурал руу түлхлээ. Цар тахлын улмаас өр зээлийн хэмжээ нэмэгдсэн нь нийгмийн зайлшгүй үйлчилгээнд шаардлагатай хөрөнгө оруулалт хийх боломжид сөргөөр нөлөөлж, өр зээлийг хөнгөвчлөх явдал хязгаарлагдмал байгаагаас үүдэн амлаж байсан эдийн засгийн сэргэлт биеллээ олсонгүй. 2020 оны 4 дүгээр сард Их 20-ийн орнуудын уулзалтаар тохиролцсон 45 тэрбум ам.долларын өрийн хөнгөлөлтөө 2021 оныг дуустал хоёр удаа сунгасан нь бодит байдал дээр 40 гаруй орны ердөө 10,3 тэрбум ам. долларын өрийг чөлөөлсөн. Энэ санаачилга өрийн эргэн төлөлтийг хойшлуулахаас хэтрээгүй, өргөдөл гаргасан 46 улс 36,4 тэрбум ам.долларын өр төлсөн нь сул талыг нь улам нэмэгдүүлсэн юм. Мөн хувь зээлдүүлэгчдийн өрийг барагдуулах асуудлыг авч үзэж чадаагүй бөгөөд ердөө 0,2 хувийг нь хойшлуулсан.

2021 он нь засгийн газрууд корпорациудын эгэх хариуцлагыг шаардах, цаашид цар тахлын эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авах хүчин чармайлтын голд хүний

эрхийг тавих үндэс, дохио болсон юм. Дэлхийн Эрүүл Мэндийн Чуулган 2021 оны 12 дугаар сард цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг бэхжүүлэх асуудлаар олон улсын баримт бичгийн төслийг боловсруулж, хэлэлцээ хийх дэлхий нийтийн үйл явцыг эхлүүлэхээр тохиролцсон ч оны эцсийн байдлаар хүний эрхийн талаар дорвитой дурдсан зүйл алга байв. Ийм төрлийн аливаа гэрээ нь дэлхийн эрүүл мэндийн хууль тогтоомжийг иж бүрэн шинэчилж, эдгээр байгууллагын хүрээнд засгийн газруудын үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт оруулахаас нааш зөвхөн хязгаарлагдмал үр нөлөө үзүүлэх болно.

Нэмж хэлэхэд, олон арван жилийн турш зөвшилцөлд хүрч чадахгүй байсны эцэст Их 20-ийн орнуудын засгийн газрууд дэлхийн татварын тогтолцооны зарим шинэчлэлийн талаар тохиролцоонд хүрсэн. Энэ нь хэдийгээр алдаа мадагтай, хангалттай бус ч дэлхий даяар хянах боломжгүй, хор хохирол ихтэй компаниудын татвараас зугтаах, татвар төлөхөөс зориудаар зайлсхийх асуудлуудыг шийдвэрлэх зөв алхам болсон.

ИРГЭНИЙ ОРОН ЗАЙ

Засгийн газрууд 2021 оны сорилтуудыг хэрхэн даван туулах талаар хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнүүлэх орон зайг бий болгохын оронд бие даасан, шүүмжлэлт дуу хоолойг нухчин дарах хандлагаа хадгалсаар байсан бөгөөд тэр ч байтугай зарим улс орон цар тахлыг иргэний орон зайг улам бүр хумих шалтаг болгон ашиглав. Оны туршид олон ч орны засгийн газар өөрсдийг нь шүүмжлэгчдийг залхаан цээрлүүлэх арга хэмжээгээ хоёр дахин нэмэгдүүлсэн. Эдгээр арга хэмжээний ихэнх нь “Ковид-19 цар тахлын талаар нийгэмд ташаа мэдээлэл тараахыг зогсоох” нэрийдлээр хийгдсэн байна. Дэлхийн зарим улс орон иргэдийнхээ тайван жагсаал цуглааныг үндэслэлгүйгээр хориглон тарааж байсан бөгөөд ингэхдээ Ковид-19-ийн тархалтаас урьдчилан сэргийлэх дүрэм журмыг шалтаг болгож байв. Африк, Ойрх Дорнод, Хойд Африк, Ази тивийн хэд хэдэн орны засгийн газар интернэт, нийгмийн сүлжээг хаах буюу ихээхэн хязгаарласан. Эсватини, Өмнөд Судан зэрэг зарим оронд иргэдийн төлөвлөсөн эсэргүүцлийн хөдөлгөөнийг таслан зогсоохоор заримдаа интернэт сүлжээг тасалдаг байв. Сэтгүүлч, шүүмжлэгч, хүний эрх хамгаалагчид, тэр дундаа эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалдаг хүмүүсийн эсрэг үйлдсэн халдлагууд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг дайралтын томоохон хэсэг байв. Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарласан шинэ хуулийн төслийг боловсруулж, өргөн барьж байсан нь арагшаа ухарсан бас нэгэн чиг хандлага байв. Эмнести Интернэшнлийн хөндлөнгийн хяналтад үндэслэн энэхүү тайланд тусгагдсан 154 орны дор хаяж 67-д нь, түүний дотор Камбож, Египет, Пакистан, Турк, АНУ зэрэг улсад тийм хууль тогтоомжийг оны туршид өргөн барьсан байна. Үүний зэрэгцээ, Ковид-19-тэй тэмцэх зорилготойгоор 2020 онд авч хэрэгжүүлсэн хязгаарлалтын арга хэмжээнүүдээ нийгмийн эрүүл мэндийн нөхцөл байдал сайжирсан ч хэвээр хадгалж үлджээ.

Хүний эрх хамгаалагчид, засгийн газрыг шүүмжлэгчдийг засгийн газрууд болон томоохон корпорацууд элдэв аргаар дарамтлан, халдаж байсан ч нийгэмд дуу хоолойгоо өргөж, **тууштай эсэргүүцэж** байв. Үндэслэлгүйгээр баривчлах, шударга бусаар яллах, айлган сүрдүүлэх, хилс хэрэг тулгах, захиргааны хязгаарлалт тогтоох болон бусад заналхийлэл, хүчирхийлэл, тэр дундаа хүчээр алга болгох, эрүүдэн шүүх зэргийг энд дурдаж болно. Хүний эрх хамгаалагчдыг онилж, дарамтлах зорилгоор зарга үүсгэх явдал нэмэгдсэн бөгөөд тухайлбал, АНУ-д Шеврон корпорацийн эсрэг Эквадор дахь нефтийн хаягдлын хохирогчдыг төлөөлж буй гол хуульчдын нэг болон Косово улсад Австрид төвтэй Келкос Энержи компанийн усан чахилгаан станцын төслүүдийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар дуу хоолойгоо өргөсөн идэвхтнүүдийн эсрэг ийм зарга үүсгэжээ. Мөн Андорра улсын засгийн газар НҮБ-ын шинжээчдийн форум дээр эмэгтэйчүүдийн эрхийн талаар үг хэлсэн идэвхтэнд бусдыг гүтгэсэн хэргээр эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Эмнести Интернэшнлийн мониторинг

хийсэн 154 орны 84-т нь хүний эрх хамгаалагчдыг хууль бусаар саатуулсан аж. Үүний дотор Ойрх Дорнод болон Хойд Африкийн 19 орны 17 нь багтаж байна. Америк тив хүний эрхийн хамгаалалтаар дэлхийн хамгийн аюултай бүс нутгийн нэг хэвээр байна. Учир нь Америк тивийн найман улсад хүний эрх хамгаалагч амиа алдсан хэрэг гарсан байна. Мьянмар, Афганистанд болсон үйл явдлууд хүний эрх хамгаалагчид өмнөхөөсөө илүү их хүчирхийлэл, айлган сүрдүүлэлтэй тулгарч, хүний эрхийн ололт алдагдаж байгааг харууллаа. Зарим орны засгийн газрууд урьд өмнө нь хэний ч санаанд багтамгүй үйлдлийг хийж, Орос, Хятадын Хонгконг муж ТББ болон хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаах эрс алхам хийлээ. Афганистанд талибанчууд засгийн эрхийг авсны дараа улс даяар 200 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаажээ.

Беларусь улс онгоцонд байсан сэтгүүлчийг баривчлахаар тэсрэх бөмбөг тавьсан гэх хуурамч заналхийллээр иргэний нисэх онгоцны чиглэлийг өөрчилсөн нь туйлын увайгүй халдлага боллоо. Нийгэмд эзлэх байр суурь, хүний эрхийн төлөөх тэмцлийг удирдан чиглүүлэхээр зориглосон иргэд цахим болон цахим бус орчинд шоовдорлолт, арьс өнгө, хүйсээр ялгаварлан гадуурхсан олон төрлийн эрсдэл, сорилтуудтай тулгарсан. Мөн засгийн газрууд сэтгүүлч, хүний эрх хамгаалагч, улс төрийн өрсөлдөгчид болон бусад шүүмжлэлт дуу хоолойг онилохын тулд тагнах программ, технологийн хэрэгслийг улам ихээр ашиглах болжээ. Цар тахлын хязгаарлалт, байнгын дарамт шахалтын улмаас Энэтхэгээс эхлээд Зимбабве хүртэлх олон орны төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа явуулах, гадаадаас санхүүжилт авахад бэрхшээлтэй болжээ. Иргэний орон зай, цөөнх бүлгүүд болон өөрөөр сэтгэгчид рүү төрийн бус тоглогчид халдаж байсан бөгөөд тэд заримдаа эвсэгт халдлага хийх, зарим үед улс орнуудын эрх баригчидтай хамтран халдлага үйлдэж байв. Энэ нь Далит, Адивасис хүмүүс болон исламын шашинтнууд ийм хүчирхийлэл, үзэн ядалттай илүү их нүүр тулгарсаар байгаа Энэтхэг улсын жишээн дээрээс илт байв. Бразилд хүрээлэн буй орчны идэвхтнүүдийг төрийн бус тоглогчид хөнөөсөн хэрэг гарсаар байна. Европт арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл улам нэмэгдэж байхад, Австри, Франц, Герман, Итали, Их Британи зэрэг улсад исламын шашны эсрэг болон еврейн эсрэг үзэл улам бүр нэмэгдэж, исламын шашинтнууд, еврей хүмүүс болон бусад үндэстний цөөнхүүд үзэн ядалтын гэмт хэрэгтэй илүү их тулгарах боллоо. 2021 онд засгийн газрууд аюулгүй байдлыг хангах нэрээр иргэний орон зайг хумих, тайван жагсаал цуглааныг гэмт хэрэгт тооцох, цагдаагийн байгууллагыг цэрэгжүүлэх, эсэргүүцлийн хөдөлгөөний эсрэг үндэсний аюулгүй байдлын эрх мэдлийг ашиглах зэргээр жагсаал цуглааныг нухчих хандлага нэмэгдсэн. Жагсаал цуглааны эсрэг аюулгүй байдлын хүчнийхний авч буй хариу арга хэмжээ харгис хатуу, жагсагчдын эсрэг шаардлагагүй, хэт их хүч хэрэглэсэн тохиолдлыг мониторинг хийсэн 154 орны 85-д нь Эмнести Интернэшнл судалгаагаараа баримтжуулсан. Аюулгүй байдлын хүчнийхэн галт эвсэг болон нулимс асгаруулагч хий, резинэн сүм зэрэг хөнөөл багатай бусад зэвсгийг байнга зүй бусаар ашиглаж, олон зуун хүнийг хууль бусаар хөнөөж, түүнээс ч олон хүнийг шархдуулсан. Зарим оронд жагсаал цуглааны эсрэг төрийн хариу арга хэмжээг эвсэгт хүчин, цэргийн техник хэрэгслийг ашиглах зэргээр цэрэгжүүлэх хандлага үргэлжилсээр байв. Авлигажсан шүүхүүд жагсагчид, түүнчлэн хүний эрх хамгаалагчид, бусад шүүмжлэгчдийг халдлагаас хамгаалж чадаагүй төдийгүй, бүр нэрмээс болж байв.

Засгийн газрууд баривчлах, шүүн таслах ажиллагаагаа үргэлжлүүлсээр байсан бөгөөд жагсаал цуглааныг удирдагчид, оролцогчдыг тодорхойлохын тулд царай таних болон мөшгин хянах бусад хэлбэрийг багтаасан технологийн арга хэрэгслийг түлхүү ашиглах боллоо.

УМАРДЫН ОРНУУД ДҮРВЭГСЭД БОЛОН ЦАГААЧДЫГ ХҮЧЭЭР БУЦААЖ БАЙНА

2021 онд шинээр үүссэн болон ужгирсан хямралын улмаас олныг хамарсан нүүлгэн шилжүүлэлт гарсаар байв. Афганистан, Этиоп, Мьянмарт болсон үйл явдлууд нүүлгэн шилжүүлэлтийн шинэ давалгааг бий болгов. Мянга мянган хүн Венесуэлийг орхин гарсаар. Зөвхөн Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад үргэлжилж буй мөргөлдөөний улмаас 2021 онд 1,5 сая хүн гэр орноо орхихоос аргагүйд хүрчээ. Дэлхий даяар олон сая хүн мөргөлдөөн, хүчирхийлэл, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол зэргээс үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн улмаас эх орноосоо дүрвэсээр байгаа бөгөөд үндэстний цөөнхүүд үүнд хамгийн ихээр өртөж байна. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн агентлагийн мэдээлснээр 2021 оны дунд гэхэд дэлхий даяар 26,6 сая дүрвэгч, 4,4 сая орогнол хүсэгч байв. Тэдний ихэнх нь Бангладеш, Йордан, Кени, Турк, Уганда зэрэг улсад олон жилийн турш дүрвэгсдийн хуаранд амьдарч байгаа бөгөөд олонх нь аюулгүй байдлыг эрэлхийлж орхиж явсан улс руу нь буцаах вий гэхээс байнгын айдастай амьдарч байна

Дүрвэж буй энгийн иргэдтэй эв санаагаа нэгтгэх явдал улам бүр нэмэгдэж байгаа нь өдгөө 15 улсад дүрвэгсдийг хүлээн авч буй орон нутагт тодорхой хэмжээний дэмжлэгийг санал болгож байгаагаас харагдаж байв. Гэсэн хэдий ч үндэсний болон олон улсын түвшинд эв нэгдэл асар их дутагдаж байна. Гадаадынхныг үзэн ядсан үг яриа олон нийтийн санаа бодолд, ялангуяа Умардынханд нэвт шингэсэн хэвээр байгаагаас цагаачлалын талаарх дотоодын бодлого улам чангарч байна. Европын Холбооны гишүүн олон арван улс дүрвэгсдийг хамгаалах дүрэм журмаа сулруулахыг уриалсан байна. Олон улсын хамтын нийгэмлэг дүрвэгсдэд зохих дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа төдийгүй аюулгүй газар руу нэвтрэх эрхийг нь хязгаарлаж байв.

Дүрвэж байгаа хүмүүс ихэнхдээ олон янзын хүчирхийлэлд өртдөг бөгөөд хүчээр буцаах, эрүүдэн шүүх, бэлгийн хүчирхийлэл зэрэг зөрчлийг үйлдэгчид ял шийтгэлээс мултарсан хэвээр байв. Олон орны засгийн газар дүрвэгсэд болон цагаачдыг нутаг дэвсгэртээ оруулахгүй байх, нэмж ирэхээс сэргийлэхийн тулд хамгаалах үүргээсээ зайлсхийж, эрхийг нь зөрчиж байна. Дүрвэн ирэгсдийг ирсэн улс руу нь буцаах тактик Беларусь/Европын Холбооны хил гэх мэт шинэ халуун цэгүүд дээр улам бүр дэлгэрч байна. АНУ-ын хилийн хяналтынхан Ковид-19 цар тахлыг шалтаг болгон АНУ-Мексикийн хил дээр бараг нэг сая дүрвэгч, цагаачдыг буцаасан. Үүний нэгэн адил засгийн газрууд орогнол хүсэх өргөдөл хүлээн авах дотоодын журамдаа гадаад хүчин зүйлийн өөрчлөлтийг илүүтэй тусгахыг эрмэлзэж байна. Мөн засгийн газрууд хилийн боомтууд дээрх гэмт хэргийг бууруулах нэрийн дор мөшгин тандах, өгөгдөлд суурилсан технологийг ашиглах чиг хандлагыг үргэлжлүүлэв. Хилийн боомт дах ийм технологийг өнгөт арьстнуудыг ялгаварлан гадуурхах байдлаар ихэвчлэн цагаан арьстнууд зонхилсон улс орнуудад ашиглаж байна. Хил давж буй хүмүүсийн хувьд байдал их хүнд байв. Эрх баригчид ихэнхдээ хууль зүйн үндэслэлгүйгээр, эсвэл тийнхүү баривчлан саатуулах нь хууль ёсны эсэхийг эсэргүүцэх боломж олголгүйгээр дүрвэгсэд болон цагаачдыг баривчилж, тодорхойгүй хугацаагаар саатуулсаар байв. Мөн зарим засгийн газар хууль бусаар албадан гаргасан бөгөөд Эмнести Интернэшнлийн 2021 оны судалгаа, мониторингид хамрагдсан 154 улсын дор хаяж 48-д нь дүрвэгсэд эсвэл цагаачдыг хууль бусаар эх оронд нь буцаасан эсвэл хил дээрээс буцаасан болохыг найдвартай эх сурвалжаас баримтжуулсан. Европын Холбооны дэмжлэгтэй Ливийн эргийн хамгаалалтынхан буусны дараа олон мянган хүн хүчээр сураггүй алга болсон төдийгүй олон зуун хүнийг зохих журмыг мөрдөлгүйгээр албадан гаргаж, хил дээр орхисон байна.

Малайз улс мөрдлөг хавчлага, хүний эрхийн бусад ноцтой зөрчлийн бодит эрсдэлийг үл харгалзан мянга гаруй хүнийг Мьянмарт буцаажээ. Олон орны засгийн газар дүрвэгсэд болон орогнол хүсэгчид зэрэг шилжин нүүдэллэж буй хүмүүсийг ялгаварлан гадуурхсан. Перу улсад нэг сая орчим гадаадын иргэн,

түүний дотор хагас сая орогнол хүсэгч эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхээ эдлэж чадахгүй байна. Хэдий тийм боловч 2022 онд Катарт болох эрэгтэйчүүдийн хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний бэлтгэлийн томоохон төслүүд дээрх цагаач ажилчдыг хөдөлмөрийн хүчирхийллийн талаар эрх баригчдад шахалт үзүүлэх явдал эрчимжиж байна. Мөн цагаачдыг, ялангуяа цагаач хүүхдүүдийг цагдан хорихыг үе шаттайгаар таслан зогсоох уриалга нэмэгдсээр байна.

ЗӨВЛӨМЖ

Үүрэг амлалтаа биелүүлэхийн тулд Засгийн газрууд цар тахлын дараах сэргэлт, хямралын хариу арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүний эрхийн зарчмуудыг хүндэтгэн сахиж, иргэний нийгэмтэй шийдэлд хүрэх түншүүдийн хувиар бодитой яриа хэлэлцээг өрнүүлэх ёстой.

Бүх засгийн газрууд вакцин үйлдвэрлэгчдийг Ковид-19 вакцины хүртээмжид саад учруулахаас сэргийлж холбогдох хууль тогтоомжийг батлан зохих арга хэмжээг авах ёстой. Ялангуяа баян чинээлэг орнууд Ковид-19 вакцины илүүдэл нөөцөө бага орлоготой орнуудад дахин хуваарилж, эдийн засгийн сэргэлтийг хөнгөвчлөхийн тулд өрийн дарамтаас чөлөөлөх ажлаа нэмэгдүүлэх ёстой. Эмийн компаниуд хамгийн их хэрэгцээтэй газарт нэн тэргүүнд хүргэлт хийх ёстой. Нийгмийн сүлжээний компаниуд худал, төөрөгдүүлсэн мэдээлэл тараахын эсрэг зохих хариу арга хэмжээг авах ёстой.

Засгийн газрууд цар тахлыг сэтгүүлчдийн бие даасан үйл ажиллагаа, мэтгэлцээний амыг таглах шалтаг болгон ашиглахаа зогсоож, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрхэд тавьсан үндэслэлгүй бүх хязгаарлалтыг нэн даруй цуцлах нь зүйтэй. Үүний зэрэгцээ засгийн газрууд хүний эрхийг хамгаалах, дэмжих зорилгоор хүмүүс эвлэлдэн нэгдэх аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх хууль тогтоомжийг батлах, өргөжүүлэх; ТББ-уудын хууль ёсны үйл ажиллагаанд саад учруулж байгаа хууль тогтоомжууд, тэр дундаа төрийн бус байгууллагуудын санхүүжилт хайх, хүлээн авах, ашиглахад саад учруулж байгаа аливаа хууль тогтоомжийг хүчингүй болгох, өөрчлөх шаардлагатай.

Засгийн газрууд иргэдийн тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулахын тулд урьдчилан зөвшөөрөл авахыг шаарддаг зүйл заалтыг цуцалж, цар тахлын үед авсан онцгой байдлын болон бусад хязгаарлалтын арга хэмжээг «шинэ хэвийн» зүйл болгохгүй байх нь туйлын чухал. Түүнчлэн хууль сахиулах чиг үүрэгтэй боловч хялбархан буруугаар ашиглагдах боломжтой бороохой, нулимс асгаруулагч хий, чинжүүтэй шүршигч, резинэн сүм зэрэг тоног төхөөрөмжийн экспорт, импортод хатуу хяналт тавих ёстой.

Засгийн газрууд олон улсын хамгаалалт эрэлхийлж буй хүмүүсийг хамгаалах үүргээ биелүүлж, эрхийг нь хүндэтгэн хамгаалж, урт хугацааны шийдэл олох хүртэл нутаг дэвсгэртээ зохистой нөхцөлд үлдэх боломжийг олгох ёстой. Тэд цагаачдыг хил дээрээсээ буцаах, хил дээрээ ирүүлэхгүй байх бодлогоо зогсоож, орон нутгийн ивээн тэтгэгчдийг дэмжих ёстой. Засгийн газрууд цагаачдыг ялгаварлан гадуурхах, цагаач хүүхдүүдийг саатуулах, хөдөлмөрийн хүчирхийллийг таслан зогсоох шинэчлэлийг гүнзгийрүүлэх ёстой.

АФРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Африкт өрнөж буй сунжирсан зэвсэгт мөргөлдөөний төлөөсийг энгийн номхон иргэд төлсөөр байна. Буркина Фасо, Камерун, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс (ТАБНУ), Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ), Этиоп, Мали, Мозамбик, Нижер, Нигери, Сомали, Өмнөд Суданд мөргөлдөөнд оролцогч талууд дайны гэмт хэрэг, олон улсын хүмүүнлэгийн ба хүний эрхийн хуулийг ноцтой зөрчсөн. Зарим тохиолдолд ийм зөрчил нь хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцогдохоор байв. Хохирогчдын төлөө шударга ёсыг тогтоох оролдлого бүтэлгүйтэх нь элбэг байлаа. Мөргөлдөөн хямралын улмаас олон сая хүн орон гэрээсээ дүрвэсэн ч дүрвэгсэд болон дотооддоо шилжин суурьшсан хүмүүсийн хуаранд хүмүүнлэгийн болон аюулгүй байдлын нөхцөл байдал эрдсэлтэй хэвээр байна.

Хямрал мөргөлдөөн өрнөхийн хажуугаар Ковид-19 цар тахал Африк тивд тархахдаа хүний эрхэд нөхөж баршгүй сөрөг нөлөө авчирлаа. Эмийн компаниуд, чинээлэг улс үндэстнүүдийн бий болгосон вакцины тэгш бус байдал цар тахлын түрлэгийг зогсоох хүчин чармайлтад саад болов. Оны эцэс гэхэд тус тивийн 1,2 тэрбум хүн амын 8 хүрэхгүй хувь нь вакцинд бүрэн хамрагдаад байв. Цар тахлын улмаас сургуулиуд хаагдаж, хүүхдүүдийн хичээл сурлага тасалдсан бөгөөд мөргөлдөөнд нэрвэгдсэн орнуудын хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд бэрхшээл нэмж тулгарлаа. Хэд хэдэн оронд цар тахлыг эс харгалзан албадан газар чөлөөлөлт хийж, олон арван мянган хүнийг орон гэргүй болгожээ.

Ковид-19 цар тахлын тархалтыг таслан зогсоох арга хэмжээ нь засгийн газруудад өөрөөр сэтгэх эрх, бусад эрх чөлөөг нухчин дарах үндэслэлийг өгсөн. Олон засгийн газрууд эрүүл мэнд, аюулгүй байдлын үүднээс тайван жагсаал цуглааныг хориглов. Хүмүүс хоригийг үл тоомсорлон олноороо гудамжинд жагсахад аюулгүйн хүчнийхэн тэднийг тараахын тулд хүч хэтрүүлэн хэрэглэж байв. Эрх баригчид хүний эрх хамгаалагчдын дууг хоолойг хорин, тэднийг гэмт хэрэгтэн болгож байв. Засгийн газрууд иргэний орон зайг хааж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ авч, өдөөн хатгалт, терроризм, гүтгэлгэтэй холбоотой эрүүгийн хуулиудыг зэвсэг болгон ашиглав.

Африкийн орнуудад хүйсийн ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлын бусад хэлбэрүүд оршсоор байна. Гол санаа зовоосон асуудалд жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээллийн хязгаарлагдмал хүртээмж, эрт болон албадан гэрлэлт, жирэмсэн охидыг сургуулиас хасах зэрэг асуудал багтаж байна. Үүний зэрэгцээ, ЛГБТИ хүмүүс бэлгийн болон хүйсийн чиг баримжаанаасаа болж дарамт шахалт, баривчилгаанд өртөж байв.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган гачигт хэд хэдэн улс онцгой ихээр нэрвэгдэж, бусад оронд хүрээлэн буй орчны доройтолтой холбоотой асуудал тулгамдаад байна.

ХҮҮЛЬ БҮС ХАЛДЛАГА БА АЛЛАГА

Бүс нутгийн хямрал мөргөлдөөн бүрт энгийн номхон иргэд, иргэний дэд бүтцийг онилсон халдлага өргөн тархсан. Камеруны Алс Хойд бүс нутагт 10-р сарын 24-ний байдлаар Боко Харам болон Баруун Африк дахь Исламын улс (ISWAP) 51 удаа

халдлага үйлдэж, наад зах нь 70 энгийн номхон иргэнийг хороосон. Төв Африкийн БНУ-д үндэсний зэвсэгт хүчин, тэдний холбоотнууд 2-р сард нэгэн сүмийг онилж, 14 хүний аминд хүрсэн. НҮБ-ын Төв Африкийн Бүгд Найрамдах Улс дахь энхийг сахиулах хүчин (MINUSCA) мөргөлдөөний улмаас 6 дугаар сараас 10 дугаар сарын хооронд 228 энгийн номхон иргэн амиа алдсан гэж мэдэгдэв. Этиоп улсад Тигрэй Ардын Чөлөөлөх Фронт (TPLF), үндэсний аюулгүй байдлын хүчин, зэвсэгт хүчний бүлгүүд Бора, Эдага Берхе, Ади-Гошу зэрэг хотод олон зуун энгийн номхон иргэдийг хоморголон устгасан. Нигерт Их Сахарын Исламын улс (ISGS) Тиллабери, Тахуа бүс нутгийн тосгоны иргэд болон худалдаачид руу дайрчээ. 1 дүгээр сараас 3 дугаар сарын хооронд гурван удаа болсон ийм халдлагын улмаас дор хаяж 298 энгийн номхон иргэн амиа алдсан байна. Зүүн хойд Нигерид Боко Харам болон ISWAP 30 гаруй халдлага үйлдэж, 123 гаруй энгийн номхон иргэний амийг хороожээ.

Бүс нутгийн хямрал мөргөлдөөн бүрт энгийн номхон иргэдийн амь насыг хөнөөсөн, шархдуулсан халдлага нийтлэг байв. Төв Африкийн БНУ-д гар хийцийн тэсрэх бөмбөг оны эхний хагаст дор хаяж 15 хүний амийг авчээ. Этиоп улсад Этиопын цэргийнхэн Тиграй дахь Эдага Селус тосгоны зах руу агаараас дайрсны улмаас 50 гаруй энгийн номхон иргэн амиа алдаж, олон хүн шархаджээ. Үүний нэгэн адил, TPLF хүчнийхэн их буугаар галласнаас Амхара мужийн Дебре Табор хотын нэгэн орон сууцны хороололд зургаан хүн амь үрэгджээ. Мозамбикийн Кабо Делгадогийн мөргөлдөөнд засгийн газраас шуурхай хариу арга хэмжээ авахаар хөлсөлсөн хувийн цэргийн компани болох Dyck Advisory Group нь энгийн болон цэргийн байг ялгахгүйгээр нисдэг тэрэгнээсээ пулемётоор буудаж, тэсрэх бодис шиджээ.

Нигерийн Зүүн хойд хэсэгт өнгөрсөн 2 дугаар сард Боко Харам бүлэглэл Борно мужийн Майдугури хотын зарим хэсгийг пуужингаар харвасны улмаас 16 хүн амиа алдаж, 47 хүн шархадсан юм. Есдүгээр сард Йобе мужийн Бувари тосгонд цэргийн агаарын цохилт өгөх үеэр есөн хүн амиа алдаж, хэд хэдэн хүн шархаджээ. Сомалид 2 дугаар сараас 7 дугаар сарын хооронд 241 энгийн номхон иргэн амиа алдаж, 295 хүн шархадсан болохыг НҮБ баримтжуулсан байна. Зэвсэгт бүлэглэлийн халдлагын үеэр амь насаа алдагсдын 68%-ийг Аль-Шабааб бүлэглэл хөнөөсөн бол үлдсэн хэсэг нь улсын аюулгүйн хүчин, овгийн дайчид, Сомали дахь Африкийн холбооны төлөөлөгчийн газар зэрэг олон улсын болон бүс нутгийн хүчнийхэнтэй холбоотой байв.

Африкийн зэвсэгт мөргөлдөөнд оролцсон бараг бүх оролцогчид бэлгийн хүчирхийллийг дайны тактик болгон ашигласан. Төв Африкийн БНУ-д НҮБ-ын энхийг сахиулах хүчин MINUSCA 1 дүгээр сараас 6 дугаар сарын хооронд ийм төрлийн 131 хэргийг, түүний дотор 115 хүчингийн хэргийг баримтжуулсан байна. БНАКУ-д мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийлэл өргөн тархсан хэвээр байгаа бөгөөд НҮБ-ын мэдээлснээр зөвхөн Хойд Киву, Итури хотод л гэхэд 1 дүгээр сараас 9 дүгээр сарын хооронд дор хаяж 1100 эмэгтэй хүчингийн гэмт хэргийн золиос болжээ. Этиоп улсад мөргөлдөөнд оролцогч талууд Тиграй болон Амхара мужид эмэгтэйчүүд, охидын эсрэг өргөн хүрээтэй хүчингийн гэмт хэрэг үйлджээ. Өмнөд Суданд НҮБ-ын тооцоолсноор төрийн аюулгүй байдлын хүчин болон төрийн бус зэвсэгт этгээдүүд хүчирхийлэл, бүлэглэн хүчиндэх, албадан нүцгэлэх зэрэг мөргөлдөөнтэй холбоотой бэлгийн хүчирхийллийн дор хаяж 63 тохиолдол үйлдсэн байна. Нигерт, Чадын G5 Сахел бүлэглэлийн гишүүд 4 дүгээр сард Тиллабери мужийн Тера хотод хоёр эмэгтэй, 11 настай охиныг хүчинджээ.

Зарим хямрал мөргөлдөөний үеэр хүмүүнлэгийн тусламжийг хаах, хязгаарлах аргыг дайны тактик болгон ашиглаж байв. Буркина Фасо улсад Ислам ба исламын шашинтнуудыг дэмжих бүлэг (GSIM) Яга мужийн Мансила хотыг бүслэн хаасны улмаас хүн амын хүнсний аюулгүй байдал алдагдсан. Мали улсад GSIM олон тосгон, суурин газрын армитай хамтран ажиллахыг нь зогсоохын тулд бүслэн хааж, тосгоны оршин суугчдын чөлөөтэй зорчих эрх, тариалангийн талбай болон ус ашиглах эрхийг хязгаарлав. Камерун, БНАКУ, Этиоп, Өмнөд Суданд зэвсэгт бүлэглэлүүд болон засгийн газрууд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг хориглон, хязгаарласаар байна.

НҮБ-ын тооцоогоор Этиоп улсад 5 сая гаруй, БНАКУ-д 19,6 сая, Өмнөд Суданд 8,3 сая хүнд хүнс, эм тариа зэрэг хүмүүнлэгийн тусламж нэн шаардлагатай байгаа юм.

Хэд хэдэн оронд нийгмийн бүлгүүд хоорондын хүчирхийлэл, улс төрийн эмх замбараагүй байдлын улмаас олон хүн амь үрэгджээ. Камеруны баруун хойд болон баруун өмнөд хэсэгт англи хэлээр ярьдаг хүмүүс, эрүүл мэндийн байгууллагууд, сургуулиуд зэвсэгт салан тусгаарлагчдын бай болов. Этиоп улсад Афар, Амхара, Бенишангул-Гумуз, Ороми, Сомали мужид угсаатны хүчирхийллийн улмаас дор хаяж 1500 хүн амиа алджээ. Нигерт малчид, тариаланчдын хоорондын хүчирхийлэл болон дээрэмчдийн дайралтын улмаас 3494 гаруй хүн амь насаа алджээ. Өмнөд Африкт ерөнхийлөгч асан Жейкоб Зумаг баривчилсанаас үүдэлтэй хүчирхийлэлд 360 гаруй хүн амиа алдав.

ЯЛ ЗАВШИХ ЯВДАЛ

Бараг бүх улсад олон улсын хуулийн дагуу гэмт хэрэг үйлдэгчид, хүний эрхийг ноцтойгоор зөрчигчид ял завшаар байна. Буркина Фасо улсад Ансарул Исламын зэвсэгт бүлэглэлийн хоёр гишүүнийг терроризмтой холбоотой хэргээр ялласан боловч 2019 онд Санматенга мужийн Йиргоу тосгон дахь Коглвеого гэх зэвсэгт бүлэглэлийн 50 хүнийг хууль бусаар хөнөөж, 66 хүнийг хүчээр сураггүй болгосон хэргийг мөрдөн шалгахад дорвитой ахиц гарсангүй. Төв Африкийн БНУ-д Эрүүгийн хэргийн тусгай шүүхээс 25 баривчлах захирамж гаргасан гэж мэдэгдсэн ч өнөөдрийг хүртэл нэг нь ч амжилттай хэрэгжээгүй байна. Засгийн газар “Өөрчлөлтийн төлөөх эх орончдын эвсэл” зэвсэгт бүлэглэлийн дайралт эхэлснээс хойш бүх талуудын гаргасан зөрчлийг шалгах Мөрдөн байцаах комиссыг байгуулсан ч тайлан, дараагийнхаа арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлээгүй.

БНАКУ-д Хойд Киву, Өмнөд Киву, Итури, Танганьика, Касай мужид дор хаяж 80 цэрэг, цагдаагийн албан хаагчид бэлгийн хүчирхийлэл зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдсэн хэргээр шүүгджээ. Конго улсын дарангуйлагч асан Рожер Лумбалаг дайны гэмт хэрэг болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутган Францын эрх баригчид баривчлав. Гэсэн хэдий ч БНАКУ-д олон улсын хуулийн дагуу гэмт хэрэг үйлдсэн бусад олон гэмт хэрэгтэн ял шийтгэлгүй үлдсэн. Мали улсад терроризмын хэргээр шүүх хурал болсон ч тэдгээр нь олон улсын шударга шүүхийн стандартад нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Түүний зэрэгцээ зэвсэгт бүлэглэл, цэргийнхний олон улсын хуулийг зөрчсөн гэмт хэргийн мөрдөн байцаалтад ахиц дэвшил бага байлаа.

Руанда улсад 1994 оны геноцидын үеэр Кикикиро хотын Интерахамвегийн цэргийн удирдагч байсан гэж буруутгагдаж байсан Жан-Клод Иямуремье геноцидын хэрэгт буруутгаж, 25 жилийн хорих ял оноожээ. Геноцид үйлдсэн хоёр сэжигтнийг шүүхийн тулд АНУ-аас Руанда руу шилжүүлэн авчирсан бол өөр нэг сэжигтнийг Нидерландаас шилжүүлэн авчээ. Өмнөд Суданд засгийн газар шүүх хурлаас илүү үнэнийг чухалчилж, Өмнөд Суданы Холимог шүүх байгуулах ажлыг хойшлуулж, хаасаар байна. Суданд 2019 оны 6-р сарын 3-нд наад зах нь 100 жагсагчийг хөнөөсөн хэрэгт хэн ч хариуцлага хүлээлгүйгээр он дууслаа. Эрх баригчид Дарфурт хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, геноцид, дайны гэмт хэрэг үйлдсэн хэрэгт холбогдсон Омар аль Башир болон бусад хоёр сэжигтнийг ОУЭШ-д шилжүүлэн өгөх үүргээ биелүүлээгүй хэвээр байна.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

ЭРҮҮЛ БАЙХ ЭРХ

Ковид-19 цар тахал Африк тивийг бүхэлд нь хамарч, хүний эрхэд нөхөж баршгүй хохирол учрууллаа. Оны туршид 9 сая орчим халдварын тохиолдол бүртгэгдэж, 220 000 гаруй хүн нас баржээ. Өмнөд Африк улс бүртгэгдсэн тохиолдол болон нас

баралтын хувьд цар тахлын голомт хэвээр байв. Ковид-19-ийн түрлэгийг зогсоох засгийн газруудын оролдлого нь эмийн үйлдвэрүүд болон чинээлэг улс орнуудын бий болгосон вакциныг дэлхий даяар түгээх тэгш бус байдлаас болж саатаж байв. Эмийн компаниуд вакциныг өндөр орлоготой орнуудад хүргэхийг нэн тэргүүнд тавьж байсан бөгөөд улмаар тэдгээр орнууд хэрэглэх хэмжээнээс илүү тунг нөөцлөв. Мөн баян орнууд оюуны өмчийн эрхээс түр татгалзах, технологи, мэдлэгийг хуваалцахыг нэмэгдүүлэх замаар бага, дунд орлоготой орнуудад нийлүүлэлтийг нэмэгдүүлэх оролдлогыг хаасан.

Ковид-19-ийн эсрэг вакциныг Африкийн орнуудад голчлон COVAX хөтөлбөр болон Африкийн вакцин худалдан авах траст, хоёр талын хандиваар дамжуулан нийлүүлжээ. Ихэнх тохиолдолд нийлүүлэлт хангалтгүй, ирэх цагийг урьдчилан тааварлах боломжгүй байсан нь засгийн газруудад хүн амын дунд итгэлцэл бий болгож, үр дүнтэй кампанит ажил зохион байгуулахад хүндрэл учруулжээ. БНАКУ, Малави, Өмнөд Судан зэрэг оронд нийлүүлэгдсэн вакцинууд дуусах хугацаа богинотой ирсэн тул эрх баригчид тэдгээрийг устгах эсвэл дийлэнх хэсгийг нь буцааж бусад улс руу шилжүүлэхээс аргагүйд хүрчээ. Нийлүүлэлтийн асуудал нь вакциныг эмзэг бүлэгт, тэр дундаа өндөр настан, архаг өвчтэй хүмүүст хүргэхэд хүндрэл учруулсан. Африкт вакцинжуулалтын үр дүнтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд саад болж буй дотоод хүчин зүйлс нь тэгш бус байдал, вакцинд эргэлзэх, үндэсний аюулгүй байдал зэрэг юм. Африкийн 1,2 тэрбум хүн амын 8 хүрэхгүй хувь нь оны эцэст бүрэн вакцинд хамрагдсан нь дэлхийн хамгийн бага үзүүлэлт бөгөөд ДЭМБ-ын нийт хүн амын 40%-ийг вакцинжуулах зорилтоос хол зөрөөтэй үзүүлэлт юм.

Ковид-19 цар тахал нь тус бүс нутгийн эрүүл мэндийн салбарт олон арван жилийн хугацаанд хөрөнгө оруулалт хийгдээгүйг илчилсэн. Ихэнх улс оронд угийн хангалтгүй байсан эрүүл мэндийн тогтолцоо, ялангуяа тахлын гурав дахь давалгааны үеэр ихээхэн хүнд байдалд орсон. Долдугаар сард орны дүүргэлт 91 орчим хувьтай байсан тул Өмнөд Африкийн Гаутенг мужийн хувийн болон улсын эмнэлгүүд ихээхэн хүндрэлтэй тулгарсан. Конго, [БНАКУ], Нигери, Того зэрэг улсад эмч нар эрүүл мэндийн тогтолцооны доголдолтой байгааг буруушаан мөн хэдэн сарын цалингаа өгөхийг шаардан ажил хаялт зарлаж, суулт зохион байгуулжээ. Ковид-19 цар тахалтай холбоотой авилгын талаарх мэдээлэл Камерун, Өмнөд Африк зэрэг олон орны эрүүл мэндийн салбарыг улам доройтуулжээ.

БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХ

Цар тахлын улмаас сургуулиуд хаагдаж, бусад сургалтын үйл ажиллагаа тасалдсан нь санаа зовоосон асуудал хэвээр байна. Сургууль хаагдсан, эрт болон албадан гэрлэлтийн түвшин өндөр байгаагаас үүдэн Чад улсад охидын сургуульд хамрагдалт 2017 онд 31% байсан бол 2021 онд 12% болж буурчээ. Өмнөд Африкт тавдугаар сарын байдлаар ойролцоогоор 750 000 хүүхэд сургуулиас завсардсан нь цар тахлын өмнөх үед 230 000 хүүхэд байсантай харьцуулахад гурав дахин их байна. 2 дугаар сард сургуулиуд үе шаттайгаар нээгдэж байсан ч зургадугаар сард дахин хаагдсан Уганда улсад суралцагчдын 30 гаруй хувь нь сургуульдаа буцаж ирэхгүй гэж тус улсын Үндэсний төлөвлөлтийн газар мэдэгдсэн.

Хямрал мөргөлдөөнд нэрвэгдсэн орнуудын хүүхдүүд боловсрол эзэмшихэд хамгийн хүнд бэрхшээлтэй тулгарлаа. Буркина Фасо, Камерун, Нигерт Боко Харам, GSIM, ISGS болон бусад зэвсэгт бүлэглэлүүд “Өрнөдийн боловсрол”-ыг хориглосоор байгаа бөгөөд сургуулиуд руу халдаж дайны гэмт хэрэг үйлдсээр байна. Түүний зэрэгцээ заналхийлэл, хүчирхийллийн улмаас багш нар ажилдаа явахаас эмээсээр байна. Буркина Фасод НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдээлснээр нийт 304564 суралч, 12480 багштай 2682 сургууль хаалттай хэвээр байв. Төв Африкийн БНУ-д СРС 1 дүгээр сараас 6 дугаар сарын хооронд дор хаяж 37 сургууль руу халдлага үйлдэн, эзлэн авжээ. Нигерт 6 дугаар сарын байдлаар Тиллабери бүс нутгийн 377 сургууль хаагдсан бөгөөд энэ хугацаанд улсын хэмжээнд 7-16 насны хүүхдүүдийн 50 гаруй хувь нь сургуульд хамрагдаагүй байна гэж НҮБ-ын Хүүхдийн сан мэдээлэв.

ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

Ковид-19 цар тахлын тархалтыг үл харгалзан хэд хэдэн улсад албадан газар чөлөөлөлт бүртгэгдсэн бөгөөд хэдэн арван мянган хүн орон гэргүй болжээ. Гана, Кени, Нигери улсад албадан газар чөлөөлөх ажлыг голчлон хотын төвүүдэд явуулж, хууль бус суурьшлын газар гэж үзсэн олон зуун байшинг нураажээ. Бүс нутаг дахь бусад албадан газар чөлөөлөлт нь эдийн засгийн ашиг сонирхлоос үүдэлтэй байсан. Уганда улсын Кирьяндонго дүүрэгт аж үйлдвэрийн газар тариалан эрхлэх төсөл хэрэгжүүлэхийн тулд 35 000 гаруй хүнийг гэр орноос нь албадан нүүлгэжээ. Зимбабве улсад түлшний компани өргөжүүлэхийн тулд олон мянган тосгоны оршин суугчдыг Чисумбанже дахь газраас нь хөөжээ.

Эерэг өөрчлөлтөөс дурдвал Кени, Уганда улсын шүүхүүд орон байртай байх эрхийг баталгаажуулж, албадан газар чөлөөлөлтийг буруушаасан. Кенийн Дээд шүүх 2013 онд нийслэл Найроби хотын албан бус суурин болох Сити Картоны оршин суугчдыг нүүлгэн шилжүүлсэн нь тэдний орон байртай байх эрхийг зөрчсөн гэж үзжээ. Уганда улсын Үндсэн хуулийн шүүх Зэрлэг амьтдыг хамгаалах газар Батвагийн уугуул иргэдийг тус улсын баруун өмнөд хэсэгт байдаг Мгахинга ой дахь өвөг дээдсийнх нь нутгаас хууль бусаар албадан нүүлгэсэн болохыг тогтоожээ.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРСААР

ЖАГСААЛ ЦУГЛААН БА ХҮЧ ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ

Ковид-19-ийн тархалтыг таслан зогсоох арга хэмжээ нь бүс нутаг даяар тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх болон бусад эрхийг нухчин дарах шалтаг болсоор байна. Камерун, Чад, Кот-д'Ивуар зэрэг олон засгийн газрын анхны алхам нь эрүүл мэнд, аюулгүй байдлын үүднээс тайван жагсаал хийхийг хориглох явдал байв. Харин Өмнөд Судан, Эсватини зэрэг оронд зохион байгуулагчдыг жагсаал болохын өмнө урьдчилан баривчилж, төлөвлөсөн жагсаалыг зогсоохын тулд интернэтийг тасалж байв. Аюулгүйн хүчнийхэн хоригоог эсэргүүцсэн зуу зуу, мянга мянган хүний тайван жагсаалыг хүч хэтрүүлэн хэрэглэж тараажээ. Ангол, Бенин, Чад, Эсватини, Гвиней, Нигер, Сьерра-Леон, Судан зэрэг 12 оронд аюулгүйн хүчнийхэн галт зэвсэг хэрэглэсний улмаас олон хүн амь үрэгджээ. Эсватинид 5 дугаар сард эхэлсэн ардчиллыг дэмжих жагсаал цуглааныг хүч хэрэглэн тарааснаар 10 дугаар сар гэхэд 80 хүн амиа алдаж, 200 гаруй хүн шархадсан юм. Суданд 10 дугаар сард болсон цэргийн эргэлтийг эсэргүүцсэн жагсаалыг тараахын тулд аюулгүйн хүчнийхэн байлдааны сум хэрэглэсний улмаас наад зах нь 53 хүн амиа алджээ.

Тайван жагсагчдыг хууль бусаар баривчлах явдал хаа сайгүй байна. Чад улсад сонгуулийн үйл явц, шилжилтийн засгийн газар байгуулахыг эсэргүүцсэн наад зах нь 700 хүнийг баривчилжээ. БНАКУ-ын Хойд Кивуд орон нутгийн эрүүл мэндийн захиргааны буруу менежментийг эсэргүүцэн тайван суулт зохион байгуулсны төлөө баривчлагдсан гурван идэвхтэн хоригдсон хэвээр байна. Эсватини улсад ардчиллыг дэмжигч дор хаяж 1000 жагсагч, түүний дотор 38 хүүхдийг хууль бусаар баривчилжээ.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД БА ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хүний эрхийг хамгаалах нь эр зориг шаардсан ажил хэвээр байгаа бөгөөд эрх баригчид хүний эрх хамгаалагчдын амыг таглах эсвэл гэмт хэрэгтэн болгохыг оролдсоор байна. Сөрөг хүчний идэвхтнүүдийн хамт тэднийг Бенин, Конго, БНАКУ, Эсватини, Кени, Нигер, Руанда, Сенегал, Танзани, Замби, Зимбабве зэрэг олон оронд баривчилж, хууль шүүхээр дарамталжээ.

БНАКУ-д олон улсын хориг арга хэмжээнд орсон хувь хүмүүс, аж ахуйн нэгжийн санхүүгийн гүйлгээг илчилсэн хоёр шүгэл үлээгчид цаазаар авах ял эчнээ оноожээ.

Руанда улсад YouTube-д видео бүтээгч Ивонн Айдаманж засгийн газрын бодлогыг шүүмжлсэн хэргээр 15 жилийн хорих ял авсан. Конго, Нигер, Замби болон бусад орны эрх баригчид шүүмжлэгчдийг айлган сүрдүүлэхийн тулд эрүүгийн хуулийн гүтгэлгийн гэмт хэргийн заалт ашиглав. Эсватинигийн терроризм, үймээн самууны тухай хуулийн дагуу шүүмжлэгчдийн эсрэг зохиомол хэрэг үүсгэжээ.

Зарим хүний эрх хамгаалагчид үйл хэргийнхээ төлөө амь насаа алдлаа. 7 дугаар сард Кени улсын хүрээлэн буй орчны төлөө тэмцэгч Жоанна Стючберигийн амь насанд олон удаа халдахаар заналхийлсний эцэст гэртээ буудуулж амиа алджээ. Мөн Сомалид хоёр сэтгүүлч амиа алдсан байна.

ТББ-уудын орон зайг хязгаарлах хууль, бодлогыг хэд хэдэн оронд нэвтрүүлсэн. Того улсад засгийн газар ТББ-д зөвшөөрөл олгох, сунгах ажлыг зогсоосон. Угандагийн засгийн газар ТББ-ын хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй гэсэн үндэслэлээр 54 байгууллагын үйл ажиллагааг нэн даруй түдгэлзүүлэхийг тушаажээ. Зимбабве улсын ТББ-ууд нийслэл Хараре хотод үйл ажиллагаа явуулахаасаа өмнө ажлын төлөвлөгөөгөө эрх баригчдад хүргүүлэхийг үүрэг болгов. Дээд шүүх уг захирамжийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзжээ. Улмаар хуульд сонгуулийн үеэр улс төрчдийг санхүүжүүлсэн, сурталчилгаа явуулсан гэж сэжиглэгдсэн байгууллагуудыг хаахыг зөвшөөрсөн нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газрууд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласаар байв. Ангол, Буркина Фасо, БНАКУ, Мадагаскар, Сенегал, Танзани, Того болон бусад оронд сонин хэвлэл, радио, телевизүүдийн үйл ажиллагааг түдгэлзүүлжээ. Гана, Замби зэрэг зарим орны эрх баригчид хэвлэл мэдээллийн байгууллагууд руу дайран орж, шууд нэвтрүүлгийг тасалдуулж, эд хөрөнгийг сүйтгэжээ. Түүнчлэн Замби улсад өнгөрсөн 6 дугаар сард үл мэдэгдэх хүмүүс Чиенги дүүргийн Калунгиши радио станцыг шатаасан юм. Нижерийн хэвлэл мэдээллийн байгууллагууд хэвлэл мэдээллийн зохицуулалтыг чангатгаж, мэдээлэл авах эрхэд заналхийлсэн хоёр хуулийн төслийг эсэргүүцэн “Мэдээллийн тасалдал” хэмээх кампанит ажил зохион байгуулжээ.

Эсватини, Нигер, Нижер, Сенегал, Өмнөд Судан, Судан, Уганда, Замби зэрэг улсад нийгмийн сүлжээг хориглож, интернэтийг хаасан байна. Өнгөрсөн зургадугаар сард Нигерийн эрх баригчид олон нийтийн дүрмийг зөрчсөн гэж ерөнхийлөгч Бухаригийн маргаантай жиргээг устгасных нь дараа Твиттерийн үйл ажиллагааг зогсоосон.

ДҮРВЭГСЭД, ЦАГААЧИД, ДОТООДОО ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ХҮНИЙ ЭРХ

Бүс нутаг даяар өрнөсөн хямрал мөргөлдөөн сая сая хүнийг орон гэрээсээ дүрвэхэд хүргэжээ. 2021 онд БНАКУ-д 1,5 сая хүн дүрвэсэн нь тус улсын нийт дүрвэгсдийн тоог 5 саяд хүргэсэн байна. Өмнөх жилүүдэд 2,6 сая гаруй хүн дотооддоо шилжин суурьшсан Сомали улсад 1 дүгээр сараас 8 дугаар сарын хооронд 573 мянган хүн орон гэрээ орхин дүрвэжээ. Бүс нутгийн ихэнх дүрвэгсдийг Камерун, Чад, БНАКУ, Этиоп, Кени, Нигер, Руанда, Судан зэрэг цөөн хэдэн улс хүлээн авч байсан ба Уганда улсад 1,5 сая гаруй буюу Африк тивд хамгийн олон дүрвэгч байна. Хачирхалтай нь Этиоп, БНАКУ зэрэг хүлээн авагч орнууд ч мөн адил олон тооны дүрвэгсдийг үүсгэжээ.

Бүс нутгийн бараг бүх дүрвэгсэд болон дүрвэгсдийн хуаранд хүмүүнлэгийн болон аюулгүй байдлын нөхцөл байдал сэтгэл түгшээсэн хэвээр байна. Зарим тохиолдолд хүмүүнлэгийн тусламж, хүртээмжийг хааж, хязгаарласан зэргээс шалтгаалан хүнс, ус, боловсрол, эрүүл мэнд, орон байрны хүрэлцээ хангалтгүй байх нь түгээмэл байв. Кенийн засгийн газар 3 дугаар сард НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн ДКГ-т Какума болон Дадааб дүрвэгсдийн хуаранг хаах 14 хоногийн хугацаатай тулган

шаардалт өгсөн. Хожим нь уг заналхийллээ буцааж, хуарангуудыг хаах хугацааг 2022 оны 6-р сар хүртэл хойшлуулсан юм. Нигерт ISGS Тахуа мужийн Интикане дахь Малийн дүрвэгсдийн суурьшсан газрууд руу дайрч, олон арван хүний аминд хүрсэн. Танзани улсад цагдаагийн болон тагнуулын байгууллагууд нь Бурунди улсын тагнуулын албатай хамтран хүчирхийлэл, хууль бусаар баривчлах зэргээр дүрвэгсдийг тус улсаас гарахыг албадаж байна.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ШООВДОРЛОЛТ

ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИДЫН ЭРХ

Африкийн орнуудад хүйсийн ялгаварлан гадуурхалт ба тэгш бус байдал газар авсан хэвээр байна. Бүс нутгийн хэмжээнд баримтжуулсан гол асуудалд жендэрт суурилсан хүчирхийлэл эрчтэй нэмэгдэж байгаа, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ ба мэдээллийн хязгаарлагдмал хүртээмж, эрт болон албадан гэрлэлт үргэлжилсээр байгаа, жирэмсэн охидыг сургуулиас хассаар байгаа зэрэг асуудал багтаж байна.

Ковид-19-ийн тархалтыг зогсоох зорилгоор засгийн газраас хэрэгжүүлсэн хязгаарлалтын арга хэмжээ нь бүс нутагт бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн түвшин огцом нэмэгдэхэд нөлөөлсөн. Өмнөд Африкт жендэрт суурилсан хүчирхийллийн өсөлт хямралын түвшинд хүрсэн бөгөөд албан ёсны гэмт хэргийн статистик мэдээгээр бүх төрлийн бэлгийн гэмт хэргийн тоо 74.1%-иар өсжээ. Мөн оны эхний хагаст эмэгтэйчүүдийн амийг хөнөөсөн дор хаяж 117 тохиолдол бүртгэгдсэн байна.

Бүс нутгийн жендэрт суурилсан хүчирхийллийн тодорхой тохиолдлууд олон нийтийн уур хилэнг төрүүлж, арга хэмжээ авахыг уриалав. 15 настай охиныг бүлэглэн хүчиндсэн үйлдлийг бичиж, нийгмийн сүлжээгээр тараасны дараа Чад улсын эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэл, гэмт этгээд ял завшдаг соёлыг эсэргүүцэн гудамжинд жагсаал хийжээ. Өмнөд Африкт 23 настай хуулийн ангийн оюутан Носисело Мтебениг найз залуу нь хөнөөсөн хэрэг олон нийтийн дургүйцлийг төрүүлсэн.

Жендэрт суурилсан хүчирхийлэл огцом ихэссэн хэдий ч хохирогчийг хамгаалах, дэмжих үйлчилгээ, түүнчлэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэл авах боломж бүс нутаг даяар хязгаарлагдмал хэвээр байна. Эрт болон албадан гэрлэлт олон оронд байсаар байна. Намибид дөрвөн настай охины эцэг эх нь түүнийг хоёр настай байхад нь 25 настай залуутай гэрлүүлсэн хэрэг гарчээ. Экваторын Гвинейд жирэмсэн охидыг сургуульд явахыг хориглосон хэвээр байна. Танзани улсын Боловсролын яам 11 дүгээр сард үүнтэй төстэй хоригийг цуцална гэж мэдэгдсэн.

Кот-д'Ивуар болон Мадагаскар улсад жендэрийн ялгаварлан гадуурхалтын тодорхой хэлбэрийг шийдвэрлэх хуулийн төслийг танилцуулсан. Суданы засгийн газар Мапутогийн протокол болон Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцыг соёрхон батлахыг зөвшөөрөв. Бусад эерэг мэдээлэл гэвэл Нигери дэх бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийг даван туулагчдыг дэмжсэн шийдвэр ба Руанда дахь үр хөндөлттэй холбоотой гэмт хэргээр хоригдож байсан 10 охид, эмэгтэйчүүдийг ерөнхийлөгчийн өршөөлөөр сулласан явдал зэргийг дурдаж болно.

АЛЬБИНИЗМТАЙ ХҮМҮҮС

Африкийн Зүүн болон Өмнөд бүс нутагт альбинизмтай хүмүүс болон тэдний гэр бүлийнхэн амь насаа алдах айдастай амьдарсаар байна. Альбинизмтэй хүмүүсийн эсрэг хүч хэрэглэсэн халдлага Малавид бүртгэгдэж, 2 дугаар сард нэг хүн амь үрэгдэж, 8 дугаар сард өөр нэг хүний цогцсыг олжээ. Замби улсад 6, 7 дугаар сард болсон тусдаа халдлагад хоёр ба есөн настай хоёр хүүхдийн биеийг зэрэмдэглэсэн байна.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

ЛГБТИ хүмүүс бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаа илэрхийлсний төлөө дарамт шахалт, баривчилгаа болон байцаан шийтгэх ажиллагаанд өртсөөр байна. Бенин улсад гурван трансжендэр эмэгтэйг Котону хотод бүлэг эрчүүд зодож, дээрэмдэхээсээ өмнө хувцсаа тайлахыг албадсан бөгөөд уг халдлагаа бичиж, нийгмийн сүлжээгээр тараажээ. ЛГБТИ хүмүүсийн эсрэг халдлага үйлдэх нь Сенегалд мөн түгээмэл бөгөөд консерватив бүлгүүд ижил хүйстнүүдийн зөвшилцсон бэлгийн харилцааг гэмт хэрэг гэж үзэхийг уриалсан жагсаал зохион байгуулжээ. Камерунд ийм үйлдэлд буруутгагдсан хоёр трансжендэр эмэгтэйд таван жилийн хорих ял оноосон ч давж заалдах шатны шүүх хурал болтол суллагадаад байв. Намиби улсад цагдаа нар трансжендэр эмэгтэйг ялаас зайлсхийхийн тулд нэрээ сольсон гэж буруутгаж, цагдан хорих газарт дарамтад оруулсан. Нигерийн Тараба муж улсад шинээр батлагдсан хуульд трансжендэр хүмүүсийг бүх насаар нь хорих заалт оруулжээ.

Кенийн Какума болон Дадааб дүрвэгсдийн хуаранд ЛГБТИ дүрвэгсэд дарамт шахалт болон халдлагад байнга өртдөг. Крестон Атухерва Какума хуаранд зориудаар гал тавьсан халдлагын улмаас хүндээр түлэгдэж, амиа насаа алдсан нь тус улсын засгийн газар ЛГБТИ дүрвэгсдийг ижил хүйстнүүдийн эсрэг дайралтаас хангалттай хамгаалж чадахгүй байгааг харуулсан.

Камеруны цагдаагийн ажилтнууд Баруун бүсийн Бафуссам дахь ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эмчлэх үйл ажиллагаа явуулдаг Колибри бүлгийн байр руу дайран орж, 13 хүнийг ижил хүйстний харьцаанд орсон гэх хэргээр баривчилсны дараагаар ХДХВ/ДОХ-ын шинжилгээ болон шулуун гэдэсний үзлэг хийсний эцэст суллажээ. ЛГБТИ хүмүүсийг гэмт хэрэгт тооцох хуулийн төслийг парламентад өргөн барьсан Гана улсад ЛГБТИ+ Rights Ghana байгууллагын албан тасалгаанд цагдаагийн ажилтнууд нэгжлэг хийж, үйл ажиллагааг нь зогсоожээ. Мөн цагдаа нар сургалтын үеэр ЛГБТИ 21 идэвхтэнг хууль бусаар цугларсан хэргээр баривчилжээ. Дараа нь тэдний эсрэг хэргийг хэрэгсэхгүй болгосон. Мадагаскар улсын Дотоод хэргийн яам жил бүр зохион байгуулдаг ЛГБТИ арга хэмжээг түдгэлзүүлэв.

Эерэг мэдээнээс дурдахад, Ботсвана улсын давж заалдах шатны шүүх ижил хүйстнүүдийн зөвшилцөлд тулгуурласан харилцааг гэмт хэрэгт тооцдог хуулийг үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн Дээд шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн, Угандад Клеопатра Камбугу өөрийнх нь эмэгтэй хүйсийг хүлээн зөвшөөрсөн Уганда иргэний үнэмлэх, паспорт авсан анхны транс эмэгтэй гэдгээ зарласан.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ДОРОЙТОЛ

Бүс нутгийн хэд хэдэн улс уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган гачигт нэрвэгдсэн. Анголд хур тунадас бага орсны улмаас сүүлийн 40 жилд болоогүй ган гачиг болжээ. Хоол хүнс, ундны ус, ариун цэврийн байгууламж хангалтгүйн улмаас хоол тэжээлийн дутагдал дээд цэгтээ хүрч, эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд ихээр өртөв. Мадагаскарын өмнөд хэсэг газар тариалан, мал аж ахуй, загас агнуурыг амьжиргаагаа залгуулах гол эх үүсвэр болгодог хүмүүст сөргөөр нөлөөлсөн хүчтэй ган гачигт нэрвэгдэв. Өмнөд Африкт 7-р сард Зүүн Кейп, Хойд Кейп, Баруун Кейп мужуудад гангийн гамшиг зарлав.

Ботсвана, Конго, БНАКУ, Гана, Намиби, Өмнөд Африк зэрэг хэд хэдэн оронд хүрээлэн буй орчны доройтолтой холбоотой санаа зовоосон асуудал үүсээд байна. Ботсвана, Намиби улсад уур амьсгалын өөрчлөлт, нутгийн уугуул иргэдийн эрх ашигт сөрөг нөлөө үзүүлж байгаа хэдий ч Канадын уул уурхайн ReconAfrica компанид Окаванго голын сав газарт газрын тосны хайгуулын лиценз олгосоор байна. Энэ талаар ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хороо мөн дурдсан байдаг. БНАКУ-ын өмнөд

хэсэгт орших Цикапа, Касай голууд болон тэдгээрийн цутгалуудад их хэмжээний бохирдол үүссэн. Анголын хойд хэсэгт байрлах алмаз олборлох, боловсруулах компаниас хаягдал ус алдагдсанаас болж бохирдол үүссэн гэж засгийн газар мэдэгдсэн. Энэ гамшгаас болж дор хаяж 40 хүн нас барж, олон зуун хүн суулгалт өвчнөөр өвчилсөн ба усны амьтан ургамал устжээ.

ЗӨВЛӨМЖ

Зарим зэрэг өөрчлөлт гарсан хэдий ч 2021 он Африк тивд хүний эрхийн хувьд хүнд жил байлаа. Африкийн засгийн газрууд болон холбогдох төрийн бус байгууллагууд жилийн турш үүссэн олон асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах шийдэмгий арга хэмжээг авах ёстой. Үүнд:

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч бүх тал энгийн номхон иргэд болон иргэний дэд бүтцийг онилсон халдлагыг зогсоох замаар энгийн номхон иргэдийг хамгаалах ёстой. Үүнд дүрвэгсэд болон дотооддоо шилжин суурьшсан хүмүүсийг хамгаалж, хоол хүнс, ус, орон байр зэрэг хүмүүнлэгийн тусламжаар бүрэн дүүрэн хангахын тулд бүх арга хэмжээг авах шаардлагатай байна.

Засгийн газрууд олон улсын эрх зүйг зөрчсөн хэрэгт нягт нямбай, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод мөрдөн байцаалт явуулж, гэмт хэрэг үйлдэгсдийг шүүхэд шилжүүлэх замаар ял завших явдалтай тэмцэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх ёстой.

Ковид-19-ийн вакцины нийлүүлэлт хүрэлцээгүй байгаа тохиолдолд засгийн газрууд хамгийн эрсдэлтэй бүлгүүд, түүнчлэн хүрэхэд хэцүү бүс нутагт вакцинжуулалтыг нэн тэргүүнд хийх ёстой. Ингэхдээ үндэсний эрүүл мэндийн тогтолцоогоо бэхжүүлэхийн төлөө бүс нутгийн болон олон улсын түвшинд хамтран ажиллаж, эрүүл мэндийн төсвийн талаар ил тод мэдээллээр хангах ёстой.

Засгийн газрууд эмэгтэйчүүд, охидын эрх тэгш байх эрх, эрүүл мэнд, мэдээлэл авах, боловсрол эзэмших эрхийг хамгаалах, тэднийг жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид амьдрах боломжоор хангах, түүний дотор ийм төрлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг Ковид-19-тэй холбоотой хязгаарлалтын үеэр цагдаагийн хамгаалалтад орох, шүүхэд хандах болон хамгаалах байр, тусламжийн утас, олон нийтийн туслах үйлчилгээнд хандах нөхцөлийг хангах арга хэмжээг нэн даруй авах ёстой.

Засгийн газрууд хүний эрх хамгаалагчид болон идэвхтнүүдийг дарамтлах буюу айлган сүрдүүлэхээ зогсоож, яллагдаж буй хүмүүст тулгаж буй бүх хэргийг хэрэгсэхгүй болгож, мөн хууль бусаар баривчлагдсан, шоронд хоригдсон хүмүүсийг нэн даруй, болзолгүйгээр суллах ёстой. Түүнчлэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэж, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг бие даан ажиллах боломжоор хангах ёстой.

АМЕРИК ТИВИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Ковид-19 цар тахлын хямралаас ч өмнө Америк тив дэлхийн аль ч бүс нутагтай харьцуулахад орлогын тэгш бус байдлын хамгийн өндөр үзүүлэлттэй байв. Оны туршид тус тивийн эдийн засгийн жигд бус сэргэлт нь олон арван жил ужгирсан бүтцийн тэгш бус байдлын өргөн хүрээтэй үр дагаварт дорвитой нөлөө үзүүлж чадсангүй. Цар тахлын үр дагаврыг арилгах янз бүрийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн хэдий ч олон орны засгийн газар хамгийн эмзэг бүлгийн хүн амынхаа нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг хамгаалж чадаагүй бөгөөд ялгаварлан гадуурхсан бодлого болон үйл ажиллагаагаараа тэдний нөхцлийг улам дордуулах нь түгээмэл байв.

2021 онд Америк тивд Ковид-19 цар тахлын улмаас 1,5 сая хүн амиа алдсан ба хүн амд ногдох нас баралтын тоогоор дэлхийд тэргүүлээ. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, тэгш бус байсан нь үүний гол шалтгаан бөгөөд эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилт муу, нийгмийн хамгааллын бодлого, арга хэмжээ нь гадуурхагдсан ард иргэдэд зохих ёсоор хүрч чадаагүй, вакцины хүрэлцээ хангалтгүй байдал нь нэрмээс болсон. Нутгийн уугуул иргэдэд цар тахлын үзүүлэх сөрөг нөлөө ариун цэврийн байгууламж, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамжийн хүртээмж хангалтгүй байгаагаас улам даамжирсан.

Олон орны засгийн газар бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд нэн тэргүүнд анхаарах талаар хангалттай ажил хийсэнгүй. Зайлшгүй шаардлагатай үйлчилгээ дутмаг байсан бөгөөд үр хөндөлтийн үйлчилгээг ихэнх улс оронд гэмт хэрэгт тооцсон хэвээр байв.

Эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл бүс нутаг даяар сэтгэл түгшээсэн асуудал хэвээр байв. Гэр бүлийн хүчирхийлэл, хүчин, аллага, эмэгтэйчүүдийг онилж хөнөөх зэрэг жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа ихэнх тохиолдолд хангалтгүй байв.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хэд хэдэн оронд аюулд өртсөн бөгөөд олон арван сэтгүүлч, засгийн газрын шүүмжлэгчдийг заналхийлж, цензурдэж, биед нь халдаж, баривчилжээ. Цагдаа болон аюулгүй байдлын бусад хүчнийхэн олон оронд хүч хэтрүүлэн хэрэглэх, үндэслэлгүйгээр баривчлан саатуулах, зарим тохиолдолд хууль бус аллага үйлдэх замаар тайван жагсаалыг нухчин дарж байв.

Эдгээр хүний эрхийн зөрчил болон олон улсын эрх зүйн бусад гэмт хэрэгт ял завших явдал бүс нутгийн улс орнуудын талаас илүүд нь ноцтой асуудал хэвээр байна. Шүүхийн хараат бус байдалд халдах явдал мөн нэмэгджээ.

Хүчирхийлэл, ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүний эрхийн зөрчлөөс болж хэдэн арван мянган хүн эх орноо орхин дүрвэжээ. Гэсэн хэдий ч олон орны засгийн газар дүрвэгсэд, орогнол хүсэгч, цагаачдыг хилээр нэвтрүүлэхийг хориглосоор байсан бөгөөд олон улсын хуулийг зөрчиж, тэдний нэхэмжлэлийг зохих ёсоор авч үзэлгүйгээр улсынх нь хилээр нэвтэрсэн хүмүүсийг албадан буцаажээ.

Латин Америк ба Карибын тэнгисийн орнуудын хүрээлэн буй орчны талаарх асуудлын мэдээллийн хүртээмж, олон нийтийн оролцоо, шударга ёсны тухай бүс нутгийн хэлэлцээр (Эсказугийн хэлэлцээр) дөрөвдүгээр сард хүчин төгөлдөр боллоо. Гэсэн хэдий ч олон оронд хүрээлэн буй орчныг сүйтгэх үйлдлүүд үргэлжилсээр байсан бөгөөд Америк тив нь хүрээлэн буй орчин, хүний эрхийн хамгаалагч хүмүүсийн хувьд дэлхийн хамгийн аюултай бүс нутгийн нэг хэвээр байна.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

Оны туршид эдийн засгийн өсөлт нэмэгдсэн хэдий ч эдгээр өсөлт нь ажилгүйдэл урьд хожид байгаагүйгээр өсөж, хүн амын орлого буурч, ядуурал ба тэгш бус байдал нэмэгдсэн 2020 оны эдийн засгийн уналтыг буцаахад хангалтгүй байв.

Аргентин, Бразил, Гватемал, Гаити, Никарагуа, Венесуэлд нөхцөл байдал онцгой хүнд байлаа. Зургадугаар сар гэхэд Аргентины хүн амын 40,6 хувь нь ядуу амьдарч байв. Бразилд хүн амын 56 хувь нь хүнсний аюулгүй байдлын асуудалтай тулгарсан. Гаитид хүн амын бараг тал хувьд хүнсний тусламж хэрэгтэй байв. Мөн Венесуэлд хүн амын 94,5 хувь нь орлогын ядууралтай, 76,6 хувь нь нэн ядуу амьдарч байжээ.

Бүс нутгийн хэмжээнд тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт түгээмэл хэвээр байна. НҮБ-ын Латин Америк, Карибын тэнгисийн Эдийн засгийн комиссын (ECLAC) мэдээлснээр тус бүс нутагт эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн дундаж түвшин 12,7 хувь, харин эрэгтэйчүүдийнх 9,7 хувь байв.

Олон орны засгийн газар хамгийн эмзэг нөхцөл байдалд байгаа хүмүүсийнхээ нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг хамгаалж чадаагүй бөгөөд зарим нь тэдний нөхцөл байдлыг улам дордуулсан. Тухайлбал, Парагвайд, ялангуяа нутгийн уугуул иргэд болон хөдөө орон нутгийн иргэдийн дунд, шүүхийн үр дүнтэй арга хэмжээ авахгүйгээр эсвэл шилжин суурьших өөр хувилбарыг санал болголгүйгээр албадан нүүлгэх явдал нэмэгджээ. “Албадан газар чөлөөлөлтийг зогсоох” кампанит ажлын тооцоолсноор цар тахлын үеэр 2020 оны 3-р сараас 2021 оны 10-р сарын хооронд Бразилийн 23 500 гэр бүлийг орон гэрээс нь албадан нүүлгэжээ. АНУ-д Дээд шүүх албадан газар чөлөөлөлтийг холбооны түвшинд түдгэлзүүлснийг сунгах оролдлогыг цуцаллаа.

Венесуэлд оны эхний хагаст улсын хүнсний түгээлтийн систем доголдож, хоол тэжээлийн хэрэгцээг хангаж чадахгүйд хүрсэн, эмнэлгийн тусламж, ундны ус, хоол хүнс, түлшний хангамж улам дордсоноос болж 3000 гаруй жагсаал цуглаан болжээ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ

Цар тахал нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, вакцины хүртээмж хязгаарлагдмал, тэгш бус байсан олон оронд сүйрлийн нөлөө үзүүлсээр байна.

Цар тахлын эхэн үеэс хойш Ковид-19-ийн улмаас 2,3 сая хүн нас барж, тус бүс нутаг дэлхийн нийт хүн амын дөнгөж 13 хувийг эзэлдэг ч дэлхийн нийт нас баралтын 45 хувийг эзэлж байна.

Улс орнууд нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээгээ үл тоомсорлож, хангалттай санхүүжүүл олгохгүй байх явдал өргөн дэлгэрсэн байсан нь хямралын цар хүрээ тэлэх гол шалтгаан болжээ. Хэд хэдэн оронд нэг хүнд ногдох эмч, сувилагчийн тоо дэлхийн хамгийн ядуу орнуудад эрүүл мэндийн үндсэн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай гэж ДЭМБ-аас тогтоосон босго хэмжээнээс хамаагүй доогуур байв.

Венесуэлд хувийн хамгаалалтын хэрэгсэл дутмаг байсан бөгөөд орон нутгийн ТББ-ууд 2020 оны 3-р сараас хойш 800 гаруй эрүүл мэндийн ажилтан Ковид-19-ийн улмаас нас барсан гэж мэдээлэв. Хүчилтөрөгч болон эмнэлгийн ор хүрэлцээгүй байсан зэрэг нь Перу улсыг нэг хүнд ногдох нас баралтын тоогоор хамгийн өндөр орон болоход нөлөөлсөн. Бразилд Ерөнхийлөгч Жаир Болсонаро Ковид-19 цар тахлын эсрэг үйл хайхарсан, үгүйсгэсэн, оппортунист, хүний эрхийг үл ойшоосон байдлаар хариу үйлдэл үзүүлэв.

8-р сарын сүүл гэхэд Хойд Америкийн хүн амын талаас илүү хувь нь Ковид-19-ийн вакцинд бүрэн хамрагдсан бол Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад хүн амын дөрөвний нэг нь бүрэн хамрагджээ. 9-р сард Дата өгөгдлийн **Airfinity** компани хөгжингүй орнууд 500 сая гаруй вакцины илүүдэл тун хадгалж байгааг мэдээлсэн.

Зарим өндөр орлоготой орнууд вакцины үйлдвэрлэлийг өргөжүүлэхийн эсрэг идэвхтэйгээр хориг тавив. Оны эцэс гэхэд Канад улс тус улсын эм үйлдвэрлэгч **Biolyse** компанид эхний 15 сая тун нь Боливи улсад очих Жонсон ба Жонсоны

вакцины 20 сая тунг үйлдвэрлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг олгоогүй байв.

Оны эцэс гэхэд Хойд болон Өмнөд Америкт вакцинд хамрагдалтын түвшин ижил байсан бөгөөд нийт хүн амын талаас илүү хувь нь вакцинд бүрэн хамрагдсан байв. Гэсэн хэдий ч бүс нутгийн улс орнуудын хооронд ихээхэн ялгаа байсан. Канад, Чили, Уругвай хүн амын дөрөвний гурав буюу түүнээс дээш хувь вакцинд бүрэн хамрагдсан бол энэ үзүүлэлт Гватемал, Венесуэл улсад хүн амын дөнгөж тавны нэг, Никарагуа, Гаитид тус бүр 6% ба 1% байв.

Засгийн газрын вакцинжуулалтын хөтөлбөрүүд нь Ковид-19-ийн халдвар авах эрсдэлтэй хүмүүсийг, тэр дундаа цагаачид, дүрвэгсдийг ихэвчлэн үл тоомсорлодог эсвэл зориудаар хасдаг байна. Олон улс орнууд уугуул иргэдийн соёлд тохирсон вакцинжуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх тусгай протокол бий болгож чадаагүй.

Зарим тохиолдолд эрүүл мэндийн ажилтнууд вакцинжуулалтын хөтөлбөрөөс хасагдаж байв. Тухайлбал, Никарагуад эрүүл мэндийн ажилтнууд бусад хүмүүсээс хамаагүй хойно буюу дөнгөж тавдугаар сард вакцинд хамрагдаж эхэлсэн байв. Зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр Ковид-19-ийн эрсдэлийн үнэлгээнээс үл хамааран засгийн газрын дэмжигчдийг илүү вакцинжуулж байгааг онцолсон.

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийг нэн тэргүүнд тавих талаар олон засгийн газрууд хангалттай ажил хийгээгүй. Зайлшгүй шаардлагатай үйлчилгээ дутмаг байсан бөгөөд аюулгүй үр хөндөлтийн үйлчилгээг ихэнх улс оронд гэмт хэрэгт тооцсон хэвээр байв. Бүгд Найрамдах Доминикан, Эль Сальвадор, Гаити, Гондурас, Ямайка болон Никарагуа улсад үр хөндөлтийг ямар ч тохиолдолд хориглосон хэвээр байна.

Аргентин улс 2020 оны сүүлээр жирэмсний эхний 14 долоо хоногт үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэхээс татгалзаж, хуулиар зөвшөөрдөг болсон ч бусад улс орнууд ийнхүү ахиц гаргасангүй. Чилид жирэмсний эхний 14 долоо хоногт үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэхгүй байх хуулийн төслийг өргөн барьсан ч дэмжээгүй. Колумбид Үндсэн хуулийн шүүх Кауса Жуста хэмээх ТББ-уудын эвслийн үүсгэсэн үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх хэргийг шийдвэрлэж чадаагүй. Доминиканы БНУ, Сальвадор улсад үр хөндөлтийг дээрхээс илүү хязгаарлагдмал нөхцөлд гэмт хэрэгт тооцохгүй байх хүчин чармайлт парламентын дэмжлэг авч чадсангүй.

Нэгдүгээр сард Гондурас улсын Конгресс үр хөндөлтийг хуулиар зөвшөөрөх боломжтой аливаа хууль тогтоомж батлахыг хориглосон Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг баталсан. Дээд шүүхэд үр хөндөлтийг бүрэн хориглохын эсрэг давж заалдсан хэрэг оны эцсийн байдлаар шийдвэрлэгдээгүй байв.

АНУ-д муж улсын засгийн газрууд 2021 онд өмнөх жилүүдтэй харьцуулахад үр хөндөлтийг хязгаарлах илүү олон хууль тогтоомжийг өргөн барьсан. Техас мужид үр хөндөлтийг бараг бүхэлд нь хориглож, жирэмсний зургаан долоо хоногоос эхлэн үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохоор болсон байна.

4-р сард Эквадорын Үндсэн хуулийн шүүхээс хүчиндүүлсэн тохиолдолд үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй гэсэн шийдвэр гаргасан нь ахиц дэвшил гаргасан цөөхөн орны нэг жишээ болно.

УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ

Америк тивийн уугуул ард түмэнд ус, ариун цэврийн байгууламж, эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын эрх, түүнчлэн тэдний эрүүл мэнд, амьжиргааны эрхийг хамгаалах соёлын зохистой механизм дутмаг байсаар байгаа нь Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг улам дордуулжээ.

Аргентин, Бразил, Боливи, Канад, Колумби, Эквадор, Никарагуа, Парагвай, Венесуэлийн уугуул иргэдэд тун ч ноцтой хүндрэл бэрхшээл тохиолдож байлаа.

Бразил улсын уугуул иргэдэд газар нутгийг нь түрэмгийлэх, ой модыг устгах, уул

уурхай болон Ковид-19-ийн тархалтаас хамгаалах хамгаалалт дутмаг байна. 8-р сард Бразилийн Уугуул иргэдийн үзэл бодол хэмээх ТББ Болсонарогийн засгийн газрыг геноцид болон эхоцидын гэмт хэрэгт буруутгасан анхны мэдэгдлийг Олон улсын эрүүгийн шүүхэд хүргүүлэв.

Мексик, Гватемал, Гондурас, Парагвай, Перу, Венесуэл зэрэг олон орны засгийн газар уугуул иргэдэд урьдчилан мэдэгдэлгүй, тэдний зөвшөөрлийг авалгүйгээр томоохон хэмжээний олборлолт, хөдөө аж ахуй, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн бөгөөд зарим тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх шүүхийн шийдвэрийг үл тоомсорлон үргэлжлүүлж байна.

Боливи, Перу, Колумби, Никарагуа, Парагвай, болон Чилид нутгийн уугуул иргэд улсын аюулгүй байдлын хүчнийхэн болон зэвсэглэсэн энгийн иргэдийн довтолгооны улмаас шархдах буюу улмаар амь насаа алджээ.

Канадад тус улсын засгийн газраас байгуулсан сүмийн хуучин сургуулиудын орчмоос олон зуун уугуул хүүхдийн шарилыг олжээ. Олон уугуул иргэд, нийгэмлэгүүд, байгууллагууд болон хамтын зөвлөлүүд үүнийг геноцид хэмээн буруутгаж, шударга ёсыг тогтоохыг уриалав. Есдүгээр сард Канадын Холбооны шүүхээс Оттавад гэр бүлээсээ албадан тусгаарлагдсан 50 000 орчим уугуул хүүхэд тус бүрд 40 000 ам.доллар төлөхийг үүрэг болгосон.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ БОЛОН ХУРАН ЧУУЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран чуулах эрх бүс нутгийн хэд хэдэн оронд заналхийлэлд өртөөд байна.

Бразил, Куба, Эль-Сальвадор, Канад, Гватемал, Мексик, Никарагуа, Уругвай, Венесуэл улсад сэтгүүлчид болон засгийн газрыг шүүмжлэгчдийг айлган сүрдүүлж, дарамталж, заналхийлж, цензүрдэж, гэмт хэрэгтэнд тооцож, эсвэл олон нийтийн мэдээллийн сүлжээнд нэвтрэхийг хоригложээ.

Хоёрдугаар сард Америк хоорондын Хүний эрхийн Комисс (IACHR) дарамт шахалт, заналхийлэл, айлган сүрдүүлэлтэд өртсөн Сальвадорын Эль-Фаро дижитал сонины 34 ажилтныг хамгаалах арга хэмжээ авсан байна. Венесуэлд хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэвтрүүлгийг хориглож, төрийн өндөр албан тушаалтныг гүтгэсэн хэргээр нэгэн томоохон сониныг торгожээ. Сэтгүүлчдийн эсрэг 290 гаруй халдлага үйлдэгдсэн гэж орон нутгийн ТББ мэдээлэв.

Колумбид нийгмийн эсэргүүцлийн хөдөлгөөнийг баримтжуулсан хэвлэл мэдээллийнхний эсрэг 402 удаа халдлага үйлдэгдсэн тухай Хэвлэлийн эрх чөлөөний сангаас мэдээлсэн. Куба улсад 7-р сарын 11-нд сүүлийн хэдэн арван жилд болсон хамгийн том жагсаалын дараа цагдаа болон засгийн газрын дэмжигчид хэвлэл мэдээллийн хэрэгсэл рүү хүчирхийлэн халдаж, дор хаяж 10 сэтгүүлчийг баривчилсан тухай мэдээллийг Америк хоорондын Хүний эрхийн Комисс (IACHR) хүлээн авсан байна. Колумби, Куба, Мексик, АНУ, Венесуэлд тайван жагсаал цуглааныг хязгаарлах, хориглох, улмаар хэлмэгдүүлсэн нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг улам дордуулж байна. Колумбын засгийн газар 7-р сарын 20-нд олон хотуудад зохион байгуулахаар төлөвлөж байсан эсэргүүцлийн жагсаалд хүмүүсийг оролцуулахгүйн тулд тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн хязгаарлах арга хэмжээг авчээ. Куба улсад 7-р сарын 11-нд болсон түүхэн жагсаалын үеэр олон зуун хүн баривчлагдсан бөгөөд 10-р сард тэднийг суллахыг уриалсан өөр нэг жагсаалыг засгийн газар хориглов. Түүний зэрэгцээ АНУ-ын хууль тогтоогчид дор хаяж 36 муж улс болон холбооны түвшинд хуран чуулах эрх чөлөөг хязгаарласан 80 гаруй хуулийн төсөл өргөн барьсан бөгөөд есөн муж улс ийм төрлийн 10 хуулийн төслийг батлаад байна.

ХҮЧ ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ

Колумб, Чили, Гондурас, Мексик, Парагвай, Пуэрто-Рико, Венесуэл зэрэг олон оронд эсэргүүцлийн жагсаалыг дарахын тулд хүч хэтрүүлэн хэрэглэжээ.

Дөрөв, тавдугаар сард Колумбын Үндэсний ажил хаялтын жагсаалын үеэр 46 хүн нас барсан (44 энгийн иргэн, 2 цагдаа) болон бэлгийн хүчирхийллийн 49 хэргийг НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар баталгаажуулсан. Венесуэлд цагдаа, цэрэг, засгийн газрыг дэмжигч зэвсэгт бүлэглэлүүд дор хаяж 59 жагсаал цуглаанд халдсан бөгөөд үүний улмаас нэг жагсагч амиа алдаж, долоон хүн шархадсан байна.

Мексикт цагдаа нар жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг жагсаал хийж буй эмэгтэйчүүдийн дуу хоолойг хорихын тулд шаардлагагүй үед хүч хэтрүүлэн хэрэглэж, үндэслэлгүйгээр баривчилж, тэр ч байтугай бэлгийн хүчирхийлэл үйлдсэн байна.

Чили улсад 2019 оны аравдугаар сард эсэргүүцлийн жагсаал эхэлснээс хойш төрийн албан хаагчдын үйлдсэн хүчирхийллийн 8000 гаруй хохирогч байгааг Улсын Прокурорын газар болон Хүний эрхийн үндэсний хүрээлэнгийн шинэчилсэн тоо баримт харуулсан.

Мөн цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд хүч хэтрүүлэн хэрэглэсэн нь хүний амь нас эрсдэхэд хүргэжээ. Эль Сальвадор улс цагдаа нарын аллагын хэргээр хамгийн өндөр үзүүлэлттэй хэвээр байна. Бразилийн Рио-де-Жанейро хотод 5-р сарын 6-нд цагдаа нар хамгийн олон хүнийг хөнөөсөн өдөр болсон ба тус хотын Жакарезиньо фавелагийн 27 оршин суугч амиа алджээ. 11-р сард Рио-де-Жанейрогийн **Complexo do Salgueiro favela**-д цагдаагийнхны явуулсан өөр нэг ажиллагааны улмаас есөн хүн нас барсан юм.

Өнгөрсөн арваннэгдүгээр сард Аргентины Буэнос-Айрес хотын цагдаа нар 17 настай хөлбөмбөгчин Лукас Гонзалесыг хүнсний дэлгүүр орчихоод явж байхад машинд нь буудан хөнөөжээ.

АНУ-д дор хаяж 888 хүн галт зэвсэг хэрэглэсэн цагдаа нараас болж амь үрэгдсэн бөгөөд үүнд хар арьстнууд харьцангуй ихээр өртлөө. АНУ-ын зургаан муж улсад хүч хэрэглэх тухай дүрэм журам байхгүй хэвээр байгаа бөгөөд тийм дүрэм журамтай муж улсуудын нэг нь ч олон улсын хууль тогтоомж, амь насанд хөнөөлтэй хүч хэрэглэхтэй холбоотой стандарттай нийцээгүй байна. Мөн АНУ-ын Сенат Жорж Флойдын хэрэгт хариуцлага тооцуулах болон цагдаагийн үйл ажиллагааны тухай хууль буюу АНУ-ын цагдаагийн үйл ажиллагааны зарим хэсгийг шинэчлэхэд чиглэсэн хоёр намын багц санал бүхий хуулийн төслийг өргөн барьж чадаагүй. Хууль бусаар хорьж саатуулах ба хүчээр сураггүй болгох

Колумб, Куба, Мексик, Никарагуа, Венесуэл зэрэг олон оронд болон Гуантанамо Бэй дэх АНУ-ын тэнгисийн цэргийн баазад хууль бусаар хорьж саатуулах тохиолдол бүртгэгдсэн.

“Эрх чөлөөг хамгаалах” кампанит ажлын мэдээлснээр Колумбын Үндэсний ажил хаялтын хүрээнд 3275 хүнийг хууль бусаар хорьж саатуулсан байна. Хүчээр сураггүй болгох асуудлаарх ажлын хэсэг оны эцэст 327 сураггүй алга болсон хүмүүсийн хаана байгаа нь тодорхойгүй байгаа тухай мэдээлжээ.

Кубын эрх баригчид 7-р сарын 11-ний жагсаалын үеэр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх эрхээ эдэлсэн олон зуун хүнийг үндэслэлгүйгээр шоронд хорьжээ.

Никарагуад 11-р сард Ерөнхийлөгч Даниэль Ортегаг дахин сонгогдохоос хэдхэн сарын өмнөхөн цагдаа нар олон арван хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчид болон засгийн газрыг эсэргүүцэгчдийг, тэр дундаа ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших магадлалтай долоон хүнийг хууль бусаар саатуулах буюу хүчээр сураггүй болгожээ.

Венесуэлийн хүний эрхийн Фором Пенал байгууллагын мэдээлснээр тус улсын аюулгүй байдлын хүчнийхэн оны туршид 44 улс төрийн идэвхтэн, оюутан, хүний эрхийн хамгаалагчдыг хууль бусаар хорьж саатуулсан байна. Зарим саатуулагдсан хүмүүс нас барсан бөгөөд тэдний гурав нь улс төрийн сэдлээр үндэслэлгүйгээр саатуулагдаж байжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Байден Гуантанамо дахь АНУ-ын Тэнгисийн цэргийн бааз дахь хорих газрыг хаахыг зорьж байгаагаа мэдэгдсэн ч 39 эрэгтэй тодорхойгүй хугацаагаар, шалтгаангүйгээр тэнд хоригдсон хэвээр байгаа ба тэдний 10-т цаазаар авах ял оноож болзошгүй байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧИД

Америк тив нь хүний эрхийг хамгаалахад дэлхийн хамгийн аюултай бүс нутгийн нэг хэвээр байв.

Бразил, Колумб, Гватемал, Гаити, Гондурас, Мексик, Перу, Венесуэл зэрэг хэд хэдэн оронд хүний эрхийн хамгаалагчид амь насаа алдлаа.

Global Witness ТББ-ын тайланд Колумб улсыг дэлхий дээр хүрээлэн буй орчны болон хүний эрхийн хамгаалагчдын эсрэг хамгийн олон халдлага үйлдсэн орон гэж тодорхойлсон.

Мөн Боливи, Чили, Куба, Эквадор, Сальвадор, Никарагуа, Гватемал, Гондурас, Мексик, АНУ-д хүний эрхийн хамгаалагчид заналхийлэл, хүчирхийлэл, мөрдөн байцаалт, үндэслэлгүйгээр хорьж саатуулах болон хууль бус мөшгин хяналтад өртөж байсан.

Венесуэлд хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдал огцом муудсан орон болжээ. “Хүний эрхийн хамгаалагчид ба шударга ёс төв”-ийн мэдээлснээр 2021 онд идэвхтнүүд рүү халдсан 743 тохиолдол гарсан нь 2020 онтой харьцуулахад 145%-иар өссөн байна.

ЯЛ ЗАВШИХ ЯВДАЛ БОЛОН ШУДАРГА ЁСЫГ ТОГТООХ

Олон улсын эрх зүйгээр хориглосон хүний эрхийн зөрчил, гэмт хэрэгт ял завших, түүнчлэн шударга ёс, үнэн мөнийг тогтоолгох, нөхөн төлбөр авах боломж хомс байгаа нь бүс нутгийн улс орнуудын талаас илүүд нь ноцтой асуудал хэвээр байна.

Бразил, Боливи, Парагвай, Сальвадор, Гватемал, Гондурас, Никарагуа, Венесуэл улсад шүүхийн хараат бус байдалд халдсаар байв. Тухайлбал, Эль Сальвадор улсад Хууль тогтоох Чуулганаараа шүүхийн бие даасан байдлыг хязгаарласан хэд хэдэн арга хэмжээ, түүний дотор Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын гишүүд болон Ерөнхий прокурорыг огцруулах зэрэг арга хэмжээг авчээ. Гватемал улсад хүний эрхийг ноцтой зөрчсөн, авлигын хэргүүдэд ял завшихын эсрэг тэмцэлд гол үүрэг гүйцэтгэдэг шүүхийн гишүүдийг албан тушаалаас нь чөлөөлөх буюу албан тушаалаа гүйцэтгэхэд нь саад тотгор учруулсан.

11-р сард болох байсан сонгуулийн өмнөхөн Никарагуа улсын Ерөнхийлөгч Даниэль Ортега дарангуйлах тактикийг хэрэгжүүлэхийн тулд шүүх болон хууль тогтоох байгууллагуудыг үргэлжлүүлэн ашигласаар байхад түүний удирдлаган дор төрийн албан хаагчдын үйлдсэн хүний эрхийн зөрчлийн хохирогч болсон олон мянган хүн шударга ёс тогтоохыг хүлээж байв.

Венесуэлд хууль шүүхийн тогтолцоо нь засгийн газрыг эсэргүүцэгчдийг төрийн зүгээс нухчин дарахад чухал үүрэг гүйцэтгэсэн бол хүний эрхийн зөрчил болон гэмт хэргийн хохирогчид хамгаалалтгүй үлджээ. 11-р сард ОУЭШ-ийн прокурор Карим Хан нь Венесуэлд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүйг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлж байгаагаа зарласан.

Аргентин, Перу, Уругвай улсад 1970, 1980, 1990-ээд онд үйлдэгдсэн, олон улсын хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээх ёстой хэргүүдэд сэжиглэгдсэн хүмүүсийн хэргийг шүүхээр шийдвэрлэх талаар тодорхой ахиц дэвшил гарсан.

4-р сард АНУ-ын засгийн газар ОУЭШ-ийн Прокурорын газрын ажилтнуудын эсрэг өмнөх засаг захиргааны тавьсан хориг арга хэмжээгээ цуцалсан боловч Афганистан, Ирак болон бусад газарт АНУ-ын цэргийн албан хаагчдын үйлдсэн дайны гэмт хэрэгт ОУЭШ-ийн харьяаллаас татгалзсаар байна.

ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИДЫН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

Бүс нутгийн хэмжээнд эмэгтэйчүүд, охидыг хамгаалах арга хэмжээ хангалтгүй, жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа дутуу дулимаг байх нь түгээмэл байв.

Тухайлбал, Мексикт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өргөн тархсан хэвээр байна. Оны туршид 3427 эмэгтэйг хөнөөсөн хэрэг бүртгэгдсэнээс 887 нь феминиздийн (эмэгтэй жендэрийн улмаас алагдаж, амь насаа алдсан) хэргээр шалгагдаж байна. Мексикийн Ерөнхий прокурорын газраас амь насаа алдахаасаа өмнө алга болсон эмэгтэйчүүдийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаа ноцтой алдаатай байсан. Мексикийн аюулгүй байдлын албаныхан жагсагч эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэж, үндэслэлгүйгээр баривчилж, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн байна.

“Колумбын Феминизид гэмт хэргийг ажиглах төв” оны эхний найман сард 432 хэргийг мэдээлсэн ба Колумб улсад аюулгүй байдлын албаныхан эмэгтэйчүүдийн эсрэг байнга бэлгийн хүчирхийлэл үйлджээ.

Гватемал улсын Прокурорын газар 2021 онд эмэгтэйчүүдийн эсрэг гэмт хэрэг хамгийн олон тоогоор үйлдэгдсэн болохыг нотолсон бөгөөд оны эхний найман сард 396 эмэгтэй амиа алдсан нь 2020 оны мөн үеийнхээс 31 хувиар өсжээ.

Парагвай болон Пуэрто-Рико улсын аль алинд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл өссөн тул онц байдал зарлав. Түүнчлэн Перу, Уругвайд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ихээхэн нэмэгдсэн байна. Пуэрто Рикод 5-р сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн 511 хэрэг бүртгэгдсэн нь 2020 оны мөн үетэй харьцуулахад огцом өссөн үзүүлэлт юм. Перуд 2020 оны мөн үед 78 феминизид хэргийн хохирогч байсан бол энэ жил 107 хохирогч бүртгэгдсэн байна. Цаашилбал, 10 792 эмэгтэй ор сураггүй алга болсон бөгөөд 1-р сараас 10-р сарын хооронд Перу дахь сураггүй алга болсон гэж мэдээлсэн хэргийн 25% нь феминизид гэмт хэрэг байв.

Венесуэлийн Ерөнхий Прокурорын газар жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн мөрдөн байцаалтаар мэргэшсэн 72 прокурорын газар байгааг зарлав. Гэсэн хэдий ч орон нутгийн ТББ-ууд тэдний үр дүнтэй ажиллаж байгаа эсэхэд эргэлзэж байгаа бөгөөд “Шударга ёс, энх тайвны төв” 1-р сараас 6-р сарын хооронд 125 феминизидын хэргийг баримтжуулсан байна.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Америк тивд ЛГБТИ хүмүүсийн эрхийг хүлээн зөвшөөрөх тал дээр тодорхой ахиц дэвшил гарсан боловч ерөнхий хууль тогтоомж батлахад хаалт хийсээр байгаа бөгөөд, хэд хэдэн оронд ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, аллагын бай болсон хэвээр байна.

Аргентин улс **нон байнери** гэж өөрсдийгөө тодорхойлдог хүмүүст шинэ иргэний үнэмлэхийг нэвтрүүлсэн бөгөөд 6-р сард Конгресс трансжендэр хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийг баталсан.

АНУ-д Байдену засаг захиргаа өмнөх засаг захиргааны ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах бодлогыг цуцлах арга хэмжээ авсан хэдий ч ЛГБТИ хүмүүсийн эрхийг хязгаарласан муж улсын хэмжээний олон зуун хуулийн төсөл өргөн баригдаад байна.

Америк тивийн аль ч оронд ЛГБТИ хүмүүс хүчирхийллийн улмаас амь насаа алдсаар байна. Трансжендэр нийгэмлэгийн сүлжээнээс Бразил улсад оны эхний хагаст 80 трансжендэр хүн амиа алдсан, Колумб улсад 11-р сар гэхэд 30 транс хүн амиа алдсан гэж мэдээлсэн.

ДҮРВЭГСЭД БОЛОН ЦАГААЧДЫН ЭРХ

Оны туршид Гватемал, Гаити, Гондурас, Венесуэл улсуудаас олон арван мянган хүн хүчирхийлэл, ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хүний эрхийн зөрчлөөс үүдэн эх орноосоо дүрвэсэн.

Канад, Чили, Мексик, Перу, Куракао, Тринидад, Тобаго, АНУ зэрэг орны засгийн газрууд дүрвэгсэд, орогнол хүсэгч, цагаачдыг хилээр нэвтрүүлэхийг хориглож, хилээр нэвтэрч чадсан дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг зохих ёсоор авч хэлэлцэлгүйгээр албадан буцаажээ.

АНУ-ын хилийн хяналтын ажилтнууд Ковид-19 нийгмийн эрүүл мэндийн заалтыг шалтаг болгож АНУ-Мексикийн хил дээрх нэг сая гаруй дүрвэгсэд болон цагаачдыг бөөнөөр нь буцаажээ. Эдгээр хууль бус албадан буцаалтын дотор харгалзах хүнгүй хэдэн арван мянган цагаач хүүхдүүд байв.

Канад улсын авч хэрэгжүүлсэн цагаачдыг хорьж саатуулах ажиллагаа нь олон улсын хүний эрхийн хууль, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхдүүдийн эрхийг зөрчсөн хэвээр байна.

Мексик улс олон мянган цэргийг Гватемал улстай хиллэдэг өмнөд хилээ хаахаар илгээв. Цагаачлалын албаны эрх баригчид олон мянган хүнийг Гватемал руу хууль бусаар буцааж буюу албадан гаргаж, асран хамгаалагчгүй хүүхдүүдийн эрхийг зөрчин тэднийг олж илрүүлж, хорьж саатуулах буюу эх оронд нь буцаах томоохон ажиллагааг өөрийн улсад явуулсан.

Ихэнх нь Венесуэлээс гаралтай олон мянган хүмүүс Чили рүү явганаар нэвтрэхийг оролдсон бөгөөд дор хаяж 18 хүн замдаа нас баржээ. Дөрөвдүгээр сард Чили улс цагаачдыг эрх зүйн статусаа хууль ёсны болгоход шинэ хязгаарлалт тавьж, олон зуун хүнийг зохих журмыг мөрдөлгүйгээр албадан гаргажээ.

Перу улсад нэг сая орчим цагаач, түүний дотор хагас сая орчим орогнол хүсэгч эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг эрхээ эдэлж чадахгүй байна.

Хэдэн арван мянган Гайтийн дүрвэгсэд олон улсын хамгаалалт хүссэн боловч бүс нутгийн засгийн газрууд тэднийг баривчлах, хууль бусаар буцаах, сүрдүүлэн мөнгө авах, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах болон зэвсэгт бүлэглэлүүдийн жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг олон төрлийн хүчирхийлэлээс хамгаалж чадаагүй юм.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ ЧАДСАНГҮЙ

Жилийн туршид эерэг өөрчлөлт гарсан хэдий ч уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээ хязгаарлагдмал хэвээр байгаа нь эргээд тус тив даяар хүний эрхийг зөрчигдөхөд хүргэж байна.

“Эсказугийн хэлэлцээр” дөрөвдүгээр сарын 22-нд хүчин төгөлдөр болсон ч оны эцэс гэхэд Куба болон Венесуэл улс гарын үсэг зураагүй байсан бөгөөд 12 орон соёрхон батлаагүй байв.

Өнгөрсөн 2-р сард АНУ-ын шинэ засаг захиргаа Парисын хэлэлцээрт дахин нэгдэж, өмнөх засаг захиргааны үед хүрээлэн буй орчин, эрчим хүчний салбарын зохицуулалтыг багасгах зорилгоор баталсан олон зуун хууль, бодлогыг цуцлахыг хичээсэн.

Гэсэн хэдий ч бусад улс орнууд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх ахиц дэвшил урам хугармаар байдалтай байв. Бразилийн Ерөнхийлөгч Болсонаро Амазон дахь ой модыг устгах болон байгалийн баялгийн олборлолтыг дэмжсэнээр уугуул иргэдийн газар нутагт уур амьсгалын хямралын нөлөөг улам хурцатгаж, хүрээлэн буй орчны сүйрлийн өв үлдэв. Имазон ТТБ-ын мэдээлснээр Бразилийн Амазон 8-р сард сүүлийн 10 жилд хамгийн их ой мод устсан байна. Боливи улс мод бэлтгэх, ой модыг шатаахыг дэмжсэн журам баталжээ. Канад улс чулуужсан түлшний

үйлдвэрлэлд татаас өгсөөр байв. АНУ-ын шинэ засаг захиргаа уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар дэлхийн бусад улстай дахин хамтран ажиллаж байгаа хэдий ч холбооны засгийн газрын эзэмшлийн нутаг дэвсгэр дээр газрын тосны өрөмдлөгийн төслүүдэд үргэлжлүүлэн зөвшөөрөл олголоо. Мөн дэлхийн 11 дэх том хүлэмжийн хий ялгаруулагч болох Мексик улс НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх бага хуралд хүлэмжийн хийн ялгаруулалтаа бууруулах шинэ зорилт танилцуулсангүй.

ЗӨВЛӨМЖ

Засгийн газрууд аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр эрүүл мэндийн эрхийг хангах үүрэгтэй бөгөөд гадуурхагдсан бүлэг болон Ковид-19-ийн эрсдэлд өртсөн бусад хүмүүст онцгой анхаарал хандуулах ёстой. Түүнчлэн иргэдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах ёстой бөгөөд нутгийн уугуул ард түмний эсрэг түүхэн шоовдорлолт, ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлүүд зэрэг ялгаварлан гадуурхалт болон шоовдордолтын олон хэлбэрт давхар өртсөн хүмүүст цар тахлын үзүүлж буй хэт сөрөг үр нөлөөг арилгахад онцгой хүчин чармайлт тавих ёстой. Мөн бэлгийн болон нөхөн үржихүйн эрх, тэр дундаа үр хөндөлтийн аюулгүй үйлчилгээ авах эрхээр хангах ёстой.

Засгийн газрууд иргэдийнхээ үзэл бодлоо илэрхийлэх, хуран чуулах эрх чөлөөг хүндэтгэж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэр дундаа сэтгүүлчдийг хууль ёсны ажлаа аливаа дарамт шахалт, хүчирхийллээс ангид хийх боломжоор хангах ёстой. Мөн хүний эрхийн хамгаалагчдын хөдөлмөрийг хууль ёсоор хүлээн зөвшөөрч, ажлаа аюулгүй явуулах нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн эсэргүүцэл буюу шүүмжлэлийн эсрэг харгис хариу арга хэмжээ авах, өрсөлдөгчдөө дүүгүй болгохын тулд үндэслэлгүйгээр баривчлах, албадан сураггүй болгох зэргээ зогсоох ёстой.

Засгийн газрууд хууль сахиулах ажиллагааны дүрэм журам болон үйл ажиллагаа нь олон улсын жишигт нийцэж байгаа эсэхийг нягталж, хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд зохих ёсоор шалгаж, эрүүгийн хариуцлагад сэжиглэгдэж буй этгээдийг шударгаар шүүх ёстой. Түүнчлэн шүүхийн хараат бүс байдлыг алдагдуулахаас зайлсхийх ёстой бөгөөд ингэснээр иргэдийн шударга ёс, үнэн мөнийг тогтоолгох, хохирлыг барагдуулах эрх нь бодитоор хангагдана. Засгийн газрууд жөндөр, бэлгийн чиг баримжаа, хувь хүний ялгаатай байдал дээр суурилсан хүчирхийллийн хэрэгт ял завших асуудлыг гаргуулахгүй байх ёстой. Мөн эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл, түүний үндсэн шалтгааныг арилгах, ЛГБТИ хүмүүсийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах, тэдэнд тулгарч буй хүний эрхийн зөрчлийн үндэс болсон ялгаварлан гадуурхалтыг устгахын тулд яаралтай арга хэмжээ авах ёстой.

Засгийн газрууд олон улсын хамгаалалт эрж буй хүмүүсийг хамгаалах үүргээ биелүүлж, тэдний эрхийг хүндэтгэн хамгаалж, тогтвортой шийдэл олтол нутаг дэвсгэр дээрээ зохистой нөхцөлд үлдэх боломж олгох ёстой.

АЗИ-НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2021 оны туршид Ази-Номхон далайн бүс нутгийн хэд хэдэн улс хүний эрхийн гүнзгий хямралд өртлөө. Мьянмарт 2-р сард болсон цэргийн эргэлтийг эсэргүүцсэн өргөн хүрээтэй жагсаал цуглааныг харгис хэрцгийгээр нухчин дарсны улмаас олон зуун хүн амиа алдаж, олон мянган хүн хууль бусаар баривчлагджээ. 8-р сард Афганистанд Талибанчууд хяналтаа тогтоосонхоо дараа дайны гэмт хэрэг үйлдэж, эмэгтэйчүүд, охидын тэмцэж олсон үндсэн эрх, эрх чөлөөг огцом хумилаа. Хятадад Шинжаанд амьдарч буй исламын шашинтнуудын эсрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэгдэж, ялангуяа Хонконгод хүний эрхийн байдал улам бүр дордов. Олон жилийн турш хүний эрхийг дээдэлж чадаагүй, хүний эрхийг зөрчсөн буруутнуудад хариуцлага тооцолгүй явж ирсэн нь хүний эрхийн эдгээр сүйрэлд шууд нөлөөллөө.

Олон засгийн газар Ковид-19 цар тахлыг хүний эрхийг хязгаарлах шалтаг болгон ашигласаар байв. Хэд хэдэн улсад Ковид-19-ийн талаар “худал”, “ташаа” мэдээлэл тараахад эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилгоор шинэ хууль тогтоомж баталсан бөгөөд одоо мөрдөгдөж буй хуулиуд нь шүүмжлэгчдийн амыг таглаж, жагсаал цуглаан хийлгэхгүй байх, тараахад ашиглаж байна.

Тус бүс нутагт өөрөөр сэтгэгчдийн тэвчээр барагдаж байна. Олон оронд хэвлэл мэдээлэл, интернэтэд тавих хяналтыг чангатгасан. Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг шүүмжилсэн улс төрийн сөрөг хүчнийхэн хийгээд бусад хүмүүс улам бүр хатуу хориг, шийтгэлд өртлөө. Тайван жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэх явдал түгээмэл байсан бөгөөд бүс нутгийн засгийн газрууд хүний эрх хамгаалагчдыг хамгаалж чадаагүй төдийгүй ажлаа явуулахад нь идэвхтэй саад учруулж байв.

Олон засгийн газар Ковид-19 халдварын шинэ давалгааны эсрэг хариу арга хэмжээ авах бэлтгэл муутай хэвээр. Тэд эрүүл мэндийн салбарыг зохих ёсоор санхүүжүүлж, авлигатай тэмцэж, эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх эрхийг хамгаалж чадаагүйн улмаас олон мянган хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжгүй болж, амь насаа алдахад хүрлээ.

Афганистанаас гадна олон оронд цар тахал, түүнтэй холбоотой хязгаарлалтын улмаас эмэгтэйчүүд, охидын байдал улам дордов. Нийгмийн зохих ёсны дэмжлэг байхгүйгээс албан бус салбарт ажиллаж буй эмэгтэйчүүд улам ядуурчээ. Бүс нутаг даяар эмэгтэйчүүд, охид бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх явдал өндөр байсаар байгаа бөгөөд буруутай этгээдэд хариуцлага бараг хүлээлгэсэнгүй. Хэд хэдэн оронд ЛГБТИ хүмүүсийн эсрэг кампанит ажил явуулсан. Бүс нутаг даяар уугуул иргэд хүрээлэн буй орчны доройтлын үр дагаварт улам их өртөж байна.

Афганистан, Мьянмар улсад хэдэн арван мянган хүн гэр орноо орхин дүрвэхээс аргагүй болж хил дамнан орогнол хайхад хүрсэн. Гэвч хөрш орнууд нь тэдний олонхыг хүний эрх нь ноцтой зөрчигдөх эрсдэлтэй нөхцөл руу буцаажээ. Бусад орны засгийн газрууд орогнол хүсэгчдийг нэвтрүүлэхээс татгалзан дүрвэгсэд, цагаачдыг саатуулж, зүй бус харьцлаа.

ӨӨРӨӨР СЭТГЭГЧДИЙГ НУХЧИН ДАРСААР

Ази-Номхон далайн бүс нутагт өөрөөр сэтгэгчдийн орон зай хумигдлаа. Мьянмарын цэргийн шинэ засгийн газар төрийн эргэлтийг эсэргүүцэгчдийн амыг хамхихыг

хичээж, улс орон даяар өрнөж буй жагсаал цуглааныг хүчирхийлэн тарааж, хуучин эрх баригч намын гишүүд, ардчиллын төлөө идэвхтнүүдийг баривчилжээ. Талибанчууд Афганистанд төрийн эрх мэдлийг гартаа авсныхаа дараахан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж, тэдний бодлогыг эсэргүүцсэн жагсаалыг хүч хэрэглэн тараасан. Хойд Солонгост улсын удирдлага, улс төрийн тогтолцоонд заналхийлсэн гэж үзсэн хэнийг ч шоронд хорих буюу “хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх” ял оноодог. Бусад олон орны эрх баригчид улс төрийн өрсөлдөгчид болон бусад хүмүүсийг дарамталж, баривчилж, хорьж, зарим тохиолдолд амь насыг нь бүрэлгэж байв.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Засгийн газрууд Ковид-19 цар тахлын талаарх ташаа мэдээлэл тархахаас сэргийлэхийн тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарласан дарангуйллын шинжтэй хууль тогтоомж, бусад арга хэмжээг зөвтгөсөөр ирлээ. Малайзын засгийн газар Ковид-19-ийн тухай “худал мэдээ”-нээс урьдчилан сэргийлэх нэрийдлээр өөрсдийг нь шүүмжлэгчдийн амыг таглах хязгааргүй эрх мэдэл олгосон захирамж гаргажээ. Хятад, Бангладеш, Фижи, Вьетнам зэрэг улсын эрх баригчид Ковид-19-ийн хариу арга хэмжээг шүүмжилсэн хүмүүсийг баривчилж, ял шийтгэл оноосон. Шри Ланкагийн эрх баригчид цар тахлын эсрэг хариу арга хэмжээний талаар санаа зовниж буйгаа хэвлэл мэдээллийнхэнд ярьсан эрүүл мэндийн салбарын ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулна гэж сүрдүүлжээ.

Бүс нутаг даяар хараат бүс хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дайралтад өртөв. Мьянмарт цэргийн эрх баригчид сонин сэтгүүлчдийг хааж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн зөвшөөрлийг цуцалж, сэтгүүлчдийг баривчилжээ. Хэвлэл мэдээллийн шинэ зохицуулалтаар Талибаныг шүүмжлэхийг бүрмөсөн хориглосон Афганистан улсад сэтгүүлчдийг баривчилж, зодож, дарамталж байгаа бөгөөд аравдугаар сарын байдлаар 200 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаажээ.

Сингапурын эрх баригчид блогч, сэтгүүлчдийн эсрэг бусдын нэр хүндэд халдсан гэх хэрэг үүсгэдэг ба The Online Citizen хэмээх бие даасан мэдээллийн сайтыг санхүүгийн зөрчил гаргасан хэмээн хуурамчаар буруутгаж, үйл ажиллагааг нь зогсоожээ. Энэтхэгийн эрх баригчид Ковид-19-ийн хохирогчдын цогцсыг Ганга мөрний эрэг дагуу бөөнөөр нь хаясан тухай мэдээлснийх нь дараа хинди хэлээр хэвлэгддэг өдөр тутмын сонины газарт нэгжлэг хийжээ. Филиппинд сэтгүүлч Мари Рессагийн ажлыг Нобелийн энх тайвны шагнал хүртэх үед нь үнэлж байсан ч засгийн газрыг шүүмжилсэн хэргээр түүний эсрэг үүсгэсэн шүүхээр хараахан шийдвэрлэгдээгүй хэргүүд нь олон арван жил шоронд хоригдох ялтай юм.

Олон засгийн газрууд цахимаар мэдээлэл авах, цааш түүгээд хяналт тавихыг хичээсэн. Сингапурын засгийн газар “гадаадын хөндлөнгийн оролцоо” гэж сэжиглэгдсэн контентыг устгах, хаах бүрэн эрх олгосон шинэ хууль баталжээ. Камбожийн шинэ хуулийн дагуу интернэтийн бүх урсгалыг “мониторинг хийх” үүрэгтэй хяналтын байгууллагаар дамжуулахыг шаардах болсон. Хятадад интернэт үйлчилгээ үзүүлэгчдэд “үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн” вэб сайтыг хаахыг тушаасан бөгөөд Шинжаан, Хонконг зэрэг маргаантай сэдвүүдийг хэлэлцэж байсан аппуудыг хаажээ. Пакистанд мөн онлайн контентыг цензурдэх хатуу хууль тогтоомжийг баталсан.

Олон орны эрх баригчид сэтгүүлч, идэвхтэн, сурган хүмүүжүүлэгчид гэх мэт өөр үзэл бодолтой хүмүүсийг баривчлах, яллахдаа одоогоор хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг ашиглажээ. Индонезид бодлого, үйл ажиллагааг нь шүүмжилсэн дор хаяж 100 хүний эсрэг зургаан жил хүртэл хорих ялтай Цахим мэдээлэл, гүйлгээний тухай хуулийг ашигласан. Энэтхэгийн Эмнести Интернэшнл байгууллагын дарга Аакар Пателийг исламын шашинтнуудын эсрэг дайсагналын талаар сэтгэл зовниж буйгаа жиргэснийх нь дараа баривчлаж, “нийтийн эв зохирлыг эвдсэн” хэргээр буруутгажээ. Балбын эрх баригчид засгийн газар, эрх баригч намын удирдагчдыг шүүмжилсэн хүмүүсийг хууль бусаар саатуулахдаа Цахим гүйлгээний

тухай хуулийг ашигласан байна. Хоёр жил завсарласны дараа Тайландын эрх баригчид *Ise majesty* хууль тогтоомжийг дахин ашиглаж эхлэв. Хаант засаглалыг шүүмжилсэн хэргээр эдгээр хуулийн дагуу буруутгагдсан 116 гаруй хүний нэг болох нэгэн төрийн албан хаагчид 87 жилийн хорих ял оноожээ.

ХУРАН ЧУУЛАХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Улс төрийн үйл явцын өрнөл, Ковид-19-ийн цар тахлын эсрэг хариу арга хэмжээг буруугаар ашигласан, ажилчдын эрх болон бусад асуудлаар бүс нутаг даяар эсэргүүцлийн давалгаа өрнөв.

Ковид-19-ийн тархалтаас сэргийлэх зорилгоор боловсруулсан дүрэм журмыг зарим улс оронд тайван жагсаал цуглааныг хориглох, тараахад ашигласан. Малайз Ковид-19-ийн хяналтын хууль, бусад хууль тогтоомжийг ашиглан тайван замаар хуран чуулах эрхийг нүхчин дарах ажиллагаагаа улам эрчимжүүлсэн бөгөөд Ковид-19-ийн хохирогчдын дурсгалыг хүндэтгэх арга хэмжээг албадан тарааж, оролцогчдыг дарамталж, баривчилж, торгууль ногдуулсан байна. Мальдивын эрх баригчид жагсаал цуглаан, ялангуяа улс төрийн сөрөг хүчний бүлгүүдийн зохион байгуулсан жагсаалыг тараахын тулд Ковидтой холбоотой эрүүл мэндийн удирдамжийг иш татав. Монгол Улсад Ковид-19-ийн хязгаарлалтыг жагсаал цуглаан хийхийг хориглох, тайван жагсаалыг албадан тараах, жагсаал зохион байгуулагчдыг баривчлах, саатуулах, торгох зэрэгт ашиглажээ.

Бүс нутгийн наад зах нь 10 улсад тайван жагсагчдын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэжээ. Мьянмарын цэргийнхэн төрийн эргэлтийг эсэргүүцэн улс орон даяар өрнөсөн жагсаалын эсрэг өргөн хэмжээний хүчирхийлэл үйлдсэн бөгөөд тайван жагсагчдын эсрэг зөвхөн дайны талбарт зориулагдсан үхэлд хүргэх тактик, зэвсгийг ашиглав. Амиа алдсан жагсагчдын тоо оны эцсийн байдлаар 1400-д хүрчээ.

Энэтхэгт өнгөрсөн наймдугаар сард цагдаа нар газар тариалангийн тухай маргаантай хуулийг эсэргүүцэн тайван жагсаал хийж байсан тариачдыг бороохойдсон. Индонезийн аюулгүйн хүчнийхэн өнгөрсөн долдугаар сард Папуагийн Тусгай автономийн тухай хуулийг шинэчлэхийг эсэргүүцсэн тайван жагсаалыг тараахын тулд усан буу, резинэн бороохой ашиглажээ.

Тайландын цагдаа нар улс төрийн шинэчлэл хийх, цар тахлын эсрэг хариу арга хэмжээг сайжруулахыг уриалсан жагсаал цуглааны эсрэг олон удаа хүч хэрэглэсэн бөгөөд жагсагчид, сонирхогчид, сэтгүүлчид рүү ойрын зайнаас резинэн сүм, нулимс асгаруулагч хийгээр буудсан юм. Жагсагчдын эсрэг байлдааны сүм хэрэглэсний улмаас хэд хэдэн хүүхэд шархдаж, нэг хүүхэд нас барсан байна. Пакистанд хууль сахиулах байгууллагууд жагсаал цуглааны эсрэг, тэр дундаа Паштунуудын эрхийг дэмжсэн жагсаалын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэсний улмаас олон хүн шархдаж, наад зах нь нэг хүн нас барсан байна.

Бүс нутгийн засгийн газрууд улс төрийн нам, идэвхтнүүд, үйлдвэрчний эвлэл, ТББ-уудын эсрэг улам бүр өргөн хүрээтэй арга хэмжээ авч байгаа нь эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний эсрэг шинэ цохилт боллоо.

Камбожид хориотой сөрөг хүчин болох Камбожийг аврах үндэсний намын гишүүдийг шүүж, есөн удирдагчийг гэм буруутайд тооцож, 25 хүртэлх жилийн хорих ял оноожээ. Вьетнамд Үндэсний ассамблейн сонгуульд бие даан нэр дэвших хүсэлтээ өгсөн иргэний сэтгүүлчийг баривчилж, таван жилийн хорих ялаар шийтгэжээ.

Хонконгийн 2020 оны Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн жинхэнэ айдас төрүүлэм үр нөлөө нь оны туршид илрэн гарлаа. Уг хуулийн улмаас дор хаяж 61 иргэний нийгмийн байгууллага, тэр дундаа Хонконгийн хамгийн том мэргэжлийн холбоог татан буулгажээ. Нэгдүгээр сард сөрөг хүчний намын олон арван гишүүдийг баривчилсны дараа зохион байгуулалттай улс төрийн сөрөг хүчин үйл ажиллагаагаа явуулах боломж нэгмөсөн дуусав. Аравдугаар сард Эмнести Интернэшнл Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу хэлмэгдүүлэлтэд өртөх эрсдэлтэй тул Хонконг дахь салбараа хаах болсноо зарласан.

Энэтхэгт Хүний эрх, хүрээлэн буй орчны асуудлаар ажилладаг олон арван байгууллагуудын зөвшөөрлийг түдгэлзүүлж, бүртгэлийг цуцлах, санхүүжилтийн талаар засгийн газраас зөвшөөрөл авах гэх мэтээр үндэсний болон олон улсын төрийн бус байгууллагуудад үзүүлэх дарамт шахалт нэмэгджээ. Мальдив улсад эрх баригчид нэр хүндтэй төрийн бус байгууллага болох Мальдивын ардчиллын сүлжээг мөрдөн шалгах ажлаа үргэлжлүүлсээр байна.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД

Хүний эрх хамгаалагчид хэд хэдэн оронд, түүний дотор тэднийг төрийн бус тоглогчид хууль бус аллагынхаа бай болгож байгаа Афганистанд амь насаа алдлаа. Талибанчууд засгийн эрхэнд гарсны дараа Афганистаны Хүний эрхийн хараат бус комиссын комиссарууд, ажилтнууд зэрэг олон хүн эх орноосоо дүрвэсэн байна. Филиппинд хүний эрх, хүрээлэн буй орчны хамгаалагчид коммунист бүлгүүдтэй холбоотой хэмээн буруутгагдсан “улаан тамга”-тай болсон нь аюулгүйн хүчнийхэнд тэднийг алах зөвшөөрөл олгосон гэсэн үг юм.

Хятадын эрх баригчид хүний эрх хамгаалагчдыг нухчин дарах ажиллагаагаа эрчимжүүлэв. Тэдний олонх нь удаан хугацаагаар хоригдож байгаа бөгөөд эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бус харьцсан тухай мэдээлэл нийтлэг байв. Өмнөх жилүүдэд хоригдож байсан хүний эрхийн хэд хэдэн хуульч, идэвхтэн сураггүй алга болсон. Үүний зэрэгцээ, Хонгконгод 1989 онд Тяньаньмэний талбайд амь үрэгдэгсдийн дурсгалыг тайван замаар хүндэтгэсэн 24 хүнд хорих ял оноожээ.

Бангладеш, Камбож, Энэтхэг, Индонез, Малайз, **Монгол**, Балба, Сингапур, Шри-Ланка, Тайланд, Вьетнам зэрэг бусад оронд ч хүний эрхийн хамгаалагчдыг дарамталж, заналхийлж, баривчилж, яллаж, шоронд хорив. Индонезид оны туршид 357 гаруй хүний эрхийн хамгаалагчдын эсрэг бие махбодын халдлага, дижитал халдлага, заналхийлэл болон бусад төрлийн халдлага бүртгэгджээ. Дижитал аюулгүй байдлын тухай хуулийн дагуу Бангладеш улсад шоронд хоригдож буй олон зуун хүмүүсийн дунд хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчид, идэвхтнүүд байсан. Балбад цагдаа нар өнгөрсөн аравдугаар сард Банке дүүрэгт нэг эмэгтэйн үхэл, мөн нэг эмэгтэйн сураггүй алга болсон хэргийг шударгаар мөрдөн шалгахыг шаардаж тайван замаар жагссан 13 идэвхтэнг саатуулжээ.

Зарим засгийн газар хүний эрхийн хамгаалагчдыг хэрхэн мөшгин хянаж байдаг нь улам бүр тодорхой болсон. Хүний эрхийн идэвхтнүүдийг албан ёсоор “төрийн дайсан” хэмээн зарласан Энэтхэг улсад хүний эрх хамгаалагчдын эсрэг хууль бус мөшгин хяналтын өргөн хүрээтэй ажиллагаа илэрсэн байна. Вьетнамд Эмнести Интернэшнлээс явуулсан мөрдөн шалгалтын явцад хүний эрх хамгаалагчдыг тус улсын дотоодод болон хилийн чанадад онилсон хууль бус мөшгин тандалтын кампанит ажил илэрчээ.

Монгол Улс хүний эрх хамгаалагчдын эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлсэн хууль баталсан нь зэрэг алхам боллоо. Гэсэн хэдий ч хүрээлэн буй орчин, газрын эрхийн асуудлаар ажиллаж буй малчид зэрэг хүний эрхийн идэвхтнүүд хууль ёсны үйл ажиллагааныхаа төлөө заналхийлэл, айлган сүрдүүлэлтэд өртөж, хууль ёсны үйл ажиллагааныхаа төлөө шүүхэд дуудагдсаар байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭРХ

Хөрөнгө оруулалт дутуу дулимаг, авлига даамжирсан зэрэг нь тус бүс нутгийн эрүүл мэндийн салбарууд Ковид-19 тахлын эсрэг зохих хариу арга хэмжээ авах чадамгүй болоход нөлөөлсөн. Зарим улс оронд боловсон хүчин, эмнэлгийн ор, тоног төхөөрөмжийн ноцтой хомсдол нь Ковид-19-ын халдвар авсан өвчтөнүүд эрүүл мэндийн зохих тусламж үйлчилгээ авч чадахгүйд хүргэлээ. Үүний улмаас оны туршид халдварын огцом өсөлттэй байсан Энэтхэг, Балба зэрэг улсад олон мянган хүн

урьдчилан сэргийлэх боломжтой үхлээс зайлж чадсангүй. Энэтхэг болон Филиппин улсад цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах засгийн газрын санхүүжилтэд ил тод байдал дутмаг, зөрчил дутагдал гарсаар байгаа нь сэтгэл түгшээж байв.

Афганистан, Мьянмар дахь улс төрийн үймээн самуун нь угийн унах гэж байсан эрүүл мэндийн тогтолцоог сүйрлийн ирмэгт аваачлаа. Олон улсын хандивлагчдаас Афганистаны эрүүл мэндийн салбарт үзүүлэх тусламжийг түдгэлзүүлсний улмаас Ковид-19 эмнэлгүүд зэрэг дор хаяж 3000 эрүүл мэндийн байгууллагууд хаалгаа барихад хүрчээ. Мьянмарт эрүүл мэндийн байгууллагууд болон ажилтнууд руу олон удаа халдлага үйлдсэний улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад саад тотгор учирсан.

Ковид-19 цар тахлын эсрэг вакцины хүртээмж зарим улсад хүндрэлтэй байв. Хойд Солонгосын эрх баригчид тус улсад Ковид-19 байгааг үгүйсгэж, COVAX хөтөлбөрийн хүрээнд олон сая тун вакцин олгох саналаас татгалзав. Балба улс хүлээж байсан вакцинаа авч чадаагүй бөгөөд 1,4 сая хүн хоёр дахь тунгаа хийлгэхийн тулд хэдэн сар хүлээх шаардлагатай болжээ.

Худал мэдээлэл нь зарим улс оронд вакцинжуулалтад бага хамрагдахад нөлөөлсөн. Тухайлбал, оны эцэс гэхэд хүн амын дөнгөж 3% нь вакцинд хамрагдсан Папуа Шинэ Гвиней улсын засгийн газар вирус болон вакцины хөтөлбөрийн талаар цаг алдалгүй, хүртээмжтэй мэдээлэл өгч чадаагүй.

Зарим орны эрх баригчид Ковид-19-ийн тархалтыг хязгаарлахын тулд шоронд хоригдож байгаа хүмүүсийн тоог бууруулах уриалгыг үл тоомсорлолоо. Тайландын эрүүл ахуйн шаардлага хангаагүй, ачаалал ихтэй шоронд хоригдож буй хүмүүсийн дунд цар тахлын 87 000 орчим тохиолдол бүртгэгдсэн байна. Пакистанд хоригдлуудыг вакцинд хамруулахыг нэн тэргүүнд анхаарч, Синдх мужид урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгож хоригдлуудыг сулласан байна. Бусад улсад шоронгийн удирдлагууд хоригдлуудын дундах халдварын түвшинг мэдээлэхээ больсон.

Хорио цээрийн хатуу арга хэмжээ нь зарим улс оронд эрүүл мэндийн, зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг алдагдуулжээ. Вьетнамын Хо Ши Мин хотын оршин суугчдыг хэдэн долоо хоногийн турш гэрээсээ гарахыг зөвшөөрөөгүй тул олон хүн хүнсний хомсдол, өлсгөлөнд автсан. Үүнтэй төстэй арга хэмжээг Камбожийн эрх баригчид хэд хэдэн хотод хэрэгжүүлсэн нь оршин суугчдын хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээний хүртээмжид ноцтой нөлөөлсөн.

АЖИЛЧДЫН ЭРХ

Цар тахал нь бүс нутгийн хэмжээнд эрүүл мэндийн ажилтнуудад асар их дарамт учруулсан хэвээр байна. Олон оронд тэд зохих ёсны хамгаалалтгүй, хангалттай цалин хөлсгүйгээр тэвчихийн аргагүй нөхцөлд ажиллаж байв. Монгол Улсад эрүүл мэндийн ажилтнууд эрх баригчдын дарамтад өртөхийн зэрэгцээ уурлаж бухимдсан, цөхрөнгөө барсан өвчтөнүүдийн бие махбодын халдлагад өртжээ. Энэтхэгт олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг зохих цалин хөлс, хувийн хамгаалалтын хэрэгслээр хангаагүй. Индонезид Ковид-19 тахлын үеэр эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрийг үнэлэн урамшууллын мөнгө олгох ажил хойшлогджээ.

Цар тахлын нийгэм-эдийн засгийн нөлөөлөл, түүнтэй холбоотой хязгаарлалтууд үргэлжилсээр байгаа бөгөөд угийн шоовдорлогдсон хүмүүст, тэр дундаа баталгаатай ажлын байр болон тогтмол орлогогүй хүмүүст илүүтэй сөргөөр нөлөөлж байна. Жишээлбэл, Балбад далитчууд болон ядуу хүмүүс, түүний дотор өдрийн орлогоороо амьдардаг хүмүүст тус улсын эдийн засгийн байдал улам дордож байгаа нь нэрмээс болжээ. Вьетнамд цагаач эмэгтэй ажилчид, тэр дундаа гудамжны худалдаачид тун хүнд нөлөө амссан бөгөөд олон хүн хүнсний аюулгүй байдал алдагдаж, бусад үндсэн хэрэгцээг хангах чадваргүй болсон гэж мэдээлсэн.

ДҮРВЭГСЭД БОЛОН ЦАГААЧДЫН ЭРХ

Афганистан болон Мьянмарт болсон үйл явдлууд бүс нутагт дүрвэгсдийн шинэ давалгааг бий болгов. 8-р сард Кабулын нисэх онгоцны буудлаас эмх замбараагүй нүүлгэн шилжүүлэлт хийгдсэний дараа олонх нь Пакистан, Иран руу хуурай газраар дүрвэсэн ч Талибанчууд тус улсыг орхин явахыг хязгаарлаж, хилээ хааснаар тэдний гуравдагч орнуудаас орогнол хүсэх эрхийг алдагдуулжээ. Оны эцэс гэхэд Иран, Пакистанаас нэг сая гаруй бичиг баримтгүй афганчууд буцаж ирсэн бөгөөд тэдний ихэнхэд өөр арга байгаагүй.

Мөн Мьянмарын орогнол хүсэгчид болон цагаачдыг бүс нутгийн бусад улс орнууд хүчээр нутаг руу нь буцаах буюу өөрийн улс руу нэвтрүүлэхээс татгалзаж байв. Тайландын хилчид цэргийн агаарын довтолгооноос зугтаж байсан 2000 орчим Карен тосгоны оршин суугчдыг хүчээр буцаажээ. Малайзын эрх баригчид мөрдлөг хавчлага, хүний эрх зөрчигдөх бусад ноцтой эрсдэлийг үл харгалзан мянга гаруй хүнийг Мьянмар руу албадан гаргав.

Мьянмар дахь хүний эрхийн нөхцөл байдал Бангладеш дахь рохинжа дүрвэгсдийг сайн дураараа эх орондоо буцах боломжгүй болгожээ. Гэсэн хэдий ч Бангладеш улсад тэдний эрхийг хязгаарласнаар байгаа бөгөөд хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байв. 19 000 гаруй хүнийг алслагдсан Бхасан Чар арал руу шилжүүлж, чөлөөтэй зорчих эрхийг нь хасчээ.

Бусад хэд хэдэн оронд дүрвэгсэд, цагаачдыг удаан хугацаагаар хорьж, зүй бус харьцжээ. Япон улсад орогнол хүсэгчид болон хууль бус цагаачдыг тодорхойгүй хугацаагаар баривчлан саатуулжээ. Цагаачдыг саатуулах байранд нас барсан Шри-Ланка эмэгтэйн үхлийн шалтгааныг мөрдөн шалгах явцад түүнд шаардлага хангасан эмнэлгийн тусламж үзүүлээгүй болох нь тогтоогджээ. Австралийн эрх баригчид дүрвэгсэд, орогнол хүсэгчдийг эх орондоо болон эргээс гаднах бүсэд хугацаагүй бөгөөд үндэслэлгүйгээр саатуулсаар байна. Шинэ Зеландад саатуулагдсан орогнол хүсэгчидтэй зүй бус харьцаж байсан ч тус улсын засгийн газар орогнол хүсэгчдийг ердөө цагаачилсан гэх үндэслэлээр эрүүгийн ял оноож, хорих ангиудад саатуулдаг практикт хөндлөнгийн хяналт хийхээ зарласан нь эерэг алхам боллоо.

Малайз, Сингапур, Өмнөд Солонгос, Тайвань, Вьетнам зэрэг оронд Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахдаа цагаач ажилчдыг шударга бусаар ялгаварлан гадуурхав.

ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИДЫН ЭРХ

Бүс нутаг даяар эмэгтэйчүүд, охидын эрхийн асуудалд томоохон ухралт гарлаа. Афганистанд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлээр 20 жилд хүрсэн ахиц дэвшил ганцхан шөнийн дотор замхарлаа. Талибаны шинэ засаг захиргаанд эмэгтэйчүүдийн төлөөлөл үгүй болж, олон салбарт ажиллах боломжгүй болсон. Охидын боловсрол эзэмших эрхийг эрс хязгаарлаж, эмэгтэй хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, шүүгч, прокурорууд заналхийлэл, сүрдүүлэгтэй тулгарсан. Эмэгтэйчүүдийн эрхийг дэмжсэн жагсаал цуглааныг Талибанчууд хүчирхийлэн даржээ.

Бүс нутгийн олон оронд аль хэдийн өргөн тархсан бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл улс орнуудын Ковид-19-ийн эсрэг авсан хариу арга хэмжээний хүрээнд улам хурцадсан. Тухайлбал, Бангладеш, Фижи, Папуа Шинэ Гвиней, Шри Ланка улсад жендэрт суурилсан хүчирхийллийн түвшин нэмэгджээ.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцох, хамгаалалтыг чангатгахыг шаардсан шаардлагууд дорвитой ахиц авчирсангүй. Хятадын засгийн газар “засан хүмүүжүүлэх төв” дэх бэлгийн хүчирхийллийн талаар ярьсан өмнө нь Шинжааны бүс нутагт хоригдож байсан, одоо гадаадад амьдарч байгаа эмэгтэйчүүдийн эсрэг гүтгэлгийн кампанит ажил өрнүүлжээ. Пакистанд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг парламент баталсан ч консерватив намуудын эсэргүүцэлтэй тулгарсан тул засгийн газраас шашны зөвлөх байгууллагад

хандаж, хуулийн төслийг нягтлан үзэх хүсэлт гаргасан тухай мэдээлэл байна. Түүнчлэн бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцохгүй байх нь нийтлэг хэвээр байв. Балбад эмэгтэйчүүдийн эрх тэгш иргэний эрхийг үгүйсгэсэн Үндсэн хуулийн заалтуудыг шинэчлэх эсвэл хүчингийн гэмт хэргийн талаар хуулиар тогтоосон хэт явцуу хязгаарлалтыг цуцлах талаар ямар нэг ахиц дэвшил гарсангүй.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Бүс нутгийн олон оронд хуулиар болон практикт ЛГБТИ хүмүүсийг хавчих буюу бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхсан хэвээр байна. Зарим улсад ижил хүйстнүүдийн зөвшилцсон бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцсон хэвээр байв. Хэд хэдэн оронд ЛГБТИ хүмүүсийн эсрэг кампанит ажил өрнөсөн. Малайзад 1700 гаруй хүнийг ЛГБТИ хүмүүсийн “амьдралын хэв маяг” болон “бэлгийн чиг баримжаа”-г өөрчлөх зорилгоор засгийн газрын харьяа нөхөн сэргээх газруудад илгээжээ. Хятадын эрх баригчид интернэтийг ЛГБТИ хүмүүсийн төлөөллөөс “цэвэрлэх” кампанит ажлаа үргэлжлүүлсээр байна. Эмэгтэйлэг төрхтэй эрчүүдийг зурагтаар гарахыг хориглож, ЛГБТИ байгууллагуудын нийгмийн сүлжээний хаягуудыг хаажээ. Афганистанд Талибанчууд ЛГБТИ хүмүүсийн эрхийг хүндэтгэхгүй гэдгээ тодорхой илэрхийлсэн.

Тайваньд ижил хүйстний гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх талаар зарим нэг ахиц гарсан ч ЛГБТИ хүмүүс ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна.

УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХ

Арилжааны ашиг сонирхол ба хүрээлэн буй орчны доройтол тус бүс нутгийн уугуул иргэдийн өв уламжлал, амь амьжиргаанд улам бүр заналхийлж, хууль эрх зүйн хамгаалалтын хүч дор хаяж нэг оронд суларлаа. Ойн хомсдол, газар нутгийг булаан авах явдал нэмэгдэж байгаагаас үүдэн Бангладешийн уугуул ард түмэн нөөцийн хомсдолд оржээ. Папуа Шинэ Гвинейн уугуул иргэд далайн гүнд ашигт малтмал, металл олборлох нь тэдний амьдрал ахуй, соёлд сөргөөр нөлөөлж байгааг эсэргүүцэв. Малайзын уугуул иргэд аялал жуулчлалын төсөл хэрэгжүүлэхээр нутгаас нь албадан нүүлгэх төлөвлөгөөг эсэргүүцэн Селангор мужийн засгийн газрын эсрэг шүүхэд гомдол гаргажээ. Балба болон Тайланд улсад өмнөх жилүүдэд албадан нүүлгэлтэд өртсөн уугуул иргэдийг буцаж ирэхийг зөвшөөрөөгүй бөгөөд амьдрах өөр газар, арга хэрэгслээр хангаагүй байна.

Фижи улсын парламент iTaukei Land Trust-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уугуул иргэдээс эзэмшиж буй газар дээр ипотекийн зээл авах болон түрээслэхэд зөвшөөрөл авах шаардлагыг цуцалсаны улмаас эсэргүүцлийн жагсаал болж, арав гаруй хүнийг баривчилсан байна. Тайванийн шүүхүүд уугуул иргэдийн газар нутаг, уламжлалт ан агнуурын зан үйлээ эзэмших эрхийг хангах талаар зарим арга хэмжээ авсан боловч одоо байгаа хууль тогтоомж нь зохих хамгаалалтыг хангаж чадахгүй хэвээр байна.

Камбожид уугуул иргэд болон орон нутгийн ой хамгаалагчдыг уламжлалт газар нутагтаа байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Тэнд болон бусад газарт газар нутгаа хамгаалах хүчин чармайлт нь баривчилгаа, хүчирхийлэлтэй тулгарч байв. Индонезийн Хойд Суматра болон Риау мужийн уугуул иргэд газар нутаг дээр нь эвкалипт мод тарихыг зогсоохыг оролдох үедээ цаасны компаниудын хөлсөлсөн хувийн хамгаалалтын ажилтнуудын хүчирхийлэлд өртсөн байна.

Филиппинд уугуул иргэд болон уугуул иргэдийн эрхийн төлөө тэмцэгчдийг баривчилж, хөнөөжээ. Үл таних этгээдүүд 2020 оны 12-р сард Тумандок нийгэмлэгийн удирдагчдыг баривчилж, зарим хүмүүсийг хөнөөсөн цагдаагийн дайралттай холбоотой хэргийн гэрч болох тосгоны ахлагч Жули Катаминыг буудан хөнөөсөн байна. Энэтхэгт Далит болон Адиваси (уугуул) эмэгтэйчүүд нийгмийн дээд зиндааны эрэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийлэлд өртөх онцгой эрсдэлд байсаар байна.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ГЭМТ ХЭРЭГ

Эмнести Интернэшнл Хятадын засгийн газар Шинжаанд амьдардаг дийлэнх нь исламын шашинтай угсаатны бүлгүүдийн эсрэг шоронд хорих, бие махбодын эрх чөлөөг нь ноцтойгоор хасах, эрүүдэн шүүх, мөрдөн хавчих зэрэг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэх баттай нотлох баримтуудыг цуглууллаа. Хятадын засгийн газар энэ бүхнийг эрс үгүйсгэж, исламын шашны итгэл үнэмшил, түрэг исламын шашинт угсаатны соёлын зан үйлийг устгахаар хүчирхийлэл, айлган сүрдүүлэлтэй хослуулан хоморголон баривчлах кампанит ажлаа үргэлжлүүлэв.

Афганистаны мөргөлдөөнд оролцогч талууд олон улсын хүмүүнлэгийн хуулийг ноцтой зөрчсөн, тэр дундаа дайны гэмт хэрэг үйлджээ. Хазара үндэстнүүд хүчирхийллийн бай болох нь элбэг бөгөөд талибанчуудын довтолгоо, засгийн эрх авах үеэр ч хүчирхийлэлд өртжээ.

Аюулгүйн хүчний 100 гаруй гишүүнийг Талибанчууд хүчээр сураггүй болгох буюу шүүхийн шийдвэргүйгээр цаазалж, зөвхөн Дайкунди хотод гэхэд бууж өгсөн есөн хазара цэргийг цаазалжээ. Талибанчууд Хазара энгийн иргэдийг хөнөөсөн хэд хэдэн хядлага үйлдсэний дотор Газни, Дайкунди муж багтаж байв.

Мьянмарт цэргийнхэн энгийн номхон иргэдийн эсрэг чиглэсэн халдлага үйлдсэний зэрэгцээ дотооддоо шилжин суурьшигчдад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх боломжийг хаасан. Арванхоёрдугаар сард зүүн Каяах мужид цэргийнхний гарт амиа алдсан хүмүүсийн дунд Хүүхдийг Ивээх Сангийн хоёр хүмүүнлэгийн ажилтан байжээ.

ЭРҮҮДЭН ШҮҮЛТ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ЗҮЙ БУС ХАРЬЦАХ

Бүс нутгийн нэлээд олон оронд эрүүдэн шүүлт болон бусад хэлбэрээр зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх талаар дорвитой ахиц дэвшил гарсангүй. Пакистан, Тайландад эрүү шүүлтийг гэмт хэрэгт тооцох алхам хийгдсэн хэдий ч санал болгож буй хууль тогтоомж нь олон улсын жишигт бүрэн нийцээгүй байв. Шри Ланкад Терроризмоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гаргасан шинэ журам нь хоригдлуудыг эрүү шүүлтэд өртөх эрсдэлд оруулж болзошгүй юм.

Бусад оронд ч эрүүдэн шүүх, зүй бусаар харьцах явдал гарсаар байна. Мьянмарт төрийн эргэлтийг эсэргүүцсэн хэргээр саатуулагдсан хүмүүсийг эрүүдэн шүүж, бусад хэлбэрээр зүй бус харьцан, зарим тохиолдолд амь насыг нь хохироож байсан. Хятадын эрх баригчид Шинжаан болон бусад бүс нутагт хоригдлуудыг эрүүдэн шүүсээр байгаа бөгөөд тэр тухайгаа ярьсан хүмүүсийг ялласан. Балбад эрүү шүүлт болон бусад хэлбэрээр зүй бус харьцах явдлыг “хэрэг хүлээлгэх” болон хоригдлуудыг айлган сүрдүүлэх зорилгоор өргөн ашигладаг байжээ. Ийм үйлдлийг гэмт хэрэгт тооцох болсон 2017 оны Эрүүгийн хуулиар ял шийтгэл оноосон тохиолдол хараахан гараагүй байна. Малайзад цагдан хоригдож байхдаа эсвэл суллагад удаагүй байхдаа нас барах тохиолдол маш түгээмэл хэвээр байгаа бөгөөд энэ нь дор хаяж зарим тохиолдолд хоригдож байхдаа зодуулж, бусад хэлбэрээр зүй бус харьцсантай холбоотой юм.

ЯЛ ЗАВШИХ

Олон улсын эрх зүйн гэмт хэрэг болон хүний эрхийн ноцтой зөрчилд ял завших явдал нэлээд олон оронд ноцтой, сэтгэл түгшээсэн хэвээр байна.

Балба, Шри Ланкад өмнө нь болж өнгөрсөн зэвсэгт мөргөлдөөний үеэр үйлдэгдсэн олон улсын эрх зүйн гэмт хэрэг болон хүний эрхийн бусад ноцтой зөрчлийн охирогчдоод шударга ёсыг тогтоож чадахгүй байсаар байна. Балбад шилжилтийн үеийн шударга ёсны механизм ганц ч хэргийг шийдэж чадаагүй. Шри Ланкийн засгийн газар дотооддоо шударга ёсыг урагшлуулах тал дээр удаа дараа бүтэлгүйтсэний эцэст

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл мөргөлдөөнд оролцогч талуудын үйлдсэн олон улсын гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах механизмыг бий болгох тогтоол гаргажээ.

Дотоодын түвшинд ахиц дэвшил гарахгүй байгаагийн улмаас Олон улсын эрүүгийн шүүх (ОУЭШ) хоёр улсад мөрдөн байцаалт явуулжээ. Гэсэн хэдий ч ОУЭШ Филиппиний засгийн газраас гаргасан хойшлуулах хүсэлтийг авч хэлэлцээд “хар тамхины эсрэг дайн”-ы хүрээнд үйлдсэн хүн төрөлхтний эсрэг гэмт хэргийн мөрдөн байцаалтыг түр зогсоов. ОУЭШ Афганистанд мөрдөн байцаалтаа дахин эхлүүлсэн боловч зөвхөн Талибан болон Исламын улс-Хорасан мужийн үйлдсэн хэргүүдэд анхаарлаа хандуулж, Афганистаны засгийн газрын аюулгүй байдлын хүчин, АНУ-ын цэрэг, тагнуулын ажилтнуудын үйлдсэн дайны гэмт хэргийг үл тоомсорлосон нь нэр хүндээ эрсдэлд оруулаад зогсохгүй ял завших явдлыг улам бүр бэхжүүлэв. Австралийн эрх баригчид Афганистанд үйлдсэн дайны гэмт хэрэгтэй холбогдуулан 2020 онд мөрдөн байцаалтад шилжүүлсэн Тусгай хүчний гишүүдийнхээ эсрэг ямар ч арга хэмжээ авч чадаагүй.

Ял завших нь хүний эрхийн зөрчлийг бусад газарт, тэр дундаа Энэтхэг улсад албадан сураггүй болгох, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах явдал өргөн хүрээтэй, системтэйгээр үйлдэгдэхэд тус дөхөм үзүүлж байв. Пакистанд хүчээр сураггүй болгох гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг парламентад өргөн барьсан боловч энэхүү гэмт хэргээс хамгаалахад хангалтгүй байв. Бангладешийн засгийн газар сураггүй алга болсон, хууль бусаар аллага үйлдсэн гэх хэргийг шалгахын оронд хариуцлага хүлээхээс татгалзах эсвэл аюулгүйн хүчнийхэн “өөрийгөө хамгаалах”-аар ажилласан хэмээн мэдэгджээ. Индонезийн аюулгүйн хүчнийхэн Папуа болон Баруун Папуад хууль бус аллага үйлдсээр байгаа бөгөөд ихэнхдээ ял шийтгэл хүлээхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Цөөн хэдэн зэрэг өөрчлөлтийг эс тооцвол Ази Номхон далайн бүс нутагт хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах явдал дордсоор байна. Хүний эрхийг үл тоомсорлох явдал түгээмэл тархсан, засгийн газрууд нь шүүмжлэлийг улам бүр үл тэвчих болсон, эмэгтэйчүүд, охид, шоовдорлогдсон бүлгүүдийг ялгаварлан гадуурхах явдал газар авсан, ял завших явдал өргөн дэлгэрсэн энэ бүс нутагт Афганистан, Мьянмарыг хямрал руу хөтөлсөн эмгэнэлт явдал гарсан нь гайхмаар зүйл биш байв.

Засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хүндэтгэж, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ёстой. Эдгээр эрхийг хязгаарласан хуулиуд, тэр дундаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтийн хандалт, ТББ-ыг хязгаарласан зохицуулалтыг цуцалж, засгийн газрыг шүүмжлэгчдийг үндэслэлгүйгээр баривчилж, цагдан хорихыг зогсоох ёстой. Хүний эрх хамгаалагчдын хууль ёсны хөдөлмөрийг хүндэтгэж, хамгаалах ёстой.

Засгийн газрууд Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахад тулгарч буй сорилтуудаас сургамж авч, эрүүл мэндийн тогтолцоондоо ихээхэн хөрөнгө оруулалт хийж, эрүүл мэндийн эрхийг хамгаалахад анхааран ажиллах ёстой.

Цар тахлын үед эмэгтэйчүүд, охидын эрхийн талаар гарсан үхралтыг арилгах, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхийн тулд бүс нутгийн засгийн газрууд хамтын хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн эмэгтэйчүүд, охидын эрх, эрх чөлөөг хязгаарласан бодлогоо эргэж харахад нь Афганистан дахь Талибаны засгийн газарт үзүүлэх дарамт шахалтаа эрчимжүүлэх ёстой.

Дэлхийн улс орнуудын засгийн газрууд хүний эрхийн хамгаалалт баталгаажих хүртэл цагаачлалын статусаас үл хамааран Афганистан эсвэл Мьянмар руу ямар ч хүнийг буцаахаас татгалзах ёстой. Зөвхөн цагаачлалын статуст нь үндэслэн орогнол хүсэгчдийг хорьж саатуулдаг практикыг таслан зогсоох ёстой.

Засгийн газрууд олон улсын эрх зүйн гэмт хэргийн талаар бүрэн дүүрэн, хараат бус, шударга, үр дүнтэй, ил тод мөрдөн байцаалт явуулж, гэмт хэрэг үйлдсэн сэжигтнүүдийг ОУЭШ-д шилжүүлэх замаар ял завших явдалтай тэмцэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх ёстой. Олон улсын шударга ёсны үйл явцад тал бүрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ёстой.

ЕВРОП БА ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

2021 онд Европ болон Төв Азид авторитар засаглал хүчээ авлаа. Хэд хэдэн улс хүний эрхийг урьд хожид байгаагүй ичгүүргүйгээр үл тоомсорлосон нь хүний эрхийн үүрэг амлалтыг хоосон цаас болгож, бүс нутгийн байгууллагуудыг утга учиргүй хоосон "яриа хэлэлцээ"-ний талбар болгоход хүргэв. Зарим улс оронд ийм хандлага төрийн эрх мэдлийг хэтрүүлэх, шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах, эрх чөлөөг дарангуйлах, эсэргүүцэгчдийн дуу хоолойг хаах зэргээр илэрлээ. Бүс нутаг даяар хүний эрх хамгаалагчид хязгаарлалт, мөрдлөг хавчлага, айлган сүрдүүлэлттэй тулгарч байв.

Бүс нутгийн хэмжээнд цагаачлалын талаарх гаднынхныг үзэн ядсан яриа олон нийтийн дунд түгэж, бодлого улам чангарсаар байв. ЕХ-ны гадаад хилийг бэхжүүлэх ажил хурдацтай үргэлжилж, олон улс орон хил дээрээсээ цагаачдыг хууль бусаар буцааж буйгаа ил тод зарласан. "Буцаах" гэдэг нь ерөнхийдөө аймшигт хүчирхийллийг булзааруулах нэр томъёо юм. ЕХ-ны хэдэн арван улс дүрвэгсдийг хамгаалах дүрэм журмыг сулруулахыг тус холбооны гүйцэтгэх засаглалд уриалав.

Олон улс оронд 2020 оны "Харуудын амь нас ч чухал" жагсаал цуглааныг эсэргүүцсэн хандлага дэлгэрсэн. Цагаачдаас айх айдсын улмаас хар арьстнууд, мусульманчуудын тухай өрөөсгөл үзлийг бэхжүүлж, Ковид-19 цар тахлын үед цыгануудыг нийгмээс улам бүр гадуурхав. Европын орнуудын зүгээс дэлхийн бусад улс орнуудын талаар явуулж буй вакцинжуулалт, уур амьсгалын бодлогод арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг олж харахад хэцүү биш байв. Европт вакцинжуулалтын түвшин харьцангуй өндөр байсан ч Зүүн Европ болон Төв Азийн зарим орнуудад вакцинжуулалт доогуур хэвээр байв.

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нь ихэвчлэн сексизм болон ижил хүйстнийг үзэн ядах үзэлтэй зэрэгцэн оршиж байв. Зарим улсад эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаар ахиц дэвшил гарсан ч заримд нь ухарсан үзүүлэлттэй хэвээр байна. ЛГБТИ хүмүүсийн эрхийг гутаан доромжилсон, хязгаарласан хууль тогтоомж санаачлах болсон нь авторитар хандлагын илрэл боллоо. Ковид-19-ийн сөрөг нөлөөлөл, Афганистан улс Талибанчуудын эрхшээлд орсон зэрэг нь авторитар ухралтын хамтаар зарим улс оронд эмэгтэйчүүдийн болон ЛГБТИ хүмүүсийн эрхийг хэдэн арван жилээр ухраасан байх магадлалтай байна.

Улс орнуудын дотоодод гарч буй ухралтыг дагалдан олон улсын харилцаа улам бүр түрэмгий шинжтэй боллоо. Армени болон Азербайжан хоорондын мөргөлдөөний үр дагавараас үүдэн хүмүүс амь насаа алдсан хэвээр байна. Оны эцэс гэхэд Украинтай хиллэдэг хил дээрээ Орос цэргийн хүчээ зузаатгаж, Европ тивд дайн гарах нь улам бүр тодорхой болжээ.

ТӨР ЭРХ МЭДЛЭЭ ӨРГӨЖҮҮЛСЭЭР

Төр эрх мэдлээ өргөжүүлэх, хяналт, тэнцэлийг үл тоомсорлох нь авторитар чиг хандлагын нэг хэсэг байв. ОХУ-д тус улсын сөрөг хүчний гол улс төрч Алексей Навальныйд улс төрийн зорилгоор удаан хугацаагаар хорих ял оноосон бөгөөд Европын Хүний эрхийн шүүхээс гаргасан түүнийг суллах захирамжийг үл тоомсорлов. Беларусийн засгийн газар онгоцоор нисэж явсан тус улсаас дүрвэсэн сэтгүүлч Раман Пратасевичийг баривчлахын тулд хуурамч тэсрэх бөмбөгний сүрдүүлэг ашиглаж, иргэний нисэх онгоцны чиглэлийг өөрчилсөн.

Хэд хэдэн засгийн газар Ковид-19, цагаачдын “хямрал” болон терроризм/экстремизмтэй тэмцэх нэрийн дор хууль ёсны үйл ажиллагааны хязгаарыг давсан хэвээр байна. Ийнхүү Польш, Литва, Латви улс олон улсын стандартад нийцээгүй онц байдал зарлаж, хил дээрх хэвлэл мэдээлэл, ТББ-ын ажлыг эрс хязгаарласан юм.

Засгийн газрууд шүүмжлэгчдийн эсрэг улам бүр боловсронгуй аргуудыг ашиглах болов. Пегасус төсөл нь Унгар, Польш, Азербайжан, Казахстан улс хүний эрх хамгаалагчид, сэтгүүлчид болон бусад хүмүүсийн эсрэг NSO группын Pegasus тагнуулын программыг ашигласныг илрүүлсэн бол Германы засгийн газар уг технологийг худалдаж авснаа хүлээн зөвшөөрсөн. Гүржийн төрийн аюулгүй байдлын алба сэтгүүлчид, иргэний идэвхтнүүд, улс төрчид, шашны зүтгэлтнүүд, дипломатуудыг өргөнөөр мөшгин хянадаг байсныг харуулсан олон мянган файл задаржээ.

Зарим нь өмнөх үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээв. Умард Македони улсад нууц цагдаагийн газрын дарга асан болон бусад этгээдийг хүмүүсийн утсыг хууль бусаар чатнасан хэргээр яллажээ. ЕХЭШ Их Британи улс хүмүүсийн хоорондын харилцаа холбоог их хэмжээгээр мөшгин хянасан үйл ажиллагаанд буруугаар ашиглахын эсрэг хамгаалалт байхгүй гэж үзсэн. Үүний зэрэгцээ Швейцарьт бүх нийтийн санал асуулгаар терроризмын эсрэг шинэ хуулийг баталсан бөгөөд цагдаа нарт өргөн хүрээний эрх мэдэл олгосон байна.

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ АЛДАГДСААР

Төрийн хэт их эрх мэдлийн нэг гол илрэл нь шүүхийн хараат бус байдал алдагдах явдал. Польш улс тус улсын шүүхийн хараат бус байдлыг хамгаалах Европын байгууллагуудын оролдлогыг эсэргүүцэж, ЕХ-нд хамгийн том хууль дээдлэх ёсны хямралыг үүсгэв. Европын Хүний Эрхийн Шүүх болон Европын Холбооны Шүүхийн цуврал шийдвэрүүд Польш улсын шүүхэд хийгдсэн өөрчлөлт нь шударга шүүхийн хэм хэмжээг хангаагүй гэж үзсэн. Үүний хариуд Польшийн Үндсэн хуулийн шүүх тус улсын хууль нь ЕХ-ны хуулиас давуу бөгөөд Европын конвенцид заасан шударга шүүхээр шүүлгэх эрх Үндсэн хуульд нь нийцэхгүй байна гэж үзсэн нь Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга сонсгол явуулахад хүргэсэн ховор тохиолдол болов.

Беларусь улсад байдал улам дор байсан бөгөөд эрх баригчид шүүх тогтолцоог эрүү шүүлтийн хохирогчид, хүний эрхийн зөрчлийн гэрчүүдийг шийтгэхдээ ашиглав. Гүрж улсад ерөнхийлөгч асан Михаил Саакашвили болон сөрөг хүчний нэр хүндтэй удирдагчдыг баривчилж, хүнлэг бус нөхцөлд хорьж байсан нь шүүхийн хараат бус байдлын талаар сэтгэл зовниход хүргэв. Киргизийн шинэ үндсэн хууль шүүхийн хараат бус байдалд халдаж болзошгүйг олон талт байгууллагууд тэмдэглэжээ.

Турк улс шүүхийн эргэн тойронд зөвхөн өнгөц засвар, хэлбэр төдий алхам хийж тогтолцооны гүн гүнзгий алдаа дутагдлыг арилгаж чадаагүй юм. Тус улс ЕХЭШ-ийн гол шийдвэрүүдийг хэрэгжүүлэх шахалтыг эсэргүүцэж, оны эцэст тус улсын эсрэг ховор хэрэглэгддэг шүүхийн шийдвэр зөрчсөн хэрэг үүсгээд байв.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ХУРАН ЧУУЛАХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Олон засгийн газар шүүмжлэлийг дуугүй болгож, иргэдийн гомдлыг нэгтгэж чадах иргэний нийгмийн байгууллагуудын амыг таглаж, гудамжинд жагсаал цуглаан хийхэд нь саад учруулсан. Зарим улс оронд хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд учирч буй гол аюул нь гүтгэн доромжлох кампанит ажил, сэтгүүлчдийг, ялангуяа эмэгтэй сэтгүүлчдийг цахимаар дарамтлах, заналхийлэх явдал байв. Босни Герцеговин улсад

улс төрчдийн нэр төрд халдсан 300 шахам хэрэгт сэтгүүлчид голдуу буруутгагдсан бол энэ тоо Хорватад нийтдээ 900 гаруй байв. Болгар, Чех, Словени зэрэг улсад эрх баригчид төрийн үйлчилгээний хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцжээ.

Польшид эмэгтэйчүүдийн болон ЛГБТИ-хүмүүсийн эрхийн төлөөх идэвхтнүүд дарамт шахалттай тулгарсаар байгаа бөгөөд үйл ажиллагааг нь гэмт хэрэгт тооцсон хэвээр байна. Румынд авилгын хэргийг шалгаж байсан сэтгүүлчдийг ердөө ажлаа хийснийх нь төлөө хууль сахиулах байгууллага байцаажээ. Косовод Австрийн эрчим хүчний компани тус улсын гол мөрөн дээр усан цахилгаан станц барих нь ямар нөлөө үзүүлэх талаар олон нийтэд ярьсан хүрээлэн буй орчны идэвхтнүүдийн эсрэг айлган сүрдүүлсэн нэхэмжлэлээ татжээ.

Цаашлаад зүүн зүгийн орнуудад ялгаатай үзэл бодлоо илэрхийлэхийг хүссэн олон тооны иргэний нийгмийн зүтгэлтнүүд, сэтгүүлчдийг хууль ёсны үйл ажиллагааных нь төлөө эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан бөгөөд олон улс оронд олон нийтийн зүтгэлтнүүдийг доромжилсон хэмээн эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ. Казахстан ба Орос улсад хэт даврагсдын эсрэг хууль тогтоомжийг өөрөөр сэтгэгчдийг дарахын тулд хэрэглэх явдал нэмэгдсэн байна.

Беларусь улсад эрх баригчид идэвхтнүүд, сэтгүүлчдийг шоронд хорьсоор байсан нь бие даасан үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар ялгаатай үзэл бодол илэрхийлэх явдлыг бараг бүхэлд нь үгүй хийсэн. Беларусийн эрх баригчид гадаадад дүрвэсэн өөрөөр сэтгэгчдийг мөрдөж байгаа талаар сэжиг таамаг гарсаар байна. Тухайлбал, сэтгүүлч Павло Шеремецийн аллагыг эдгээр эрх баригчид төлөвлөж байсны нотолгоо олдсон бол Беларусийн гадаадад дүрвэсэн Витал Шишоуг заналхийлсэн гэсэн гомдлын дараа Украины нийслэл дэх цэцэрлэгт хүрээлэнд дүүжлэгдсэн байдалтай олджээ. Туркменистаны зарим интернэт хэрэглэгчид интернетэд нэвтрэхийн тулд виртуал хувийн сүлжээ (VPN)-г ашиглахгүй гэж Коран судраар тангараглах шаардлагатай болсон гэж мэдэгджээ.

ХУРАН ЧУУЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Олон улс орон тайван жагсаал цуглааныг хязгаарлахыг хуульчилсан байна. Грек улс олон нийтийг гадаа талбайд цуглахыг гурав дахь удаагаа хориглосон бөгөөд хэд хэдэн тайван жагсаалыг тараах зэргээр тайван жагсаал цуглаан хийх эрхийг зүй бусаар хязгаарлахын тулд цар тахлыг шалтаг болгон ашигласаар байна. Кипр ч мөн адил өргөн хүрээний хориг тавьсан. Туркийн эрх баригчид тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлаж, олон зуун хүнийг дур мэдэн баривчилж, хууль бусаар хүч хэрэглэж, эрхээ эдэлсэнийх нь төлөө хүмүүсийг ялласаар байна.

Беларусь улсад тайван жагсаал хийх эрх үндсэндээ байхгүй болж, олон мянган хүн хэлмэгдүүлэлтээс айж эх орноосоо дүрвэжээ. Орост ганц хүний жагсаал цуглаан зохион байгуулсан хүмүүсийг хүртэл ялласан бөгөөд Москвад тайван жагсагчдыг илрүүлж, шийтгэхийн тулд нүүр царай таних аргыг ашиглажээ. Казахстанд хязгаарлалт тавьсан хууль тогтоомж нь тайван жагсаал зохион байгуулах хүсэлтийг ихэнхдээ хүлээн авдаггүй байна.

Сербид 2020 онд болсон жагсаалын үеэр цагдаа нарын гэмтэж бэртээсэн 40 хүний шүүхэд гаргасан гомдолд ахиц дэвшил гарсангүй. Их Британид прокурорууд Black Lives Matter хөдөлгөөний жагсагчдыг яллахгүй байх шийдвэр гаргасан бол Умард Ирландад цагдаа нар 72 жагсагчийн торгуулийг буцаан олгох арга хэмжээ авчээ. Гэсэн хэдий ч ихээхэн маргаантай Цагдаагийн тухай хуулийн төсөлд жагсаал цуглааныг зүй бусаар хязгаарлахын тулд цагдаагийн эрх мэдлийг эрс өргөжүүлж, зөрчил гаргасан тохиолдолд хатуу шийтгэл оногдуулахаар төлөвлөсөн байна.

2021 оны сүүлээр Ковид-19-тэй холбоотой хязгаарлалтууд Бельги, Нидерланд, Австри, Итали, Хорват зэрэг улсад томоохон эсэргүүцлийн жагсаалыг өдөөсөн. Зарим жагсаал хүчирхийллээр өрнөж, олон арван жагсагчдыг баривчилснаас гадна жагсагчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнууд гэмтэж бэртжээ.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутаг даяар эвлэлдэн нэгдэх эрх чөлөө аюулд орсоор байна. Унгар улсад төрийн бус байгууллагуудад үндэслэлгүй хязгаарлалт тавьсан хуулиа хүчингүй болгосон ч түүнийг орлох хууль нь шинэ асуудал үүсгэсэн. Европын Холбооны Шүүх цагаачдад туслах явдлыг гэмт хэрэгт тооцсон өөр нэг хууль Европын холбооны хууль тогтоомжийг зөрчсөн болохыг тогтоов. Грек улсад цагаач, дүрвэгсэдтэй ажилладаг ТББ-уудыг бүртгэхийг хязгаарласан зохицуулалт хэвээр байна. Туркийн эрх баригчид Санхүүгийн арга хэмжээ авах ажлын хэсгийн (FATF) зөвлөмжийг ТББ-уудыг дарамтлах шинэ хууль батлах халхавч болгон ашигласан байна.

Бүс нутгийн зүүн хэсэгт эрх баригчид иргэний нийгмийн үйл ажиллагааг улс төрийн үйл ажиллагаатай илүү ихээр холбож, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарласан дүрмийг зөрчсөн тохиолдолд хорих ялаар шийтгэдэг болжээ. Орос улс олон тооны иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоох болон хориглох зорилгоор “гадаадын агент” болон “тааламжгүй байгууллага”-ын хууль тогтоомжийг системтэйгээр ашиглаж, эдгээр хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр тус улсын хүний эрхийн хамгийн нэр хүндтэй байгууллагуудын нэг болох “Мемориал”-ыг татан буулгажээ.

Оны эцэс гэхэд Беларусь улсад 270 гаруй иргэний нийгмийн байгууллагаг үндэслэлгүйгээр татан буулгасан буюу албадан хаажээ. Александр Лукашенко ВВС-д өгсөн ярилцлагадаа ТББ-уудыг улс төрийн сөрөг хүчнийхэнтэй холбож, “Та нарын [Барууныхан] санхүүжүүлж байсан бүх хог шаарыг устгана” гэж амласан байна. Узбекистанд “олон нийтийн холбоо, шашны байгууллага хууль бусаар байгуулах” тухай хязгаарлалтын журмыг зөрчвөл хорих ялаар шийтгэдэг хэвээр байна.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД

Улс орнууд хүний эрх хамгаалагчдыг ажлаа явуулахад аюулгүй, таатай орчноор хангах үүргээ зөрчсөөр байна. Нүүдэллэж буй хүмүүсийг хамгаалагчид захиргааны хязгаарлалт, мөрдлөг, дарамтад өртлөө. Эмэгтэйчүүдийн болон ЛГБТИ хүний эрхийг хамгаалагчид хүчирхийлэл, шударга бус яллах ажиллагаа, заналхийлэл, гүтгэлгийн кампанит ажилтай нүүр тулж байв.

Кипр, Франц, Грек, Итали, Мальта зэрэг улсад цагаачдын эрхийг хамгаалагчдад эрүүгийн хариуцлага хүлээлгэсээр байна. Итали болон Грек улсад хувь хүмүүс, төрийн бус байгууллагуудын эсрэг шүүх хурал үргэлжилсээр байв. 2021 онд мөн зарим цагаачдын эрхийг хамгаалагчдыг цагаатгасан, тухайлбал Их Британи дахь Стэнстэдийн хэргийг үүнд дурдаж болно.

Польшийн эрх баригчид Гэгээн Мариагийн хөргийг солонгон цагирагтай дүрсэлсэн постерийн улмаас “шашны итгэл үнэмшлийг доромжилсон” хэргээр буруутгагдсан гурван эмэгтэйг цагаатгахыг эсэргүүцэн давж заалдлаа. Аюулгүй, хууль ёсны үр хөндөлтийн тусламж үйлчилгээг дэмжигч эмэгтэйчүүдийн эсрэг гүтгэлгийн кампанит ажил өрнүүлж, амь насанд нь заналхийлж байв.

Турк улсад хүний эрх хамгаалагчид үндэслэлгүй мөрдөн байцаалт, ял шийтгэлтэй тулгарлаа. Үүний хамгийн том жишээ нь Осман Кавалагын хэрэг байлаа. Түүнийг нэн даруй суллахыг шаардсан ЕХЭШ-ын шийдвэр гарсан ч тэрээр дөрвөн жилийн дараа шинэ хэрэгт буруутгагдаж, хоригдсон хэвээр байв.

Оросод хүний эрх хамгаалагчдыг нухчин дарах явдал улам өргөжиж. Хүний эрхийн хуульч Иван Павловт “мөрдөн байцаалтын үр дүнг задруулсан” хэрэг үндэслэлгүйгээр тулгах үед тэрээр Оросоос дүрвэн гарсан бөгөөд “эрэн сурвалжлагдаж байгаа” хүмүүсийн жагсаалтад оржээ. Наталья Эстемироваг хулгайлж, хөнөөсөн хэргийг эрх баригчид зохих ёсоор мөрдөн шалгаагүй гэж ЕХЭШ үзжээ. Беларусь улсад нийгмийн бүх салбарын идэвхтнүүдийг мөрдөн хавчиж байв. Оны эцэс гэхэд тус улсын хүний эрхийн тэргүүлэгч байгууллага болох Виаснагийн долоон гишүүнийг үндэслэлгүйгээр саатуулж, эрүүгийн ял оноосон. Дур

зоргоороо баривчлахын эсрэг асуудлаарх НҮБ-ын ажлын хэсэг суллахыг шаардсан ч Азербайжаны засгийн газрын шүүмжлэгч Хусейн Абдуллаев шоронд хоригдсон хэвээр байгаа юм.

ДҮРВЭГСЭД БОЛОН ЦАГААЧДЫН ЭРХ

2021 онд хууль бус цагаачлалыг тогтоон барихын тулд хил дээр шинэ хана олныг барьсан бөгөөд хамгаалалтын дэглэм доройтож, хил дээрх үхэл, эрүү шүүлтийг өргөнөөр хүлээн зөвшөөрөх болжээ.

Грек улс Туркийг Афганистан, Сомали болон бусад орноос орогнол хүсэгчдэд аюулгүй улс гэж зарлав. Дани улс Сирийн дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг цуцалж, Сирид буцаах оролдлого хийсэн нь туйлын харамсалтай зүйл боллоо. Хэд хэдэн улс Афганистаны орогнол хүсэгчдийг талибанчууд эзлэн авахын өмнөхөн эх орон руу нь буцаажээ.

Беларусийн эрх баригчид Беларусь улсаар дамжин ЕХ-руу шилжих шинэ зам бий болгохыг дэмжиж, цагаачид болон дүрвэгсдийг Польш, Литва болон Латви улсын хил рүү хүчлэн шахсаны улмаас тэдгээр улс хил дээр орогнол хүсэх эрхийг хүчингүй болгож, хил дээрээс буцаах явдлыг хуульчилсан. Жилийн эцэс гэхэд олон хүн хил дээр гацаж, хэд хэдэн хүн нас баржээ. Туркээс Грек, Газар дундын тэнгисээс Итали руу.

Мароккоогоос Испани руу чиглэсэн “хуучин” нүүдлийн замуудаас ч “буцаах” явдал хэвээр байсан бол далайд аврагдсан хүмүүсийг хуурай газарт буулгахаасаа өмнө удаан хугацаагаар саатуулсан байна.

Олон улс орон хилээр нэвтрэхээс “сэргийлсэн” хүмүүсийн тоог ил тод зарласан нь ихэнхдээ тэдний хамгаалагдах хэрэгцээг үнэлэхгүйгээр бүгдийг буцаасан гэсэн үг юм. Турк, Унгарт зарласан тоо хэдэн арван мянгад хүрсэн бол Польш, Латви, Литватай хиллэдэг Беларусийн хил дээр зарласан тоо 40 000 давжээ.

Бусад олон улс дүрвэгсэд болон цагаачдыг хувь хүний нөхцөл байдлыг харгалзахгүйгээр түргэвчилсэн, хууль бус, албадан шилжүүлэх ажиллагаа явуулсан бөгөөд Грек, Хойд Македони, Босни Герцеговин, Хорват зэрэг улс үүнийг үгүйсгэв. БНХАУ-ын Шинжаанаас дүрвэж ирсэн казах угсаатнууд Казахстаны хилийг хууль бусаар нэвтэрсэн хэргээр яллагджээ.

Зарим шүүх ийм үйлдлийг хууль бус гэж хүлээн зөвшөөрсөн. Серби, Хорватын Үндсэн хуулийн шүүх цагдаа нар хүмүүсийг “буцаах” -даа эрхийг нь зөрчсөн гэж үзжээ. 2017 онд Серби рүү буцаасны дараа галт тэргэнд дайруулж амиа алдсан Афган охины эрхийг Хорват улс зөрчсөн гэж ЕХЭШ шийдвэрлэв. Итали, Австрийн шүүхүүд орогнол хүсэгчдийг Словени, Хорват руу удаа дараа хөөж гаргасан нь олон улсын хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзжээ. Гэсэн хэдий ч эдгээр шийдвэрийг эс харгалзан “буцаах” үйлдэл хийсэн, зүй бусаар харьцсан тохиолдолд хариуцлага хүлээх нь ховор байв.

ЕХ болон Итали улс цагаачдын эрхийг ноцтой зөрчиж байгаа Ливийн эргийн хамгаалалтынхны тус улс руу “буцаан татах” ажиллагааг санхүүжүүлэхэд хамсагч хэвээр байв. 10 дугаар сар гэхэд 27 000 гаруй дүрвэгсэд, цагаачдыг Ливийн эргийн хамгаалалтынхан Газар дундын тэнгисийн төв хэсэгт баривчилж, Ливи рүү буцаасан байна.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Хар арьстнууд, мусульманчууд, цыгануудын эсрэг арьс өнгөөр ялгаварлан гадуурхаж байгаа нь илэрхий боллоо. Их Британид засгийн газрын тайланд институцлагдсан арьс өнгөний үзлийн талаар анхаарал татсан асуудал байгааг үгүйсгэсэн хэдий ч цагдаагийн шинэ хуулийн төсөлд хар арьст, цыган нүүдэлчин хүмүүсийг илүү их ялгаварлан гадуурхах заалт орсон байна. Данийн эрх баригчид хууль тогтоомжоос “гетто”-г дурдсаныг хассан боловч “Барууны гаралтай бус” оршин суугчдад нийгмийн

орон сууцны хязгаарлалтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байв. Австри, Франц, Герман улс радикализм болон терроризмын эсрэг арга хэмжээ гэх шалтгаанаар исламын шашинтнуудыг мөшгин хянах ажиллагаагаа эрчимжүүлж, исламын сүмүүдийг нэгжиж, исламофобийг хянаж буй байгууллагуудыг хаажээ.

ЦЫГАН ХҮМҮҮС

Цыган хүмүүс дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна. Түүнчлэн боловсрол, орон байр, ажлын байр зэрэгт тусгаарлалт оршсоор байна. Тэдний амьдардаг газарт цагдаагийн хэт хяналт тавьж, сургуулийн хүрэлцээ дутмаг хэвээр байв. Чех, Грекийн цагдаа нарын гарт хоёр цыган амиа алдсан нь олны анхааралд өртөж, АНУ дахь Жорж Флойдын үхлийг санагдуулж байлаа.

1966-2012 оны хооронд эрх баригчдын хууль бусаар үргүй болгосон олон мянган цыган эмэгтэйчүүдэд нөхөн олговор олгох хуулийн төслийг олон жил хийсэн идэвхтнүүдийн кампанит ажлын үр дүнд Чехийн Сенат баталлаа. Словакийн засгийн газар олон мянган цыган эмэгтэйчүүдийг албадан үргүй болгосондоо албан ёсоор уучлалт гуйсан хэдий ч нөхөн төлбөрийн үр дүнтэй механизм бий болгохыг одоо хүртэл хийгээгүй байна.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

ЛГБТИ хүмүүс бүс нутаг даяар ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртсөөр байна. Польш, Унгар зэрэг хэд хэдэн улс ЛГБТИ хүмүүсийг гутаан доромжилсон, ялгаварлан гадуурхсан хууль тогтоомжийг хэлэлцэж, баталсан. Сербид ерөнхийлөгч иргэний хамтран амьдрагчдын тухай хуульд гарын үсэг зурахаас татгалзав. Болгар, Турк зэрэг улсад зарим улс төрчид ижил хүйстнийг үзэн ядсан үг хэллэг, үйлдэл хийжээ.

Туркменистан, Узбекистан улсад эрэгтэйчүүд хоорондоо болон ижил хүйстнүүд харилцан тохиролцож бэлгийн харилцаанд орохыг эрүүгийн гэмт хэрэгт тооцдог. ОХУ-ын “гей суртал ухуулгын” хууль нь ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхах явдлыг өөгшүүлсэн юм.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Польш, Андорра, Сан Марино, Мальта болон бусад улсад аюулгүй, хууль ёсны үр хөндөлт хүний эрхийн гол асуудал байсаар ирлээ. Польш улсад ургийн хүнд хэлбэрийн гажигтай үед үр хөндөлт хийхийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болов. Шийдвэр гарсны дараа нэг жилийн хугацаанд 34 000 эмэгтэй үр хөндөлтийн тусламж, зөвлөгөө авах зорилгоор гадаадад зорчих боломж олгодог “Хил хязгааргүй үр хөндөлт” ТББ-д хандсан байна.

Андорра улсад НҮБ-д тус улсын үр хөндөлтийг бүхэлд нь хориглосон асуудлыг хөндөн шүүмжилсэн хүний эрх хамгаалагчийн эсрэг бусдын нэр хүндийг гутаасан гэх хэргүүд үргэлжилсээр байна. Сан-Марино улсад олон нийтийн санал хураалтаар үр хөндөлтийг хуульчилсан нь эерэг үйл явдал байлаа.

ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИДЫН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл янз бүр байв. Турк улс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чухал гэрээ болох Истанбулын конвенцоос гарсан бол Молдав ба Лихтенштейн хоёр улс уг конвенцыг соёрхон баталжээ. Цаашилбал, Словени улс хүчингийн гэмт хэргийн тухай хуулиа зөвшөөрөлд суурилсан болгож өөрчилсөн бөгөөд хүчингийн гэмт хэргийн тухай хууль тогтоомжийн шинэчлэлийг Нидерланд, Испани, Швейцарь зэрэг улсад хийж байна.

Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл түгээмэл байна. Оросын

эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын консорциум 2011-2019 онд бусдын гарт амиа алдсан нийт эмэгтэйчүүдийн 66 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болохыг тогтоожээ. Узбекистаны Дотоод хэргийн яам “НеМолчи” ТББ-аас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн хэрэгт шүүхээр ял оноохыг хүссэн хүсэлтийг “ямар ч зорилгогүй” хэмээн татгалзсан байна. Азербайжанд эмэгтэйчүүдийн эрхийн идэвхтнүүд, сэтгүүлчдийг шантаажилж, жендерийн асуудлыг тусгайлан гутаан доромжлох кампанит ажилд өртсөн бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн эсрэг эмэгтэйчүүдийн жагсаалыг хүчээр тараажээ. Афганистанд Талибанчууд засгийн эрх авснаар Төв Азид “уламжлалт” үнэт зүйлсийг хөхиүлэн дэмжих хүчин чармайлтаа бэхжүүлэв. Украинд ижил хүйстнүүдийн эсрэг халдлага үргэлжилсээр байсан бөгөөд Донбассын засгийн газрын бус хяналтад байдаг газруудад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүст үзүүлэх үйлчилгээ хангалтгүй байгаа тухай мэдээлсэн.

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЭРХ

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө бүс нутгийн олон улс, ялангуяа ЕХ-д вакцинжуулалтын түвшин өндөр байснаар тодорхой хэмжээгээр буурсан байна. Гэвч цар тахал нь санхүүжилтгүй, хэт ачаалалтай эрүүл мэндийн тогтолцоонд асар их дарамт учруулаа.

Зарим улс Европын Хүний эрхийн тухай конвенцийг зөрчиж байсан бөгөөд хэд хэдэн улс халдварын цаашдын давалгаа, шинэ мутаци гарч ирсний улмаас эмнэлгийн онц байдлыг өргөтгөснөө зарлаж, шинэ хөл хорио, бусад хязгаарлалт тогтоосон.

Энэ бүс нутагт вакцинд эргэлзэх хандлага өндөр байсантай голчлон холбоотойгоор вакцины тэгш бус байдал улам бүр тодрох болсон. Тиймээс Исланд, Мальта, Португал, Испанид нийт хүн амын 80 гаруй хувь нь вакцинд хамрагдсан бол Армени, Беларусь, Босни ба Герцеговин, Гүрж, Киргизстан, Тажикистан, Украинд 30-аас бага хувь нь вакцинд хамрагдсан байна. Зарим тохиолдолд бичиг баримтгүй цагаачид, ялгаварлан гадуурхалтад өртөмтгий бүлгийн хүмүүс вакцинд хамрагдахад бэрхшээлтэй тулгарчээ. Нас баралт өндөр настнуудын дунд харьцангуй их хэвээр байв.

Европ вакцин хандивлах чиглэлээр ихээхэн амлалт өгсөн боловч Их Британи, Норвеги, Швейцарь болон ЕХ оюуны өмчийн эрхийг (TRIPS) түдгэлзүүлснээр үйлдвэрлэж буй вакцины тоог нэмэгдүүлэх боломжид хаалт хийсээр байгаа нь дэлхийн хэмжээнд вакцины тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж байна.

Украины Донбасст орон нутгийн эмнэлгийн байгууллагууд эмнэлгийн боловсон хүчин, багаж хэрэгсэл, тэр дундаа вакцины хүрэлцээ муу байснаас үүдэн ачааллаа дийлэхгүй болсон гэх мэдээлэл байна. Туркменистаны эрх баригчид тус улсад Ковид-19-ийн тохиолдол байгааг үгүйсгэсээр байсан ч долдугаар сараас насанд хүрэгчдийг заавал вакцин хийлгэхийг шаардах болжээ.

Ковид-19 цар тахал нь нийгмийн хамгааллын иж бүрэн тогтолцоо байхгүй үед маш олон ажилчдыг эрсдэлтэй байдалд оруулав. Ялангуяа эмэгтэйчүүд, цагаач ажилчид илүү эмзэг байв. Австри улсад цагаач асрагч эмэгтэйчүүд хүчирхийлэл, ялгаварлан гадуурхсан, шударга бус цалин хөлс, хэт олон цагаар ажиллах явдалтай тулгардаг. Италид асрамжийн газрууд дахь хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар санал бодлоо илэрхийлж, эвлэлдэн нэгдэхийг хүссэн эрүүл мэндийн болон асрамжийн газрын ажилтнуудын эсрэг сахилгын болон цээрлүүлэх арга хэмжээ авав. Арменид цар тахал нь эмэгтэйчүүд, охидын цалин хөлсгүй асарч тэтгэх ажлын хүнд ачааг улам нэмэгдүүлжээ.

ХЯМРАЛ МӨРГӨЛДӨӨНИЙ БҮС ДЭХ ХҮНИЙ ЭРХ

Хуучин ЗХУ-ын орнуудад хямрал мөргөлдөөнтэй бүсэд гарч байгаа өчүүхэн өөрчлөлт ч хөгжилд саад болж, харилцааны шугамын хоёр талын оршин суугчдын зорчих эрх чөлөө, эрүүл мэндээ хамгаалах эрхэд ихээхэн сөргөөр нөлөөлдөг байна.

2020 оны Армени-Азербайжаны мөргөлдөөний улмаас Азербайжанд шилжүүлэн өгсөн бүс нутагт Арменийн зэвсэгт хүчний тавьсан минээс үүдэн жилийн турш 100 гаруй хүн шархдаж, амь үрэгджээ. Энэхүү мөргөлдөөний үеэр үйлдэгдсэн дайны гэмт хэрэгт хариуцлага тооцох, хохирогчдод шударга ёсыг тогтоох боломжгүй байсан бөгөөд гал зогсоох хэлэлцээрийн дараа олзлогдсон 40 гаруй армени үндэстэн хүнлэг бус нөхцөлд олзлогдсон хэвээр байна. 2020 оны мөргөлдөөний үеэр дүрвэсэн Азербайжаны 40 000 энгийн номхон иргэний дийлэнх нь гэртээ буцаж ирсэн боловч мина, дэд бүтцийн сүйрэл, амь амьжиргаагаар алдсан зэрэг нь 1990-ээд оны үед дүрвэсэн 650 000 гаруй иргэнийг буцаж ирэхэд саад болсон юм. 36 000 орчим армени үндэстэн дотооддоо шилжин суурьшсан хэвээр байна.

Украины Донбасс муж дахь мөргөлдөөн засгийн газар болон Оросын дэмжлэгтэй салан тусгаарлагчид бие биенээ гал зогсоох дэглэм зөрчсөн гэж буруутган үргэлжилсэн бөгөөд НҮБ-ын Мониторингийн багаас Украины Аюулгүй Байдлын Нууц алба дор хаяж есөн удаагийн баривчилгаа явуулсан хэргийг шинээр бүртгэжээ. Оны сүүлээр Украинтай хиллэдэг хил дээрээ Орос олон тооны цэрэг цуглуулж, болзошгүй түрэмгийллийн айдас төрүүлэв.

Гүржийн салан тусгаарласан Абхаз, Өмнөд Осет/Цхинвали мужид засгийн газрын хяналтад байдаг нутаг дэвсгэрт хөдөлгөөнийг хязгаарласан байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах явдал үргэлжилсээр байгаа бөгөөд 2020 онд Өмнөд Осет/Цхинвали мужид баривчлагдсан Инал Жабиевын үхлийн талаар үр дүнтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй, Анри Атейба Абхазад хоригдож байхдаа нас баржээ.

УУР АМЬСГАЛЫН ХЯМРАЛЫН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Европ тив нь өнөөг хүртэл дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтад гүйцэтгэсэн үүрэг болон хөрөнгө чинээгээрээ уур амьсгалын хямралыг даван туулахад дэлхийн бусад орнуудын өмнө онцгой үүрэг хүлээдэг. Гэсэн хэдий ч Европын орнууд болон Европын Холбоо нь өөрсдийн хариуцлагын түвшин болон дэлхийн агаарын температурын өсөлтийг 1,5 хэмд барих зайлшгүй шаардлагад нийцүүлэн чулуужсан түлш ашиглахыг үе шаттайгаар зогсоох бодлого зэрэг ялгаруулалтыг бууруулах зорилтуудыг баталж чадаагүй хэвээр байна. Жил бүрийн НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх хэлэлцээний үеэр (COP26) Европын орнууд уур амьсгалын хямралын улмаас алдагдал, хохирол амсаж буй хөгжиж буй орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх дэлхийн санхүүгийн байгууллага байгуулахыг эсэргүүцсэн. Гэсэн хэдий ч Шотланд болон Бельгийн Валлониа мужууд алдагдал, хохиролд зориулж тусгай санхүүжүүлэлт гаргажээ.

Идэвхтнүүд Герман, Франц, Бельгид ялгаруулалтыг хязгаарлах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд засгийн газруудаас илүү хүчин чармайлт гаргуулахын тулд шүүхэд зарга мэдүүлэх аргыг ашиглаж,

хууль ёсны ялалт байгуулжээ. Иргэний нийгмийн байгууллагуудын шүүхэд мэдүүлсэн түүхэн заргын талаар Голландын шүүх Shell компанид нүүрстөрөгчийн ялгаруулалтаа 2030 оны эцэс гэхэд 2019 оны түвшинтэй харьцуулахад 45 хувиар бууруулах захирамж гаргажээ. Ингэхдээ бусад баримтуудын зэрэгцээ бизнесийн байгууллагуудын хүний эрхийг хүндэтгэх үүрэг хариуцлагад үндэслэн шийдвэрээ гаргасан байна. Гүрж улсад хүрээлэн буй орчны аюулгүй байдлын асуудлаарх эсэргүүцэл гарснаар усан цахилгаан станц барих ажлыг цуцалжээ.

УЛС ОРНЫ ДОТООДЫН БОЛОН ДЭЛХИЙ ДАЯАРХ ХҮНИЙ ЭРХ

Авторитар дэглэм рүү шилжих чиг хандлагыг дагалдан улс орнууд олон талт байгууллагуудаас холбоогоо таслах явдал нэмэгдэв. ЕАБХАБ хямрал мөргөлдөөн рүү хальтрах шилжилтийг зогсооход хүчин мөхөсдөж байсан бол томоохон улс орнууд тус байгууллагын зөвлөмжийг үл тоомсорлож, хөндлөнгийн хяналтыг нь үл хэрэгсэж байв. Европын зөвлөл нь гишүүн орнуудаасаа ЕХЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх, үүргээ биелүүлэхийг шаардаж чадсангүй. ЕХ нь хууль дээдлэх ёсны хямралын улмаас үйл ажиллагаа нь саармагжиж, цагаачид ба дүрвэгсдийн эрхийн талаар өөрийн дүрэм журмыг хэрэгжүүлэх хүсэлгүй байв.

Орос болон Хятад улс, ялангуяа дорно зүгт нөлөөгөө бэхжүүлсээр байв. Хоёр улс олон улсын хүний эрхийн тогтолцоог үл тоомсорлосон ба Орос улс хүн амаа нухчин дарах Беларусийн ажиллагааг дэмжсэн юм. ЕХ-ноос Орос, Беларусийн эсрэг тавьсан эдийн засаг, улс төрийн хориг арга хэмжээ нь хойно хойноосоо ирэх хэлмэгдүүлэлтийн давалгааг зогсоож чадсангүй.

Их Британид хилийн чанадад үйлдэгдсэн гэмт хэрэгт ял завших боломжийг олгосон хууль тогтоомжийг баталсан. Хилийн чанад дахь ажиллагааны тухай хууль нь хилийн чанад дахь цэргийн ажиллагаатай холбоотой шүүх хуралдаанд хязгаарлалт тогтоосон. Тухайлбал, иргэний нэхэмжлэлд хөөн хэлэлцэх хугацаа тогтоож, таван жилээс дээш хугацааны өмнө үйлдсэн ихэнх гэмт хэрэгт ял тулгахгүй байх заалт оруулсан.

Гэсэн хэдий ч зарим эерэг санаачилгыг баталсан. Гуравдугаар сард Европын зөвлөл цаазаар авах ял, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцахад ашигладаг бараа бүтээгдэхүүнийг худалдаалахын эсрэг арга хэмжээний тухай зөвлөмжийг батлав. Зарим улс орон зэр зэвсэг шилжүүлэх хариуцлагагүй үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авсан. Герман улс Йемений мөргөлдөөнд оролцож буй Саудын Араб улс руу зэвсэг экспортлохыг түдгэлзүүлсэн хугацаагаа сунгалаа. Франц улсад Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс руу зэвсэг шилжүүлэх ил тод байдлыг хангах үүднээс ТББ-ууд хуулийн процессыг эхлүүлжээ. Швейцарь улс дотооддоо мөргөлдөөнтэй, хүний эрхийг ноцтой буюу системтэйгээр зөрчих эрсдэлтэй улс орон руу зэвсэг экспортлохыг хориглосон хууль баталсан.

ЗӨВЛӨМЖ

Дээр дурдсан зүйлс нь засгийн газрууд хүний эрхийг хамгаалах, үүрэг хариуцлагыг хамтран хэрэгжүүлэх амлалтаа биелүүлэхийг сануулсан дохио юм. Одоогийн байдлаар уур амьсгалын идэвхтнүүд, хүний эрх хамгаалагчид асуудлыг яаралтай урагшлуулахыг хүсэж байгаа боловч аль аль нь засгийн газар, корпорациудын хүчтэй дарамт шахалтанд байна. Хүний эрхийн үйлсэд одоо илүү олон баатрууд хэрэгтэй байгаа бөгөөд эс бөгөөс сүүлийн хэдэн арван жилийн ололт амжилт устах эрсдэлтэй байна.

Засгийн газрууд хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг гутаан доромжилж, гэмт хэрэгт тооцохын оронд тэдний гүйцэтгэдэг нэн чухал үүргийг хүлээн зөвшөөрөх ёстой. Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хэрэгжүүлэх орон зайг янз бүрийн шалтагт үндэслэсэн төрийн халдлагаас хамгаалах ёстой. Улс орнууд мөшгин хяналтын нийгэм рүү хальтарч буйг зогсоож, хууль дээдлэх ёсыг хүндэтгэж, шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах явдлыг таслан зогсоох ёстой.

Ковид-19 цар тахал үргэлжилж байгаа энэ үед тус бүс нутгийн болон бусад бүс нутгийн улс орнууд вакциныг тэгш хүртээмжтэй түгээх, эмчилгээ болоод вакцинжуулалтыг нь хүлээн зөвшөөрөхүйц, боломжийн үнэтэй, хүртээмжтэй, хүн бүрт хүрэлцээтэй байлгахын тулд хамтран ажиллах нь зайлшгүй чухал юм.

Хямрал мөргөлдөөн, ядуурлаас дүрвэж буй хүмүүс аюулгүй газарт очихын төлөө хуурай газар болон далайд амиа алдаж байгаа тул засгийн газрууд Европ руу ирэх шаардлагатай байгаа хүмүүст, аюулгүй, тогтвортой цагаачлалын замыг өргөтгөх ёстой. Үүнд хүмүүнлэгийн виз олгох, суурьшуулах, олон нийтийн ивээн тэтгэлэг, гэр бүлийг буцааж нэгтгэх зэрэг хамаарна.

Засгийн газрууд эмэгтэйчүүд, охидын эсрэг ихэнхдээ далд үйлдэгддэг хүчирхийллийн эсрэг яаралтай тэмцэж, жендэрт суурилсан хүчирхийлэл, үндсэн шалтгааныг нь арилгахыг нэн тэргүүнд тавих ёстой. Бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгахын тулд хууль болон практикт илүү олон алхам хийх шаардлагатай байна.

ОЙРХ ДОРНОД, ХОЙД АФРИКИЙН БҮС НУТГИЙН ТОЙМ

Персийн булангийн зарим орнуудыг эс тооцвол бүс нутгийн олон засгийн газар КОВИД-19 цар тахлын хоёр дахь жилд ч хүн амаа вакцинжуулах зэрэг эрүүл мэндийн үйлчилгээг зохих ёсоор хүргэж чадахгүй байна.

Засгийн газрууд үг хэлэх эрх чөлөөг гэмт хэрэгт тооцох хатуу хууль тогтоомж нэвтрүүлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ноцтойгоор хязгаарласаар байгаа бөгөөд интернэтэд цензур тавьж, мөшгин хянах дижитал төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийсээр байв. Хүний эрх хамгаалагчид эрүүгийн ял шийтгэл, хорих ял, захиргааны арга хэмжээ, заналхийлэл, айлган сүрдүүлэлтэй нүүр тулав. Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох болсон бөгөөд аюулгүй байдлын хүчнийхэн тайван жагсаал цуглааныг хууль бусаар хүч хэрэглэн дарж байв. Тус бүс нутаг ачаалал хэтэрсэн, эрүүл ахуйн шаардлага хангаагүй бохир заваан шоронгийн нөхцөл нь хоригдлуудыг КОВИД-19 цар тахлаар халдварлах эрсдэлд оруулсан бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй, эрүү шүүлт болон бусад хэлбэрээр зүй бус харьцах явдлаас болж байдал улам дорджээ.

Олон улсын шинжтэй гэмт хэрэг үйлдсэн, хүний эрхийг ноцтой зөрчсөн гэх үндэслэлээр сэжиглэгдэж буй аюулгүй байдлын хүчнийхэн, цэрэг, зэвсэгт бүлэглэлийн гишүүд ямар ч ял шийтгэл хүлээсэнгүй. Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд дайны гэмт хэрэг үйлдэж, олон улсын хүмүүнлэгийн хуулийг ноцтой зөрчлөө. Сири болон Йемений эрх баригчид хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг хязгаарласан нь нэгэнт нөөц нь шавхагдаж байсан эрүүл мэндийн тогтолцоог улам дордуулав. Цэргийн дэглэмтэй зарим улс дайтаж буй талуудад хууль бусаар зэвсэг нийлүүлэн, цэргийн шууд дэмжлэг үзүүлснээрээ хүний эрхийн зөрчлийг улам хурцатгалаа. Эрх баригчид дүрвэгсэд, цагаачдыг баривчилж, тодорхойгүй хугацаагаар хорьж байсан нь ихэнхдээ хууль зүйн үндэслэлгүй байв. Йордан болон Ливан улс Сириэс ирсэн 3 сая гаруй дүрвэгсдийг хүлээн аваад байгаа ч олон мянган дүрвэгсдийг албадан гаргах, олон хүчин зүйлээр шалтаглан эх орон руу нь буцаажээ. Бүс нутгийн эрх баригчид бага цалинтай ажилчдыг ажлын байраа алдах, цалин орлогоо алдах эрсдэлээс хамгаалж чадсангүй. Цагаач ажилчдын оршин суух эрхийг ажил эрхлэлттэй уясан байдаг олон улс орны хувьд кафала (ивээн тэтгэх) тогтолцоо нь тэднийг онцгой эмзэг нөхцөлд оруулжээ.

Бэлгийн дарамтаас эхлээд "нэр төрийн" аллага гэх мэт эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэлд ял шийтгэл оноолгүй орхиж, гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэх төрийн үүрэг амлалт хөсөр хаягдаж, хяналтгүй үргэлжилсээр байна. Эрх баригчид ЛГБТИ хүмүүсийн эрхийг маш ихээр зөрчиж, олон хүнийг бэлгийн чиг хандлага, хүйсээс нь шалтгаалан баривчилж, зарим эрчүүдийг шулуун гэдэсний үзлэгт албадан хамруулсан байна. Бүс нутаг даяарх шашны болон үндэстний цөөнхийн бүлгийн гишүүд нь олон төрлийн ялгаварлан гадуурхалтад өртөж байна.

ЭРҮҮЛ БАЙХ ЭРХ

Египет, Иран, Тунис, Ливи зэрэг улсад Ковид-19 цар тахлын эсрэг вакциныг нэвтрүүлэхдээ ил тод бус, хангалттай зөвлөлдөөгүй, эрсдэлт бүлгийн эрэмбийг тогтоох ажил удаашралтай, дүрвэгсэд, цагаачид, дотооддоо шилжин суурьшигч,

хоригдлууд, орон гэргүй болон бичиг баримтгүй хүмүүс зэрэг нийгмийн гадуурхагдсан, орхигдсон бүлгүүдийг тэгш, шударгаар хүртээмжтэй хамруулж чадаагүй.

Вакцинжуулалтын хүртээмжид улс төрийн хүчин зүйлс нөлөөлөв. Иран улсад вакцинжуулалт удааширсан нь Их удирдагчийн 1-р сард гаргасан Их Британи, АНУ-д үйлдвэрлэсэн вакциныг хориглох шийдвэрээс голчлон хамаарсан бөгөөд 8 дугаар сард уг хоригийг цуцалсны дараа вакцинжуулалт хурдацтай явагдаж, оны эцэс гэхэд хүн амын 80 гаруй хувь нь 1-р тунгаа хийлгээд байв. Тунис улс 7 дугаар сарын дунд үе гэхэд нэг сая хүн тутамд хоногт ногдох нас баралтын тоогоороо дэлхийд хоёрдугаарт бичигдэж байсан бөгөөд хүн амын дөнгөж 6 хувь нь вакцинжуулалтад хамрагдсан нь вакцинжуулалт дутагдалтай байгааг илтгэж байв. Гэхдээ Ерөнхийлөгч Кайс Саид парламентыг татан буулгаж, онцгой бүрэн эрхээ зарласны дараа вакцинжуулалт хурдацтай явагдаж, оны эцэс гэхэд хүн амын 46 хувь нь вакцинд хамрагдаад байв. **Институцлагдсан** ялгаварлан гадуурхалтын жишээ болгож Израйлийн Баруун эрэг болон Газын зурваст 5 сая орчим палестинчуудыг вакцинжуулах кампанит ажилд хамруулаагүй байна.

Тунис, Марокко зэрэг улсад төрийн болон хувийн хэвшлийн ажлын байранд нэвтэрч буй, мөн тус улсаас гадагш зорчих бүх хүнийг заавал вакцины үнэмлэхтэй байхыг шаардах болсон. Тунист ажил олгогчдод вакцин хийлгээгүй ажилчдыг цалин хөлсгүйгээр сул зогсоох вакцинжуулалтын тухай тогтоол гаргасан нь ажилчдын бусад эрхийг зөрчих нөхцөл бүрдүүлсэн.

Персийн булангийн улсууд болон Израйлийг эс тооцвол цар тахлын хоёр дахь жил бүс нутгийн хэмжээнд эрүүл мэндийн тогтолцооны сул дорой байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, үнэ тарифийн асуудлыг ил болгов. Ливан улсын засгийн газар эдийн засгийн хямралын үед эрүүл мэндийн нэн чухал байгууллагууд, тэр дундаа эмнэлгүүдийг түлш шатахуунаар хангах, нийгмийн хамгааллын ямар нэг төлөвлөгөө гаргаж чадаагүй. Мөн 11 дүгээр сард Засгийн газар нь эрчимтэй өсч буй үнийг төлөх чадамжгүй архаг хууч өвчтэй хүмүүст шаардлагатай эм ханган нийлүүлэлтийг хийлгүй эмийн татаасыг зогсоожээ. Египетэд зургаадугаар сард батлагдсан улсын төсөв нь засгийн газрын төсвийн 3 хувийг эрүүл мэндийн салбарт хуваарилна гэж Үндсэн хуульд тусгасан заалтын хэмжээнд хүрч чадаагүй ба эрүүл мэндийн даатгал, эм тарианд зарцуулах төсвийн хэмжээг бууруулсан байна. Сирийн засгийн газар хорт хавдар, чихрийн шижинтэй өвчтөнүүдэд чиглэсэн хүмүүнлэгийн тусламжийн хүртээмжийг хязгаарласнаар Зүүн хойд Сирийн эрүүл мэндийн салбарт үүсээд буй хомсдолыг улам дордуулжээ. Зэвсэгт бүлэглэлүүд эрүүл мэндийн болон хүмүүнлэгийн ажилтнууд руу халдлага үйлдсээр байгаа Ливи улсад зэвсэгт мөргөлдөөний улмаас үүссэн эвдрэл гэмтэл болон эмнэлгийн тоног төхөөрөмж, дэд бүтэцгүйгээс Ковид-19-ийн тусгаарлах хэд хэдэн байгууламжийг хаажээ.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн эрх баригчид тайван замаар үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө хүмүүсийг баривчилж, цагдан хорьж, ял тулгасаар байна. Ингэхдээ эрх баригчид Эрүүгийн хуулийн “доромжилсон бол” хэмээгдэх субъектив заалтыг ихэвчлэн ашиглан цар тахлын эсрэг авч буй хариу арга хэмжээг шүүмжлэгчдийг, мөн шүүмжлэгчдийг хорьсныг шүүмжилсэний төлөө ял оноож байна.

Иракийн Курдистан бүсийн шүүхээс нийгмийн сүлжээ ашиглан явуулсан сэтгүүл зүйн ажилтай нь холбоотойгоор таван идэвхтэн, сэтгүүлчид тус бүрийг бүрхэг заалттай хуулийн заалтад үндэслэн зургаан жилийн хорих ял оноосон байна. Курдистаны орон нутгийн засаг захиргаа уг яллах ажиллагаагаа “үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс” зайлшгүй шаардлагатай хэмээн зөвтгөсөн байна. Түүнчлэн Саудын Араб улсад Абурурахман аль-Садханыг засгийн газрын эдийн засгийн бодлогыг шүүмжлэн жиргэснийх нь төлөө 20 жилийн хорих ялаар шийтгэж, мөн ижил хугацаагаар хилийн хориг тавьсан байна.

Мароккогийн шүүх YouTube хэрэглэгч Жамила Сааданег эрх баригчдыг биеэ үнэлэгчдийн сүлжээ, хүний наймааг нуун дарагдуулсан хэмээн буруутгасан бичлэг байршуулж, нийтэд дэлгэснийх нь төлөө төрийн байгууллагуудыг “доромжилсон” хэргээр гурван сарын хорих ял оноосон. Алжирт эрх баригчид хууль ёсны эрхээ эдлэж, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэн үйл ажиллагаа явуулсных нь төлөө хүмүүсийг яллахдаа терроризмтой холбоотой тодорхой бус зүйл заалт ашиглах нь нэмэгдсээр байна. Бүс нутгийн засгийн газрууд үг хэлэх эрх чөлөөг гэмт хэрэгт тооцох харгис хууль тогтоомжийн төслийг өргөн барьжээ. Ливийн парламент цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эрс хязгаарласан, мөшгин хянах, цензурдахыг Засгийн газарт зөвшөөрсөн, “ёс суртахуунгүй” гэж үзсэн контентыг түгээсн тохиолдолд хорих ялаар шийтгэх тухай кибер гэмт хэргийн тухай хуулийг баталжээ. Египетэд ерөнхийлөгч цар тахлын талаарх мэдээллийг нийтэлсэн тохиолдолд тодорхой бус үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийг соёрхон баталсан байна. Ираны эрх баригчид ард иргэдэд Ковид-19 цар тахлын эсрэг вакцинаар хүртээмжтэй хангаж чадаагүй гэсэн үндэслэлээр засгийн газрын эсрэг зарга мэдүүлэхээр ярилцсан зургаан хүнийг баривчилж, шүүхэд шилжүүлжээ.

Тунисын Эрүүл мэндийн яам жагсаалтад багтсанаас бусад эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг Ковид-19 цар тахлын талаар олон нийтэд мэдээлэхийг хориглож, зөрчвөл сахилгын шийтгэл ногдуулах эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж сүрдүүлэв.

Бүс нутгийн засгийн газрууд интернэтэд цензур тавьсаар байна. Египет, Палестины эрх баригчид цахим хуудсууд руу хандахыг хориглосоор байсан бөгөөд Ираны эрх баригчид нийгмийн сүлжээний платформуудыг хаасан байна.

ХҮВИЙН НУУЦТАЙ БАЙХ ЭРХ

Энэ бүс нутгийн засгийн газрууд хүний эрх хамгаалагчдыг мөшгин онилох зорилгоор хяналтын системийн **NSO Групп** компанийн “Пегасус” тагнах програм гэх мэт өндөр дижитал төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийсээр байв. Долдугаар сард Forbidden Stories мэдээллийн байгууллагуудын нэгдэл нь Эмнести Интернэшнлийн техникийн дэмжлэгтэйгээр бүс нутаг даяар “Пегасус” тагнах программыг ашиглаж буй цар хүрээг ил болгож, Марокко, АНЭУ, Саудын Араб, Бахрейны засгийн газар үйлчлүүлэгчид нь болохыг тодорхойлжээ. Долдугаар сард Мароккогийн шүүх олон улсын шударга шүүхийн хэм хэмжээг зөрчин эрх баригчдыг байнга шүүмжилдэг сэтгүүлч Омар Радиг “тагнуул хийсэн”, “хүчингийн хэрэгт буруутган” зургаан жилийн хорих ял оноосон байна. Мароккогийн эрх баригчид 2019 оны 1-р сараас 2020 оны 1-р сарын хооронд түүний iPhone утсанд “сүлжээний тарилга” хийх замаар тагнаж байсан юм.

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИД БА ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Бүс нутгийн хүний эрх хамгаалагчид өөрсдийнх нь амыг таглаж, ял оноохыг эрмэлзэж байгаа эрх баригчдын эсрэг эр зоригтой сөрөн зогссоныхоо төлөө ихээхэн хохирол амссаар байна. Саудын Арабын эрх баригчид **өөрөөр сэтгэгчдийг** нухчин дарах ажиллагаагаа зогсолтгүй үргэлжлүүлж, олон хүнд ял оноолоо. Шүүхээс таван хүний эрх хамгаалагчийг зөвхөн хүний эрхийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаатай нь холбоотой хэргээр 20 хүртэлх жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, зорчих эрхийг нь удаан хугацаагаар хориглосон байна. Израйльд Израйлийн Батлан хамгаалах яам Палестины нэр хүнд бүхий иргэний нийгмийн зургаан байгууллагыг нууц мэдээлэл тараасан хэмээн үндэслэлгүйгээр буруутган “террорист” гэж тодорхойлж хэвийн үйл ажиллагааг нь саатуулжээ. Мөн Израйль улс НҮБ-ын хүний эрхийн шинжээч, мөрдөн байцаагч гэх мэт олон улсын хүний эрхийн ажиглагч, мөрдөн байцаагчдыг өөрийн оронд нэвтрүүлэхээс татгалзсаар байв.

Египетэд хүний эрх хамгаалагчид улс төрийн зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэн шалгах, шүүхээс гадуур тэнсэн харгалзах арга хэмжээ авч, үндэслэлгүйгээр шоронд хорих, гадаадад зорчихыг хориглох, хөрөнгийг нь битүүмжлэх, "террористуудын жагсаалт"-д хууль бусаар оруулах зэрэгт өртсөөр байгаа нь үндсэндээ иргэний эрхэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцохыг нь хориглосон хэрэг юм. Ливид цэргийнхэн болон зэвсэгт бүлэглэлүүд Ерөнхийлөгчийн сонгууль эхлэхээс хоёр хоногийн өмнө буюу 12-р сарын 22-нд тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байсан Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө хүн хулгайлах, заналхийлэх, айлган сүрдүүлэх замаар иргэний нийгмийн идэвхтнүүд рүү хийх дайралтаа эрчимжүүлэв.

ЖАГСААЛ ЦУГЛААН БА ХУУЛЬ БУС ХҮЧ ХЭРЭГЛЭХ

Засгийн газрын Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээний нэг хэсэг болгон олон нийтийн цугларалтыг байнга хориглож байсан хэдий ч бүс нутгийн олон оронд хүмүүс жилийн турш ихэвчлэн нийгэм, эдийн засгийн эрхээ шаардаж эсэргүүцлийн жагсаал зохион байгуулж байв. Тунист 1-р сард үргэлжилсэн жагсаалын давалгааны үеэр цагдаа нар 1500 гаруй хүнийг баривчилжээ. Алжир, Ирак, Ливанд эсэргүүцлийн хөдөлгөөнүүд жилийн турш үргэлжилсэн ба жагсагчдыг баривчилж, зодож, зарим тохиолдолд зөвхөн тайван жагсаалд оролцсоных нь төлөө яллаж байв.

Бүс нутгийн аюулгүй байдлын хүчнийхэн эсэргүүцлийн жагсаалыг тараахдаа хүч хэтрүүлэн хэрэглэх буюу шаардлагагүй үед хүч хэрэглэх нь түгээмэл байв. Иранд аюулгүй байдлын хүчнийхэн тайван жагсаалыг тараахын тулд галт зэвсэг хэрэглэсний улмаас доод тал нь 11 хүн амиа алдаж, олон зуун хүн шархадсаны дотор хараагүй болсон ч хүн байв. Түүнчлэн жагсагчид болон ойр орчимд байсан хөндлөнгийн хүмүүсийг үндэслэлгүйгээр хоморголон баривчилж, жагсаалын үеэр интернэтийг хааж байв. Иракт Курдистаны бүсийн засгийн газар эсэргүүцлийн жагсаалд оролцсон 100 гаруй хүнийг баривчилжээ. Мөн Иракийн аюулгүйн хүчнийхэн 1-р сараас 5-р сарын хооронд эсэргүүцлийн жагсаалыг тараахын тулд галт зэвсэг ашиглах зэргээр хүч хэтрүүлэн хэрэглэсэн байна.

Ливанд эдийн засгийн уналтаас үүдсэн мөргөлдөөний дараа 1-р сард аюулгүй байдлын албаныхан галт зэвсэг хэрэглэж, олон арван хүнийг баривчилж, улмаар цэргийн шүүхэд шилжүүлсэн **нь ховор тохиолдол** юм. Йорданы эрх баригчид эдийн засгийн нөхцөл хүндэрч байгааг эсэргүүцсэн жагсагчдын эсрэг нулимс асгаруулагч хий их хэмжээгээр хэрэглэж, эв санааны нэгдлийн жагсаал зохион байгуулахаас сэргийлж багш нарын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийг баривчилжээ.

Тав, зургадугаар сард Израйлийн цагдаа нар Зүүн Иерусалимд газар албадан чөлөөлж байгаа, Газын зурваст цэргийн цохилт өгч байгааг эсэргүүцэж жагссан Израйлийн Палестин иргэдийн эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэж, жагсаалыг зохион байгуулагчид, оролцогчдыг олноор нь баривчилжээ.

Баривчлагдсан хүмүүсийн дийлэнх нь хүчирхийлэлтэй холбоогүй зөрчлийн хэрэг үйлдсэн хэмээн буруутгагдсан байна. Баруун эрэг дэх Палестины эрх баригчдыг шүүмжилдэг нөлөө бүхий идэвхтэн хорионд байхдаа нас барсны улмаас Палестины хотуудад жагсаал цуглаан өрнөсөн бөгөөд эрх баригчид шаардлагагүй байхад хүч хэтрүүлэн хэрэглэв. Жагсагчид болон жагсаалын ойр орчимд байсан хөндлөнгийн хүмүүсийг баривчилж, эрүүдэн шүүжээ.

ХОРИГДЛУУДЫН ЭРХ

Хэд хэдэн оронд хоригдлуудыг хэт олон хүнтэй, агааржуулалт муу, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хангалттай хоол хүнс, усаар хангадаггүй хэрцгий, хүнлэг бус нөхцөлд хорьж байсан нь тэднийг Ковид-19 болон бусад халдварт өвчинд өртөх эрсдэлд оруулжээ. Египет шиг давж заалдах боломжгүйгээр урьдчилан хорих газарт удаан хугацаагаар саатуулах, Ливи шиг цагаачлалын статусын улмаас тодорхойгүй хугацаагаар саатуулах, Израйль, Палестин шиг захиргааны журмаар саатуулах зэрэг үндэслэлгүй баривчлагаанаас шалтгаалан шоронгийн даац хэтрэх явдал түгээмэл байна. Зарим улс оронд нийтийн хөл хорионы үеэр болон зарим үед түүнээс ч урт хугацаагаар хоригдлуудад гэр бүлийнхэнтэйгээ харилцах өөр арга хэрэгслээр хангахгүйгээр хорих ангид эргэн очихыг хориглож байв.

Бус нутаг даяар эрх баригчид хоригдлуудыг эрүүл мэндийн зохих тусламж үйлчилгээгээр хангаж чадаагүй бөгөөд зарим тохиолдолд өөрөөр сэтгэгчдийг шийтгэх зорилгоор зориуд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлээгүй байна. Мөн нилээдгүй орны засгийн газар хоригдлуудыг цаг тухайд нь вакцинжуулалтад хамруулж чадаагүй. Иранд хоригдлуудыг вакцинжуулах ажил 8-р сар хүртэл эхлээгүй бөгөөд Египетэд улс төрийн шалтгаанаар хоригдож байсан зарим хоригдол, тэр дундаа ахимаг настай, эсвэл эрүүл мэндийн эрсдэлт бүлгийн хоригдлуудыг вакцинжуулалтаас хасчээ.

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ЗҮЙ БУС ХАРЬЦАХ

Бүх төрлийн цагдан хорих газарт “хэрэг хүлээлгэх” зорилгоор хүнд нөхцөлд тодорхойгүй хугацаагаар ганцаарчлан хорих зэргээр эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах явдал дор хаяж 18 улсад гарсан байна. Египет, Иран, Ливи, Саудын Арабын эрх баригчид эрүү шүүлт тулгасан, тэр дундаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс санаатайгаар татгалзсаны улмаас хоригдож байхдаа нас барсан хэргийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулаагүй байна.

Ливанд Сирийн дүрвэгсэд эрүү шүүлтэд өртсөн 26 тохиолдол бүртгэгдсэний дотор терроризмтой холбоотой хэргээр хоригдож байсан дөрвөн хүүхдийг цэргийн тагнуулын ажилтнууд болон бусад хүмүүс эрүүдэн шүүсэн байна. Хоригдлууд эрүү шүүлтэд өртсөн гэдгээ шүүхэд мэдэгдсэн ч эрх баригчид эрүү шүүлттэй холбоотой нэхэмжлэлийг мөрдөн шалгаагүй орхижээ. Нэр хүндтэй улс төрийн шүүмжлэгч Низар Банатыг Палестины Аюулгүй байдлын хүчнийхэн Баруун эргийн Өмнөд хэсгийн Хеброн хотод баривчилж, эрүүдэн шүүсний улмаас нас баржээ. Задлан шинжилгээгээр түүний биеийн бүх хэсэгт хугаралт, хөхрөлт, зулгаралт илэрсэн байна.

Бүс нутгийн хэд хэдэн орны хууль тогтоомжид ташуурдах, мөчийг нь тайрах, нүдийг нь сохлох, чулуугаар шидэх, цовдлох зэрэг бие махбодын шийтгэлийг хэрэглэсээр байна. Иран, Ливид ташуурдах шийтгэлийг гүйцэтгэжээ.

ЦААЗААР АВАХ ЯЛ

Бүс нутгийн улс орнууд хүний амь насыг санаатайгаар бүрэлгэхээс бусад гэмт хэрэг болон ижил хүйстнүүдийн сайн дурын үндсэн дээрх бэлгийн харьцаа зэрэг олон улсын хуулиар хамгаалагдсан үйлдэлд цаазаар авах ял оноосоор байна. Египет, Иран, Ливи, Саудын Арабын терроризмын эсрэг, цэргийн, онцгой байдлын болон хувьсгалын шүүхүүд туйлын шударга бус шүүх хурлаар цаазаар авах ялыг оноож байв. Дор хаяж зургаан улсад цаазаар авах ялыг гүйцэтгэсэн бөгөөд заримдаа гэр бүлийнхэнтэй нь эцсийн удаа уулзуулалгүйгээр нууцаар гүйцэтгэжээ.

Иран, Саудын Арабын эрх баригчид 18 нас хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэргийнхээ улмаас цаазаар авах ялаар шийтгэгдэн цаазлагдсан байна.

ЯЛ ЗАВШИХ ЯВДАЛ

Олон улсын шинжтэй гэмт хэрэг үйлдсэн, хүний эрхийг ноцтой зөрчсөн, тухайлбал хууль бусаар бусдыг хөнөөх, эрүүдэн шүүх, хүчээр сураггүй болгох, хүчиндэх зэрэг гэмт хэрэгт сэжиглэгдсэн аюулгүй байдлын хүчин, зэвсэгт бүлэглэлийн гишүүд ял завших явдал тус бүс нутагт гаараад байна. Ливийн эрх баригчид НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хоригт багтсан хүчирхийлэл үйлдэгч, зэвсэгт бүлэглэлийн командлагч, гишүүдийг төрийн байгууллагуудтай хамтран ажиллахыг зөвшөөрөх буюу албан тушаалд томилж, тушаал дэвшүүлж байв. 2011 онд эцгийнхээ засаглалыг эсэргүүцсэн жагсаалыг хүчээр нүхчин дарахад гүйцэтгэсэн үүргийнх нь төлөө ОУЭШ-ээс эрэн сурвалжилж байсан Саиф аль-Ислам аль-Каддафи эрх чөлөөтэй явж байгаа төдийгүй өөрийгөө ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч хэмээн танилцуулжээ. Иранд Эбрахим Раиси 1988 онд үйлдэгдсэн үй олноор нь сураггүй алга болгох, шүүхээс гадуур цаазлахтай холбоотой хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт шалгагдахын оронд ерөнхийлөгчийн албан тушаалд дэвшжээ. Египетийн эрх баригчид цэргийнхэн баруун нутгийн элсэн цөлд хүний наймааны хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийг шүүхээс гадуур цаазлаж байсан тухай “ Disclose ” ТББ-ын мэдэгдлийг шалгахын оронд тус улсын бүх томоохон сүлжээнүүдийн домэйныг хаажээ. Ливанд эрх баригчид 2020 онд болсон Бейрут боомтын дэлбэрэлтийн мөрдөн байцаалтад жилийн турш удаа дараа саад учруулж, улс төрчид, албан тушаалтныг шүүхийн зарлан дуудахаас хамгаалах олон арга хэмжээг авчээ.

Тунист Ерөнхийлөгч Кайс Саид парламентаа долдугаар сард тараасны дараа 10 удаа цэргийн шүүх хурал болсны дотор ерөнхийлөгчийг шүүмжилсэн хэргээр 4 энгийн иргэнийг шүүсэн нь өмнөх жилүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Шилжилтийн үеийн шударга ёсны үйл явцын нэг хэсэг болох хүний эрхийг зөрчсөн аюулгүй байдлын албаны гишүүдийн эсрэг арван удаагийн шүүх хурал гурав дахь жилдээ сунжирч, ямар ч шийдвэр гаргасангүй.

Олон улсын түвшинд гэмт этгээдүүдэд хариуцлага тооцох чиглэлээр зарим нэг алхам хийгдлээ. 10-р сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2016 оноос хойш Ливид үйлдэгдсэн олон улсын шинжтэй гэмт хэргийг мөрдөн шалгах Баримт тогтоох комиссын бүрэн эрхийг сунгажээ. 1988 онд шоронд болсон **өргөн хүрээтэй** аллагад оролцсон хэргээр Шведэд баривчлагдсан Ираны албан хаагч асан Хамид Нуригийн хэргийг шүүхийн түгээмэл харьяаллын зарчмын дагуу шүүх хурал 8-р сард эхэлсэн. Европын дор хаяж дөрвөн улс Сири улсад дайны гэмт хэрэг үйлдсэн, олон улсын шинжтэй бусад гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй хүмүүсийг үндэсний шүүхээрээ хэлэлцэж, ялласан байна. 2-р сард Германд Сирийн аюулгүй байдлын ажилтан асанд Дамаск хотод хоригдож байсан жагсагчдыг эрүүдэн шүүхэд тусалж дэмжсэнийх нь төлөө хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт буруутгаж, ял оноосон. Гэсэн хэдий ч Саудын Араб, Бахрейны лобби нөлөөллөөр Йемен дэх олон улсын хүмүүнлэгийн хууль зөрчсөн үйлдлийг олон улсын, шударга бус мөрдөн шалгах цорын ганц механизм болох Йемений асуудлаарх НҮБ-ын Олон улсын болон бүс нутгийн тэргүүлэх шинжээчдийн бүлгийн үйл ажиллагааг зогсооход хүргэв.

АРЬС ӨНГӨӨР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ҮЗЭЛ

Израйль улс газар нутгийг нь хуваах, тусгаарлах, хяналт тавих, газар болон өмч хөрөнгийг нь хураах, эдийн засаг, нийгмийн эрхийг нь үгүйсгэх замаар Палестинчуудыг дарангуйлах, ноёрхох тогтолцоог хэвээр хадгалсаар ирсэн нь хүний эрхийг зөрчиж, олон улсын хэмжээнд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах хууль бус үйлдэл юм. Израйль улс энэхүү тогтолцоог хадгалах зорилгоор Палестинчуудын эсрэг хууль бус үйлдлүүд, тухайлбал албадан шилжүүлэх, захиргааны журмаар баривчлах болон эрүүдэн шүүх, хууль бус аллага, үндсэн эрх, эрх чөлөөг үгүйсгэх, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болох хавчин гадуурхах зэрэг хууль бус үйлдэл хийсээр байна.

ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨН

Ирак, Ливи, Йемен, Сирийн олон жилийн зэвсэгт мөргөлдөөнтэй, аюултай байдал нь энгийн номхон иргэдийн амьдралыг бусниулсан хэвээр байгаа бөгөөд төрийн болон төрийн бус этгээдүүдийн хүчирхийллийн цар хүрээ харилцан адилгүй түвшинд байгаа нь тухайн газар нутагт эрх барьж байгаа эвслүүд, гадны дэмжигч хэн байхаас хамаарч байна. Мөргөлдөөний олон оролцогчид дайны гэмт хэрэг үйлдэж, олон улсын хүмүүнлэгийн болон хүний эрхийн хуулийг ноцтой зөрчсөн.

Бараг бүх талууд агаараас цохилт өгөх хэлбэрээр энгийн номхон иргэдийн амь насыг хохироож, шархдуулж, орон сууцны хорооллыг их буу, миномёт, пуужингаар буудаж, замбараагүй халдлага үйлдэж байв. Ливид үндэсний гал зогсоох хэлэлцээр байсаар байтал орон сууцны хороололд зэвсэгт бүлэглэл, зэвсэгт хүчний хооронд үе үе мөргөлдөөн гарч, энгийн номхон иргэд амь үрэгдэж, иргэний дэд бүтцэд гэмтэл учирсан. Йеменд Саудын Араб тэргүүтэй эвсэл болон Хутхигийн арми хууль бус халдлага үйлдсээр байсан бөгөөд дотоодын дүрвэгсдийн хуаран, хоол хүнс түгээх байгууламж зэрэг иргэний объект руу цохилт өгч, олон тооны энгийн номхон иргэдийн амь насыг хөнөөж, шархдуулсан байна. Сирид засгийн газар нь Оросын армийн дэмжлэгтэйгээр баруун хойд хэсэгт халдлага үйлдэж, орон сууцны барилга, зах, эмнэлгүүдэд цохилт өгчээ.

Дайны гэмт хэрэг болон бусад халдлага үйлдэхэд ашигладаг зэвсгийг шилжүүлэх ажиллагаа үргэлжилсээр байв. Орос, Турк, АНЭУ нь НҮБ-аас Ливид тавьсан зэвсгийн хоригийг зөрчиж, гадаадын хөлсний цэргүүд, цэргийн техник хэрэгслийг ашигласаар байна. 10-р сард АНЭУ-д үйлдвэрлэж, экспортолсон хуягт машинуудыг Триполи хотод дүрвэгсэд болон цагаачдын эсрэг дайралт хийхэд ашиглажээ.

Ливи болон Сирид хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг хязгаарлах нь зарим тоглогчдын тактик байсаар байв. Ливид зэвсэгт этгээдүүд улс төрийн зорилгоор олон сая ливичүүдийн цэвэр усны хангамж руу хэд хэдэн удаа халдлага үйлдсэн. Сирийн засгийн газрын цэргүүд 6-р сараас 9-р сарын хооронд Дара аль-Балад дахь олон мянган энгийн номхон иргэдийг бүслэн хоол хүнс, эмнэлгийн хэрэгсэл болон бусад амь нас аврах тусламж хүргэхийг хориглосон байна.

5-р сард болсон зэвсэгт мөргөлдөөний үеэр Израйль улс Газын зурваст дайны гэмт хэрэг үйлдсэн нь тодорхой боллоо. Наад зах нь 242 палестин хүн амь үрэгдсэний 63 нь хүүхэд байсан ба олон мянган хүн шархаджээ. 74 мянга гаруй палестинчууд гэр орноо орхин дүрвэжээ. Газын зурвас дахь Палестины зэвсэгт бүлэглэлүүд хууль бус халдлага үйлдэж, Израйль руу олон мянган пуужин харвасны дийлэнхийг Израйль улс замаас нь сөнөөж байсан хэдий ч Израйлийн 13 иргэн амь үрэгджээ.

ДҮРВЭГСЭД, ДОТООДЫН ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ЭРХ

Эрх баригчид дүрвэгсэд болон цагаачдыг ихэнхдээ хууль эрх зүйн үндэслэлгүйгээр, тийнхүү саатуулах нь хууль ёсны эсэхийг давж заалдах боломжгүйгээр баривчлан, тодорхойгүй хугацаагаар саатуулсаар байна. 10-р сард Ливийн аюулгүйн хүчин болон Триполид төвтэй зэвсэгт бүлэглэлүүд Африкийн Сахараас өмнөд бүсийн 5000 гаруй иргэд, хүүхдүүдийг баривчлахын тулд хууль бус хөнөөлт зэвсэг ашиглажээ.

Ливи, Йемен, Саудын Арабт төрийн болон төрийн бус тоглогчид дүрвэгсэд болон цагаачдыг хууль бусаар хөнөөх, аюултай нөхцөлд үндэслэлгүй саатуулах, эрүүдэн шүүх буюу бүсэд хэлбэрээр зүй бус харьцах, хүчиндэх болон бусад хэлбэрийн бэлгийн хүчирхийлэл үйлдэх зэрэг олон төрлийн гэмт хэрэг үйлдсээр байна. Ливид Европын Холбооны дэмжлэгтэй Ливийн эргийн хамгаалалтынхан буусны дараа олон мянган хүн хүчээр сураггүй болсон бөгөөд дор хаяж 2839 хүнийг албадан гаргаж, Чад, Египет, Судан улстай хиллэдэг хуурай газрын хил дээр үлдэжээ. Йеменд Хутхи

де-факто эрх баригчид олон зуун цагаач эрэгтэй, эмэгтэй, хүүхдүүд болох голдуу Этиоп, Сомали иргэдийг шаардлага хангахгүй нөхцөлд тодорхойгүй хугацаагаар саатуулжээ. 3-р сард өлсгөлөн зарласны хариуд 350 цагаач амьдардаг барилга руу эрх баригчид пуужингаар харвасны улмаас гал түймэр дэгдэж, 46 эрэгтэй хоригдол амиа алдсан юм. Өнгөрсөн 6-р сард АНЭУ дор хаяж 375 африк цагаач ажилчдыг үндэслэлгүйгээр саатуулж, зургаан долоо хоног хүртэл хүнд нөхцөлд гадаад ертөнцөөс тусгаарлаж, бүх эд хөрөнгийг нь хурааж, эцэст нь албадан гаргажээ. Сирийн засгийн газар 2017-2021 оны хооронд тус улсад буцаж ирсэн дүрвэгсэд, тэр дундаа хүүхдүүдийг үндэслэлгүйгээр баривчилж, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бүс харьцаж, түүний дотор хүчиндэх болон бусад бэлгийн хүчирхийлэл үйлдэж, мөн хүчээр сураггүй алга болгож байна.

Катар улсад эрх баригчид цагаач ажилчдын үхлийг зохих ёсоор шалгахгүй байна. Тус улсад ирэхээсээ өмнө эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байсан ч сүүлийн арван жилийн хугацаанд тэднээс олон мянга нь гэнэтийн бөгөөд санамсаргүй байдлаар нас баржээ. Нас барсан шалтгааныг хийж байсан ажилтай нь холбоотой эсэх талаар үнэлгээ хийхэд саад учруулсны улмаас ар гэрийнхэн нь ажил олгогч буюу эрх баригчдаас нөхөн төлбөр авах боломжгүй болжээ. Египетэд эрх баригчид зохих дүрэм журмыг мөрдөлгүйгээр, орогнол хүсэх боломж олгохгүйгээр 40 Эритрейчүүдийг эх нутаг руу нь албадан буцаажээ.

Ливи, Сири, Иракт хэдэн арван мянган дотоодын шилжин суурьшигчид эх нутагт нь үүссэн аюултай байдал, сөрөг арга хэмжээ авахаас эмээсний улмаас эсвэл зайлшгүй шаардлагатай үйлчилгээ байхгүйн улмаас гэртээ буцаж очиж чадаагүй байна. Тэд Ковид-19 вакцин, боловсрол, орон сууц, ажлын байр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад нэмэлт саад бэрхшээлтэй тулгарсан. Иракийн засгийн газар оны эхээр дотооддоо шилжин суурьшигчдад зориулсан бараг бүх хуаранг хаах гэсэн оролдлого нь олон мянган хүнийг хоёрдох удаагаа шилжин суурьшихад хүргэх буюу орон гэргүй болгов.

АЖИЛЧДЫН ЭРХ

Бүс нутгийн эрх баригчид бага цалинтай ажилчдыг ажлын байр, цалин бууралт, тэр дундаа цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөнөөс хамгаалж чадаагүй. Мөн засгийн газрууд ажилчдын ажил хаях эрхийг нухчин дарч, ажил хаялтад оролцсоны улмаас шударга бусаар халагдсан ажилчдыг хамгаалж чадсангүй. Египетийн эрх баригчид ажилчдыг үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө, эсхүл өөрөөр сэтгэсэн гэх үндэслэлээр шийтгэсээр байна. Шинэ хууль тогтоомжоор “террористуудын жагсаалтад” орсон төрийн албан хаагчдыг ажлаас нь шууд халах боломжийг олгосон бол төрийн байгууллагын ажилтныг “улс төрийн үзэл бодлоо олон нийтэд илэрхийлсэн” хэргээр нөхөн олговоргүйгээр халахыг шүүхээс зөвшөөрсөн. Цагаач ажилчдын хамгаалалтыг сайжруулах шинэчлэлийг хэд хэдэн оронд, ялангуяа ажиллах хүчний маш өндөр хувийг эзэлдэг Персийн булангийн орнуудад зарласан байна.

ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИДЫН ЭРХ

Бүс нутаг даяар эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл эрүүгийн эрх зүйн тогтолцоогоор ихэнхдээ шийтгэл хүлээлгүй өнгөрч байна. Йордан, Ирак, Кувейт, Палестин зэрэг улсад “нэр төрийн” гэгдэх аллага гарсаар байгаа бөгөөд эрх баригчид гэмт этгээдүүдийг яллах арга хэмжээ авч чадахгүй байна. Иранд өргөн барьсан эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлд хохирогч эмэгтэйчүүдэд хамгаалах байр бий болгох зэрэг нааштай заалт багтсан боловч гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг гэж тодорхойлж чадсангүй. Гэр бүлийн хүчин болон хүүхдийн гэрлэлтийг гэмт хэрэгт тооцоогүйгээс гадна гэр бүлийн хүчирхийлэлд хариуцлагаас илүүтэй эвлэрлийг дэмжжээ.

Иран улс дахь хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтүүд нь эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг улам дордуулж, жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл, сайн дурын үргүй болгох үйлчилгээ, бусад холбогдох мэдээллийн хүртээмжийг эрс хязгаарласан байна. Ливийн эрх баригчид эмэгтэйчүүд, охидыг хүчин болон бэлгийн ба жэндэрт суурилсан бусад хүчирхийллээс хамгаалах, түүнчлэн зэвсэгт бүлэглэлүүд болон төрийн бус бусад тоглогчдын аллага, эрүү шүүлт, эрх чөлөөг нь хууль бусаар хасах зэрэг гэмт хэргээс хамгаалж чадаагүй. Йемен улсад Хутхигийн эрх баригчид эмэгтэйчүүд, охидыг баривчлах, хүчээр алга болгох кампанит ажил явуулахдаа Хутхигийн хэрэгжүүлдэг жэндэрийн хэм хэмжээг эсэргүүцэж буй хүмүүсийг онилсон байна.

Бүс нутгийн хэмжээнд эмэгтэйчүүд гэрлэлт, гэр бүл салалт, хүүхдийн асрамж, өв залгамжлал, түүнчлэн Саудын Араб, Иранд хөдөлмөр эрхлэлт, улс төрийн албан тушаал зэрэг хууль эрх зүйн хувьд ялгаварлан гадуурхалттай тулгарсаар байв. Египетийн хувь хүний эрх зүйн байдлын тухай хуульд оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлт нь эмэгтэйчүүдийн бие даасан байдлыг улам бүр дордуулж, ялгаварлан гадуурхах заалтуудыг хэвээр үлдээсэн аж.

ЛГБТИ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Бүс нутаг даяар ЛГБТИ хүмүүс бэлгийн болон хүйсийн чиг баримжаанд нь үндэслэн баривчлах, яллах, зарим тохиолдолд эрүү шүүлттэй дүйцэхүйц шулуун гэдсээр үзлэг хийлгэх зэрэгтэй тулгардаг. Эрүүгийн шүүхүүд ижил хүйстнүүдийн сайн дурын үндсэн дээрх бэлгийн харьцааг гэмт хэрэгт тооцож, ял оноодог хэвээр байв. Египет улсын нэгэн шүүх дөрвөн эрэгтэйг ижил хүйстний бэлгийн харьцаанд орсон хэмээн буруутгаж, 6-9 жил хүртэл хорих ял оноожээ. Мөн эрх баригчид ЛГБТИ хүмүүсийг төрийн бус тоглогчдын хүчирхийллээс хамгаалж чадаагүй. Иранд өөрийгөө ижил хүйстэн гэж тодорхойлсон нэгэн залууг цэргийн албанаас чөлөөлөх үнэмлэх дээр нь “гажиг” гэж тодорхойлсны дараа бусдад алагджээ. Тунисын хоёр цагдаагийн ажилтан ЛГБТИ идэвхтэн, Тунисын ЛГБТИ хүмүүсийн эрхийг хамгаалах DAMJ бүлгийн толгойлогч Бадр Баабуг үг хэлээр доромжилж, хүчирхийлэн халдахдаа цагдаа нарын эсрэг гомдол гаргаж, “янхнууд болон ижил хүйстнүүдийг өмгөөлж байгаагийнх нь төлөө” өшөө авч байна хэмээн зодсон байна.

Марокко улсын парламент зарим талаар эерэг алхам хийж хүйсийг хожим нь өөрчлөх боломжтой бөгөөд трансжэндэр хүмүүст хүйсээ солих боломжийг олгосон хуулийг баталсан.

ШАШНЫ БОЛОН ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХҮҮД

Бүс нутаг даяар шашны цөөнхүүд хуулиар болон практикт ялгаварлан гадуурхалттай тулгарсаар байна. Египет, Иран зэрэг зарим оронд эрх баригчдын зүгээс исламын шашинтай гэж тодорхойлсон эцэг эхээс төрсөн хүмүүсийг өөрсдийн шашин шүтлэгийг тунхагласан эсвэл зөвшөөрөгдөөгүй итгэл үнэмшил илэрхийлсэн хэргээр баривчлан яллаж, үндэслэлгүйгээр саатуулжээ. Египетэд Христийн шашинтан Гергес Самих өөрийн фэйсбүүк дэх Зөнч Мохамедын талаар бичсэн посттой холбоотойгоор мөрдөн байцаалтын ажиллагааг хүлээн цагдан хоригдсон хэвээр байв. Иранд Христийн шашинд дагаар орсон гурван иргэнийг “ариун гэгээн шашин”-ыг доромжлох буюу “өөрийн шашинд урвуулах” хэрэгт таван жил хүртэл хорих ялаар шийтгэх шинэ хуулийн үндэслэлээр шоронд хорих ял оноожээ.

Иран болон Ливийн үндэстний цөөнхийн ажил эрхлэлт, улс төрийн албан тушаал болон боловсрол, эрүүл мэнд зэрэг нэн чухал үйлчилгээ авах эрхийг хязгаарлаж, хэл, соёлын эрхийг нь зөрчин ялгаварлан гадуурхаж байна. Ливийн аль-Куфра дахь Табу оюутнууд зэвсэгт бүлэглэлийн хяналтад байдаг дүүрэгт байрладаг тус хотын цорын ганц их сургуульд элсэн орох боломжгүй болжээ. Иранд үндэстний цөөнх “Бурхны эсрэг дайсагнасан” гэх мэт хууль зүйн үндэслэл бүрхэг заалтаар оногдуулсан цаазаар авах ялд харьцангуй их өртсөн хэвээр байна.

ЗӨВЛӨМЖ


Эрх баригчид өөрсдийн үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг, тэр дундаа вакциныг ялгаварлан гадуурхахгүйгээр хүргэх, эрүүл мэндийн ажилтнуудыг зохих ёсоор хамгаалж, цар тахалтай тэмцэх зорилгоор тогтоосон аливаа хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай бөгөөд тохирсон хэмжээтэй байх ёстой.

Засгийн газар үзэл бодлоо тайван замаар илэрхийлэхтэй холбоотой бүх мөрдөн байцаалт, яллах ажиллагааг зогсоож, «доромжлол»-ыг гэмт хэрэгт тооцдог субъектив заалтуудыг хүчингүй болгож, гүтгэлгийг гэмт хэрэгт тооцохоос татгалзах ёстой. Мөн хүний эрх хамгаалагчдыг үндэслэлгүйгээр баривчлах, яллах, заналхийлэх халдлага дарамтаас ангид ажиллах боломжийг хангах замаар хүний эрхийг хүндэтгэж, хамгаалах үүргээ ухамсарлах ёстой.

Засгийн газрууд дүрвэгсэд болон цагаачдын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийг таслан зогсоох ёстой. Дүрвэгсэд болон цагаачдыг зөвхөн цагаачлалын статуст нь үндэслэн баривчлах, үндэслэлгүйгээр саатуулах явдлыг таслан зогсоож, орогнол хүсэх эрхийг хүндэтгэж, хамгаалах ёстой. Дүрвэгсдийг албадан гаргахыг зогсоож, тэднийг мөрдлөг хавчлагад өртөх эрсдэлтэй тохиолдолд эх орон руу нь буцаахаас хамгаалах ёстой. Засгийн газрууд мөн цагаач ажилчдад, тэр дундаа цагаач гэрийн ажилчдад хөдөлмөрийн хуулийн хамгаалалтыг олгож, кафала системийг халах ёстой.

Зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд олон улсын хүмүүнлэгийн хуулийг мөрдөх, ялангуяа энгийн номхон иргэд болон иргэний дэд бүтцийн эсрэг шууд халдлага, замбараагүй халдлагыг зогсоох ёстой. Бүс нутагт үргэлжилж буй мөргөлдөөний нэгэн адил олон улсын хууль тогтоомжийг зөрчихөд ашиглагдах өндөр эрсдэлтэй тохиолдолд зэвсэг шилжүүлэх явдлыг зогсоох ёстой.

Эрх баригчид хууль сахиулагчдаа галт зэвсэг болон хөнөөл багатай зэвсэг хэрэглэх талаар олон улсын стандартыг мөрдөх явдлыг хангах, хууль бусаар хүч хэрэглэсэн хэргийг мөрдөн шалгаж, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад хариуцлага тооцож, тайван жагсаал цуглаан хийх эрхийг хүндэтгэн сахих ёстой.



www.amnesty.org
www.amnesty.mn

